



Mongolian Marketing
Consulting Group

YOUR
RESEARCH
PARTNER



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ҮНДЭСНИЙ СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХУВИЛБАР № 01



2020.07.09

Захиалагч: Харилцаа холбооны зохицуулах хороо

Гүйцэтгэгч: Эм Эм Си Жи ХХК



ESOMAR²⁰
corporate



ЭМ ЭМ СИ ЖИ ХХК

Зүүн Хүрээ хотхон, 203-р байр, 4 давхар, 14-р хороо
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот,
Монгол Улс
Утас/Факс: 976-77000188
Имэйл: info@mmcg.mn
Вэб сайт: <http://www.mmcg.mn>

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Метро бизнес төв А-блок 5 давхар,
Д.Сүхбаатарын гудамж-13
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033
Утас: (976)-11-304258, 1800-1858
Факс: (976)-11-327720
Имэйл: info@crc.gov.mn
Вэб сайт: <http://www.crc.gov.mn>



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



Mongolian Marketing
Consulting Group

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ҮНДЭСНИЙ СУУРЬ СУДАЛГАА

Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны санхүүжилтээр “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаа”-г зах зээлийн судалгаа, зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи (MMCJ) ХХК хийж гүйцэтгэлээ.

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг олон улсын судалгааны ёс зүйн стандарт болох ESOMAR-ын код болон Маркетинг, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа үйлчилгээний (ISO 20252:2019) стандартын дагуу эцэг, эх болон 13-18 настай хүүхдийг төлөөлүүлэн нийслэл Улаанбаатар хотын 7 дүүрэг, 6 аймгийн хэмжээнд 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 07 дүгээр сарын 09-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн болно.

Энд дурдагдаж буй судалгааны үр дүн нь эцэг, эх болон хүүхдүүдийн мэдлэг, хандлага, санал бодол дээр шууд үндэслэгдсэн гэдгийг анхаарна уу.

АГУУЛГА

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	7
НЭГ. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	8
1.1 ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА	9
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО	9
ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	10
1.2 СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ АРГА ЗҮЙ	11
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1: 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН СУДАЛГАА	12
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2: ЭЦЭГ, ЭХИЙН СУДАЛГАА	14
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3: МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА	16
1.3 СУДАЛГААНЫ БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	17
1.4 СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЕ ШАТУУД	18
ХОЁР. СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ	31
СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ	32
ГУРАВ. СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН	36
3.1 ХҮҮХЭД БУЮУ 13-18 НАСНЫХАН	37
1. 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ЦАХИМ ОРЧНЫ ХЭРЭГЛЭЭ	37
2. 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ФЕЙСБҮҮКИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ОНЦЛОГ	44
3. 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ЦАХИМ ОРЧИН ДАХ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ	49
4. 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ЦАХИМ ОРЧНЫ ХАЛДЛАГАД ӨРТӨЖ БАЙСАН БАЙДАЛ	56
5. 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ АРГА ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ БАЙДАЛ БОЛОН МЭДЭЭЛЭЛ АВДАГ СУВАГ	64
3.2 ЭЦЭГ, ЭХЧҮҮД БУЮУ 7-18 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ГЭР БҮЛ	76
1. ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ЦАХИМ ОРЧНЫ ХЭРЭГЛЭЭ	76
2. 7-12 НАСТАЙ ХҮҮХДИЙН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ	83
3. ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ЦАХИМ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ	89
4. ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ЦАХИМ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ТУРШЛАГА, ХАНДЛАГА БОЛОН МЭДЭЭЛЭЛ АВДАГ СУВАГ	98



3.3 ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ	108
1. ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХАНД ЗОРИУЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	108
2. ЭЦЭГ, ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	113
3. КАМПАНИТ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БОЛОХ БҮТЭЭЛЧ АЖЛУУД	115
4. ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БОЛОН ҮҮРЭН ОПЕРАТОР КОМПАНИУДЫН ХИЙЖ БОЛОХ АЖЛУУД	116
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	117
ХАВСРАЛТ 1: СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ	123
ХАВСРАЛТ 2: 13-18 НАСНЫ ХҮҮХДЭЭС АВАХ АСУУЛГА	126
ХАВСРАЛТ 3: 7-18 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ, ЭХЭЭС АВАХ АСУУЛГА	136

I ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Интернэтэд ордог давтамж	38
График 2. Интернэт ашиглаж эхэлсэн нас, хүйс, байршил, сууцны нөхцөлөөр.....	39
График 3. Интернэтэд ордог төхөөрөмж, насны бүлэг, байршил, сууцны төрлөөр	40
График 4. Аав, ээжийнхээ эзгүйд интернэтэд орох байдал, суралцаж буй ангир.....	41
График 5. Интернэт ороод хийдэг зүйлс, хүйсээр	42
График 6. Ашигладаг сошиал медиа, хүйс, насны бүлэг, байршил, сууцны нөхцөлөөр.....	43
График 7. Өдөрт интернэт орчинд зарцуулдаг цаг.....	43
График 8. Фейсбүүкийн хаягийн тоо.....	45
График 9. Фейсбүүкийн илүү хаягаа ашигладаг зорилго	46
График 10. Фейсбүүкийн найзын хүсэлт хүлээн авах хандлага болон танихгүй хүнтэй найз болсон байдал, хүйс, насны бүлэг, байршлаар	46
График 11. Фейсбүүкийн шинэ найзтай болоход чухалчилж хардаг зүйлс.....	47
График 12. Интернэт орчинд бүртгэл хийхдээ оруулдаг хувийн мэдээлэл, хүйсээр	48
График 13. Интернэтийн эрх өгье гэвэл хувийн мэдээллээ бусдад өгөх эсэх.....	48
График 14. Интернэтэд орох нь хэр зэрэг аюултай гэж үзэж байгаа болох, хүйс, насны бүлгээр.....	50
График 15. Интернэт орчин ямар аюул учруулна гэж бодож байгаа болох.....	51
График 16. Найзуудаасаа ирсэн холбоос бүхий мэдээллийг дарж үзэх байдал, хүйсээр	52
График 17. Хамгийн их эрсдэл учруулна гэж бодож байгаа зүйлс, хүйсээр.....	53
График 18. Цахим орчны гэмт хэрэг, эрсдэлийн талаар сонсож байсан байдал	54
График 19. Хуурамч хаягийг таних аргуудыг ашиглаж буй байдал,	55
График 20. Цахим орчны халдлагад найзууд нь өртөж байсан тохиолдол	61
График 21. Хэн цахим дарамт хийдэг болох, хүйс, насны бүлэг, байршил, сууцны төрлөөр ..	62
График 22. Цахим орчны талаарх хүүхдүүдийн хандлага	63
График 23. Цахим дарамтад өртсөн тохиолдолд эцэг, эхдээ хэлдэг эсэх.....	66
График 24. Цахим халдлагад найз чинь өртөж болзошгүй гэж санаа зовж байгаа тохиолдолд хэнд хандах талаар, хүйсээр	67
График 25. Цахим орчинд өөрийг илүү аюулгүй болгох зорилгоор хийж байсан зүйлс, хүйсээр	68
График 26. Сошиал орчинд пост оруулахдаа хийдэг тохиргоо, насны бүлгээр.....	69
График 27. Сөрөг сэтгэгдэлд үзүүлдэг хариу үйлдэл, хүйсээр	69
График 28. Цахим орчинд өөрийгөө хамгаалах үйлдлүүдийг хийдэг байдал, хүйсээр	71
График 29. Цахим орчинд олон цагийг зарцуулснаар учирч болох эрсдэл.....	72
График 30. Интернэтийн хэрэглээний талаарх мэдээлэл авдаг эх үүсвэр, хүйсээр	73
График 31. Хамгийн их мэдээлэл авдаг хэрэгсэл, суваг, хүйсээр	74
График 32. Ekids.mn, harptwebs.mn рүү орж нийтлэл уншиж байсан байдал, насны бүлгээр ..	75
График 33. Өрхийн хэрэглэдэг интернэт, байршлаар	77
График 34. Эцэг, эхчүүдийн сошиал медиа ашигладаг цаг, хүйсээр	79
График 35. Эцэг, эхчүүдийн сошиал медиа ашигладаг цаг, байршлаар	80
График 36. Хүүхдээ саатуулах зорилгоор гар утсаа өгдөг эсэх, хүйсээр.....	80
График 37. Хэдэн настай хүүхдээ саатуулах зорилгоор гар утсаа өгдөг болох	81
График 38. Эцэг, эхийнхээ гар утсыг аваад хүүхдүүдийн хийдэг үйлдэл	81
График 39. Хүүхдийн интернэт хэрэглэж эхэлсэн нас, байршлаар.....	82
График 40. Хүүхдэдээ ухаалаг утас авч өгдөг нас, байршлаар	82
График 41. 7-12 настай хүүхдэд нь интернэт орох боломжтой төхөөрөмж байгаа эсэх, байршлаар.....	84
График 42. Гар утсыг нь хүүхэд ашиглах боломжтой байдаг эсэх, хүйсээр	84

График 43. Гэр бүлийн дундын хэрэглээний таблеттай эсэх, уг таблетыг хүүхэд хяналтгүйгээр ашиглах боломжтой эсэх, байршлаар	85
График 44. Гэр бүлийн дундын хэрэглээний таблетад бүртгэлтэй байдаг аккаунт	85
График 45. Гэр бүлийн дундын хэрэглээний компьютер байдаг эсэх, байршлаар	85
График 46. Гэр бүлийн дундын хэрэглээний компьютерын гол хэрэглэгч, байршлаар	86
График 47. 7-12 насны хүүхдийн интернэт, фейсбүүкийн хэрэглээ.....	86
График 48. 7-12 насны хүүхдийн интернэт ордог давтамж, сууцны төрлөөр.....	87
График 49. 7-12 насны хүүхдүүдийн ашигладаг сошиал медиа, байршлаар.....	88
График 50. Аав, ээж хүүхдүүддээ фейсбүүк хаяг нээж өгдөг эсэх, байршлаар	90
График 51. Хэдэн настай хүүхдэдээ фейсбүүк хаяг нээж эсэх, байршлаар	90
График 52. 13 болон түүнээс дээш настай хүүхэд фейсбүүк, инстаграм ашиглах эрхтэй болдог гэдгийг мэддэг эсэх, хүйс, байршлаар	91
График 53. Хүүхдийнхээ цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавьдаг эсэх, хүйсээр	91
График 54. Цахим орчны хүүхдийн хүмүүжилд үзүүлж буй нөлөө, хүйсээр.....	92
График 55. Хүүхдийнхээ цахим орчин дахь найзуудыг мэддэг эсэх, хүйсээр	92
График 56. Хүүхдийнхээ цахим орчин дахь найзуудыг мэдэхийг хүсдэг эсэх, хүйсээр	93
График 57. Цахим орчин нь хүүхдэд аюул хэр зэрэг аюултай гэж үзэж байгаа болох	93
График 58. Эцэг, эхчүүдийн цахим орчны аюулыг төсөөлж буй байдал.....	94
График 59. Хүүхдийг цахим, интернэт орчинд хамгаалдаг хэлбэр	94
График 60. Хүүхдүүддээ зөвлөгөө өгч байсан байдал	95
График 61. Сонсож байсан цахим гэмт хэргүүд.....	96
График 62. Интернэт орчноор дамжуулан үйлдсэн гэмт хэргийн талаар сонсож байсан эсэх	97
График 63. Цахим халдлагад өртөх өндөр эрсдэлтэй нас	97
График 64. Хүүхдээ цахим орчны халдлагад өртөж байсан гэж бодож байгаа эсэх.....	99
График 65. Хүүхдүүд нь цахим халдлагад өртөж байсан талаараа хэлж байсан эсэх	100
График 66. Гэрийн компьютер, таблет, гар утас зэрэгт цахим орчноос хамгаалах программ, арга зэргийг ашигладаг эсэх	101
График 67. Хүүхдийнхээ гар утасны хэрэглээг хянадаг эсэх	101
График 68. Хэрхэн хүүхдийнхээ гар утсыг хянадаг болох.....	102
График 69. Насанд хүрээгүй хүүхдийн цахим орчинд хийсэн үйлдэлд эцэг эх нь хариуцлага хүлээдгийг мэддэг эсэх.....	103
График 70. Хүүхдэд нь интернэтээр худалдан авалт хийх боломжтой банкны карт байгаа эсэх	103
График 71. Интернэтээр худалдан авалт хийх боломжтой банкны картыг хянадаг эсэх.....	104
График 72. Цахим сүлжээнд олон цагийг зарцуулснаар бий болох сөрөг үр дагавар, эцэг, эхийн бодлоор	104
График 73. Цахим орчинд хүүхдүүд өөрийг хамгаалах үүднээс хийх ёстой үйлдлүүд	105
График 74. Эцэг, эхчүүдийн интернэтийн хор хөнөөл, дарамт, зохистой хэрэглээний талаарх мэдээлэл авдаг эх үүсвэр	106
График 75. Ekids.mn, happywebs.mn сайт руу орж байсан эсэх	106

I ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: 13-18 насны хүүхдийн судалгааны түүврийн хэмжээ, байршлаар хуваарилсан байдал.....	13
Хүснэгт 2: Эцэг, эхийн судалгааны түүврийн хэмжээ, байршлаар хуваарилсан байдал	15
Хүснэгт 3: Судалгааны зохион байгуулалтын үе шатууд.....	18
Хүснэгт 4: Мэдээлэл цуглуулалтад ашигласан техник хэрэгсэл	24
Хүснэгт 5: Интернэтэд ордог давтамж, хүйс, насны бүлэг, сууцны нөхцөлөөр	38
Хүснэгт 6: Интернэтэд ордог байршил, хүйс, насны бүлэг, сууцны төрлөөр.....	40
Хүснэгт 7: Интернэтэд зарцуулдаг дундаж хугацаа, минутаар, ялгаатай бүлгээр	44
Хүснэгт 8: Цахим орчны халдлагад өртөж байсан байдал, хүйс, насны бүлгээр	58
Хүснэгт 9: Цахим орчны халдлагад өртөж байсан байдал, байршил, сууцны төрлөөр.....	60
Хүснэгт 10: Цахим орчны халдлагад найзууд нь өртөж байсан тоо, хүйс, насны бүлэг, байршлаар.....	61
Хүснэгт 11: Цахим дарамт хийх хандлага болон мэдээлэл бусадтай хуваалцах хандлага	70
Хүснэгт 12: Интернэтийн хэрэглээний талаарх мэдээлэл авдаг эх үүсвэр, насны бүлгээр, байршлаар.....	73
Хүснэгт 13: Эцэг, эхчүүдийн сошиал медиа хэрэглээ, насны бүлгээр, байршлаар	78
Хүснэгт 14: Интернэт орчинд нэг өдөрт зарцуулдаг хугацаа, хүйс, байршлаар	78
Хүснэгт 15: Эцэг, эхчүүдийн интернэтэд зарцуулдаг дундаж хугацаа, минутаар, ялгаатай бүлгээр.....	79
Хүснэгт 16: 7-12 насны хүүхдүүдийн өдөрт интернэт орчинд зарцуулдаг цаг, байршлаар.....	87
Хүснэгт 17: 7-12 насны хүүхдүүдийн интернэтэд зарцуулдаг дундаж хугацаа, минутаар, байршил, сууцны төрлөөр	87
Хүснэгт 18: Хүүхдийн гар утасны хэрэглээг хянахад туслах аппликэйшийн талаар мэддэг эсэх	102
Хүснэгт 19: Цахим орчны талаарх эцэг, эхчүүдийн хандлага	107
Хүснэгт 20: 13-18 насны хүүхдийн судалгаанд оролцогчдын мэдээлэл	123
Хүснэгт 21: 7-18 насны хүүхэдтэй эцэг, эхийн судалгаанд оролцогчдын мэдээлэл	124

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Судалгааны багийн зохион байгуулалтын бүтэц	17
Зураг 2: Таблетаар судалгааны мэдээлэл цуглуулалт хийх программын харагдах байдал.....	20
Зураг 3: Судалгааны суулга, зааврыг боловсруулсан дараалал	21
Зураг 4: Судалгааны аргазүйн сургалт зохион байгуулж буй байдал.....	22
Зураг 5: Судалгааны мэдээлэл цуглуулж буй байдал	25
Зураг 6: 13-16 насны хүүхдээс судалгаа авахдаа эцэг, эхээс нь зөвшөөрөл авсан хуудас.....	26
Зураг 7: Судалгаа авсан GPS цэгийн байрлал	27
Зураг 8: Real time чанарын хяналт хийсэн хянах самбарын харагдах байдал.....	28
Зураг 9: Утсаар хяналт хийсэн протоколыг хөтөлсөн байдал.....	29
Зураг 10: Алдааны протоколыг хөтөлсөн байдал.....	30



НЭГ. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

2019 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсад нийт 3.37 сая интернэт хэрэглэгч байгаагийн 91% нь буюу 3'072'775 нь ухаалаг гар утас, төхөөрөмжөөр хөдөлгөөнт үүрэн холбооны сүлжээ ашиглан интернэтэд холбогдож байна. Эм Эм Си Жи компанийн сүүлийн 6 жилийн турш хийж байгаа “Үндэсний медиа хэрэглээний судалгаа”-аас харахад нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн тоо 2014 оноос хойш маш өндөр өсөлттэй байгаа ба нөгөө талдаа уламжлалт медиа хэрэглээнээс телевиз үзэлт буурсаар байна. Нийт интернэт хэрэглэгчдийг насаар нь ангилж харвал 15-19 насныхны 99% нь сүүлийн 12 сарын хугацаанд ямар нэгэн байдлаар интернэтэд холбогдсон байгаа нь хамгийн өндөр хувьтай үзүүлэлт ба тэдний нийт интернэт хэрэглээний ихэнх хувийг нийгмийн сүлжээний интернэт хэрэглээ эзэлж байна. Ялангуяа “Gen Z” залуу үеийнхэн өдөрт 7-9 цаг буюу өдрийн гуравны нэгийг сошиал сүлжээнд өнгөрүүлж байна. Улмаар өсвөр насныхан өөрийгөө хамгаалах мэдлэг, мэдээлэл хангалтгүй байгаагаас цахим орчинд зүй бус үйлдэл хийх, гэмт хэргийн золиос болох үүнээс улбаалан сэтгэл зүй, эд материал, эрүүл мэнд, амь насаараа хохирох эрсдэл ихээр бий болоод байна. Нөгөөтээгүүр цахим орчинд хүүхэд багачуудад тохиолдож болох эрсдэл, аюулын талаар хэлж зөвлөх ёстой эцэг эхчүүдийн мэдлэг боловсрол, мөн тэдэнд тавих хяналт маш сул байна. Тиймээс цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаа хийж, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлага тулгараад байна.

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО

Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд бид дараах зорилгыг тавин ажилласан:

- Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот болон баруун, зүүн, төв, говийн бүсийн тус бүр 1 аймаг, нийт 6 аймгийн 13-18 насны хүүхдийн интернэтийн зохистой хэрэглээ болон цахим орчинд өөрийгөө дарамт шахалт, доромжлол, гэмт хэрэгт өртөх эрсдэлээс хэрхэн хамгаалах талаарх мэдлэг, хандлага, дадлыг судалж, энэ талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлэхэд авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот болон баруун, зүүн, төв, говийн бүсийн тус бүр 1 аймаг, нийт 6 аймгийн 7-18 насны хүүхэдтэй эцэг, эхчүүдийн хүүхдээ цахим орчны дарамт шахалт, доромжлол, гэмт хэрэгт өртөх эрсдэлээс хэрхэн хамгаалах талаарх мэдлэг, хандлага, дадлыг судалж, энэ талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлэхэд авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах

Эм Эм Си Жи компанийн зүгээс зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчид тавигдах шаардлага, ажлын даалгавар, судалгааны зорилго, ач холбогдолтой нарийвчлан танилцаж, зөвлөх үйлчилгээнд хэрэглэгддэг олон улсын нийтлэг онол, арга зүй, тэргүүн туршлага, шинжлэх ухааны аргачлалд тулгуурлан боловсруулсан өөрийн компанид мөрдөгдөж буй арга зүй, стандарт дүрэм журамд үндэслэн зөвлөх үйлчилгээг гүйцэтгэсэн болно. Судалгааны тайланг боловсруулахдаа дараах зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

1. Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд хийгдэх ажлын даалгаварт дурдсан зорилго, тодруулах зүйлс, хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрийг нэг бүрчлэн, нарийвчлан авч үзсэн байх;

2. Санал болгож буй аргачлал арга зүй нь олон улсын болон үндэсний түвшинд хэрэглэгдэж буй нийтлэг арга зүй, тэргүүн туршлагад үндэслэсэн байх, судалгааны үе шат тус бүрд ёс зүйн болон мэргэжлийн стандартуудыг дагаж мөрдөх. Судалгааг хэрэгжүүлэхдээ судалгааны ёс зүйн олон улсын ЭЗОМАР-ын код болон "Зах зээлийн, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа: Нэр томъёоны тайлбар толь, үйлчилгээнд тавих шаардлага" MNS ISO 20252:2019 стандартыг дагаж мөрдсөн байх;
3. Шинжлэх ухааны болон практикийн үндэслэл, нотолгоотой, ач холбогдолтой арга зүйг сонгосон байх;
4. Асуудлыг олон талаас нь тэнцвэртэй байдлаар бодит нотолгоо мэдээлэлд үндэслэн үнэлж дүгнэх;
5. Аргачлал, арга зүй, зохион байгуулалт нь эдийн засгийн болон ажлын эцсийн үр дүнгийн хувьд үр ашигтай байх зэрэг болно.

ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Уг зөвлөх үйлчилгээний ажлыг судалгаа шинжилгээний "Эм Эм Си Жи" ХХК 2020 оны 05 сарын 12-аас 07 сарын 09-ны хооронд хийж гүйцэтгэсэн ба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Судалгааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрээр аргачлал, арга зүйг нарийвчлан боловсруулсан.
2. Судалгааны түүврийн дизайныг боловсруулж, дизайны дагуу түүвэрлэлтийг хийсэн.
3. Тодорхойлсон аргачлал, арга зүйд нийцүүлэн судалгааны асуулгыг боловсруулсан. Судалгааны асуулгын хуудаст захиалагчийн саналыг тусгаж, судалгааны хүрээнд холбогдох тараах материалуудыг бэлтгэсэн.
4. Судалгааны мэдээлэл цуглуулагч нарыг бүрдүүлэх, анхан шатны сонгон шалгаруулалтыг хийсэн. Судалгааны төсөлд оролцох мэдээлэл цуглуулагчид, багийн ахлагчдыг сургалтад хамруулах, сургалтыг зохион байгуулсан.
5. Туршилтын судалгааг зохион байгуулах: Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулсан.
6. Батлагдсан асуулгын маягтаар Улаанбаатар хотын 7 дүүрэг болон 6 аймгийн хэмжээнд мэдээллийг цуглуулж, цуглуулсан мэдээллийн чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.
7. Цуглуулсан мэдээллээр мэдээллийн сан бүрдүүлсэн.
8. Судалгааны бэлтгэл ажил, мэдээлэл цуглуулалтын явцын мэдээг захиалагч талд хүргүүлсэн. Мөн судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, санал зөвлөмжийг багтаасан судалгааны тайланг бэлтгэж хүлээлгэн өгсөн.
9. Мэдээллийг цахим байдлаар архивлан захиалагчид хүлээлгэн өгөх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үе шат тус бүрд баримталсан зарчим, арга зүйг дараагийн бүлгүүдэд танилцуулав.

1.2 СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ АРГА ЗҮЙ

Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаа хий, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг дараах аргачлал, арга зүйн дагуу гүйцэтгэсэн.

Судалгааны хүрээнд дараах 4 төрлийн ажлыг хийсэн. Үүнд:

1. **БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1 – 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН СУДАЛГАА:** Энэ хүрээнд Улаанбаатар хот, 6 аймгийг хамруулсан ба цахим орчны хэрэглээ, цахим орчны дарамт шахалт, доромжлол, гэмт хэрэгт өртөх эрсдэлээс хэрхэн хамгаалах талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлоход чиглэгдсэн.
2. **БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2 – ЭЦЭГ, ЭХИЙН СУДАЛГАА:** Энэ хүрээнд Улаанбаатар хот, 6 аймгийг хамруулсан ба 7-18 насны хүүхэдтэй эцэг, эхчүүдийн цахим орчны дарамт шахалт, доромжлол, гэмт хэрэгт өртөх эрсдэлээс өөрийн хүүхдээ хэрхэн хамгаалах талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлоход чиглэгдсэн.
3. **БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3 – МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА:** Цахим орчин дах хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг 7 мэргэжилтэнтэй ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан. Ингэхдээ цахим орчин дах хүүхэд хамгааллын чиглэлээр цаашид хийж хэрэгжүүлбэл зохих ажлууд, хүндрэл бэрхшээл зэргийг тодорхойлоход чиглэгдсэн.
4. **БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 4 – ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ:** Хүүхэд болон эцэг, эхийн судалгааны үр дүнд үндэслэж, цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, энэ талаарх мэдлэг мэдээллийг зорилтот бүлэгт хүргэхэд авах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахад чиглэгдсэн.

Судалгааны ажлыг үр дүнтэй явуулахын тулд судалгааны аргазүйг оновчтой боловсруулах нь чухал байдаг. Иймээс бид судалгааны бүрэлдэхүүн хэсэг бүрийн аргазүйн хүрээнд судалгааны зорилго, зорилт, түүвэрлэлт, судалгаанаас тодруулах асуудал зэргийг дараах байдлаар тодорхойлж гаргасан.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1: 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН СУДАЛГАА

ЗОРИЛГО

Хүүхэд, өсвөр насныхан буюу 13-18 насныхны цахим орчны хэрэглээ, цахим орчны дарамт шахалт, доромжлол, гэмт хэрэгт өртөх эрсдэлээс хэрхэн хамгаалах талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлоход чиглэгдсэн.

АРГАЗҮЙ

Судалгааны нэгж буюу түүврийн нэгж нь 13-18 насны хүүхдүүд байсан. Энэ шатанд хамрагдсан нийт судалгаанд оролцогчдоос судалгааны батлагдсан санал асуулгыг авсан. Судалгааны батлагдсан асуулгын маягтыг хавсралтаас харна уу.

Аливаа асуудлаар өөрчлөлт хийхэд эхлээд иргэдийг мэдлэгтэй болгоно (Knowledge Building), дараа нь хандлагыг бий болгоно (Attitude Formation), эцэст нь байнгын үйлдэл болгож (Practice) - зан төлөвийн өөрчлөлтийг бий болгодог. Иймээс зан төлөвийн өөрчлөлтийг бий болгох гэж байгаа тул KAP буюу Мэдлэг-Хандлага-Туршлагын судалгаа нь гол арга зүйн үндэслэл болдог. Тиймээс судалгааны ажлыг олон улсад өргөн ашиглагддаг **KAP (Knowledge, Attitude and Practice) – Мэдлэг, Хандлага, Туршлага аргазүйг** ашигласан. Уг аргазүйг 1960 оноос хойш олон улсын хөгжлийн байгууллагууд эрүүл мэнд, гэр бүл, хүүхэд хамгаалах хөтөлбөрийн үнэлгээ, судалгааг хийхэд ашиглаж эхэлсэн байдаг.

KAP (Knowledge, Attitude and Practice) аргазүйг ашиглаж дараах **үндсэн 3 зүйлийг судалсан. Үүнд:**

1. **Knowledge - Мэдлэг** – 13-18 насны хүүхдүүд цахим орчинд өөрийгөө хамгаалах мэдлэг, ойлголтын түвшнийг хэмжсэн.
2. **Attitude – Хандлага** – Ямар хандлагатай байна вэ? Жишээ нь "Цахим орчинд өөрийн хувийн мэдээллээ байршуулж болохгүй", "Цахим орчинд танихгүй хүндтэй танилцаж, улмаар уулзаж болохгүй" гэх мэт хандлагуудтай санал нийлж байгаа эсэхийг тодорхойлсон
3. **Practice – Туршлага** – Хэдийгээр цахим орчин нь эрсдэл дагуулж болзошгүй гэдгийг мэдэж байгаа боловч өдөр тутмын хэвшил болгож чадаж байгаа эсэх, цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах аргыг мэдэж байгаа зэргийг тодорхойлсон.

ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг, Налайх дүүрэг болон Дархан, Эрдэнэт хот болон баруун, зүүн, төв, говийн бүсийн тус бүр 1 аймгийн төвийг сонгон авч, нүүр тулсан ярилцлагын аргаар хийж гүйцэтгэсэн. Бид судалгаанд оролцогчдыг сонгон шалгаруулахдаа дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн. Үүнд:

- Тухайн сум, дүүрэгт амьдардаг байх;
- 13-18 настай байх;
- Хэрэв тухайн өрх нь 13-18 настай 1-ээс олон хүүхэд байгаа тохиолдолд зөвхөн 1 хүүхдээс судалгааг авах;
- Өөрийгөө илэрхийлэх, үзэл бодлоо хуваалцах чадвартай байх

ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ БУЮУ СУДАЛГААНД ОРОЛЦОХ НЭГЖИЙН ТОО

Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр 2018 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад 7-18 насны 636,403 хүүхэд байна. Эдгээр хүүхдүүдийн 51% нь буюу 324,602 хүүхэд нь эрэгтэй, 49% нь буюу 311,801 хүүхэд нь эмэгтэй байна. Уг тоонд үндэслэн 95%-ийн итгэх магадлал, 3%-ийн алдааны түвшинд судалгааны түүврийн хэмжээг тооцоолоход 700 хүүхдийг хамруулахаар байна. Дээрх шаардлагыг хангасан 1 судалгаанд оролцогчийг олохын тулд ойролцоогоор 2-3 хүүхэдтэй уулзаж байсан ба шалгуурт тэнцсэн 705 хүүхдээс судалгаа авахын тулд ойролцоогоор 2000 гаруй хүүхдүүдтэй уулзсан.

Хүснэгт 1: 13-18 насны хүүхдийн судалгааны түүврийн хэмжээ, байршлаар хуваарилсан байдал

№	Хот/Аймаг	Дүүрэг/Сум	Түүврийн хэмжээ
1	Улаанбаатар	Баянгол	47
2	Улаанбаатар	Баянзүрх	62
3	Улаанбаатар	Налайх	18
4	Улаанбаатар	Сонгинохайрхан	66
5	Улаанбаатар	Сүхбаатар	33
6	Улаанбаатар	Хан-Уул	38
7	Улаанбаатар	Чингэлтэй	39
8	Ховд	Жаргалант	66
9	Дорнод	Хэрлэн	64
10	Дархан-Уул	Дархан	70
11	Орхон	Баян-Өндөр	68
12	Өвөрхангай	Арвайхээр	67
13	Төв	Зуунмод	67
Нийт			705

Ухаалаг төхөөрөмж болох таблет /CAPI/ ашиглаж мэдээлэл цуглуулалт хийсэн судалгаанд хамрагдах хүүхдийн тоог тухайн байршлын нийт хүүхдийн тоо болон илтгэх чадварыг харгалзан тооцоолсон. Судалгааны түүвэрлэлтийг энгийн санамсаргүй түүврийн аргаар хийсэн. Судалгаанд гэр хороолол болон орон сууцны хороололд амьдардаг өрхүүд хамрагдах ба нэг өрхөөс нэг хүүхдээс судалгааг авсан. Оролцогчийн хүйс нь тэнцвэртэй буюу 49.5% нь эрэгтэй, 50.5% нь эмэгтэй байлаа. Насны хувьд 30.4% нь 13-14 настай, 34.3% нь 15-16 настай, 35.3% нь 17-18 настай хүүхдүүдийг судалгаанд хамруулсан. Амьдардаг сууцны хувьд 40.4% нь орон сууцны хороололд амьдардаг байсан бол 37.6% нь гэр хорооллын хашаа байшинд, 20.3% нь монгол гэрт амьдардаг хүүхдүүд судалгаанд хамрагджээ.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2: ЭЦЭГ, ЭХИЙН СУДАЛГАА

ЗОРИЛГО

Эцэг, эх буюу 7-18 насны хүүхэдтэй эцэг, эхчүүдийн цахим орчны дарамт шахалт, доромжлол, гэмт хэрэгт өртөх эрсдэлээс өөрийн хүүхдээ хэрхэн хамгаалах талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлоход чиглэгдсэн.

АРГАЗҮЙ

Судалгааны нэгж буюу түүврийн нэгж нь 7-18 насны хүүхэдтэй эцэг, эх байсан 13-18 насны хүүхдүүдийн судалгааны арга зүйтэй адил буюу КАР (Мэдлэг-Хандлага-Туршлага) арга зүйг ашигласан. Энэ шатанд хамрагдсан нийт судалгаанд оролцогчдоос судалгааны батлагдсан санал асуулгыг авсан. Судалгааны батлагдсан асуулгын маягтыг хавсралтаас харна уу.

ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг, Налайх дүүрэг болон Дархан, Эрдэнэт хот, баруун, зүүн, төв, говийн бүсийн тус бүр 1 аймгийн төвийг сонгон авч, нүүр тулсан ярилцлагын аргаар хийж гүйцэтгэсэн. Бид судалгаанд оролцогчдыг сонгон шалгаруулахдаа дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн. Үүнд:

- Тухайн сум, дүүрэгт амьдардаг байх;
- 7-18 насны хүүхэдтэй байх;
- Өөрийгөө илэрхийлэх, үзэл бодлоо хуваалцах чадвартай байх

ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ БУЮУ СУДАЛГААНД ОРОЛЦОХ НЭГЖИЙН ТОО

Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр 2018 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад 636,403 хүүхэд байгаа. Харин 7-18 насны хүүхэдтэй өрхийн тоо гэсэн статистик тоон мэдээлэл байхгүй байгаа тул ам бүлийн тоон үндэслэж тооцоолол хийв. 1 өрх дунджаар 3.7 ам бүлтэй гэвэл эцэг, эхээс гадна 1.7 хүүхэд байна гэж үзье. Ингэхэд ойролцоогоор нийт эх олонлог маань $636,403 \div 1.7 = 374,355$ өрх байхаар байна. Уг тоонд үндэслэн судалгаанд хамрагдах эцэг, эхийн тоог 95%-ийн итгэх магадлал, 3%-ийн алдааны түвшинд судалгааны түүврийн хэмжээг тооцоолоход 617 гарсан. Судалгаанд хамруулах эцэг, эх болон түүврийн тархалтыг бодолцон 651 эцэг, эх болгон тодотгол хийлээ. Дээрх шаардлагыг хангасан 1 судалгаанд оролцогчийг олохын тулд ойролцоогоор 3-4 эцэг, эхтэй уулзаж байсан ба шалгуурт тэнцсэн 651 эцэг, эхээс судалгаа авахын тулд ойролцоогоор 2500 орчим хүнтэй уулзсан.

Хүснэгт 2: Эцэг, эхийн судалгааны түүврийн хэмжээ, байршлаар хуваарилсан байдал

№	Хот/Аймаг	Дүүрэг/Сум	Түүврийн хэмжээ
1	Улаанбаатар	Баянгол	40
2	Улаанбаатар	Баянзүрх	65
3	Улаанбаатар	Налайх	15
4	Улаанбаатар	Сонгинохайрхан	74
5	Улаанбаатар	Сүхбаатар	17
6	Улаанбаатар	Хан-Уул	45
7	Улаанбаатар	Чингэлтэй	22
8	Ховд	Жаргалант	65
9	Дорнод	Хэрлэн	61
10	Дархан-Уул	Дархан	65
11	Орхон	Баян-Өндөр	60
12	Өвөрхангай	Арвайхээр	67
13	Төв	Зуунмод	55
Нийт			651

Ухаалаг төхөөрөмж болох таблет /CAPI/ ашиглаж мэдээлэл цуглуулалт хийсэн судалгаанд хамрагдах эцэг, эхийн тоог тухайн байршлын өрхийн тоо болон илтгэх чадварыг харгалзан тооцоолсон. Судалгааны түүвэрлэлтийг энгийн санамсаргүй түүврийн аргаар хийсэн. Оролцогчийн хүйс нь тэнцвэртэй буюу 49.2% нь эрэгтэй, 50.8% нь эмэгтэй оролцогч байлаа. Насны хувьд 36-45 насны эцэг, эхчүүд нийт судалгаанд оролцогчдын 51.2%-ийг бүрдүүлжээ. Одоогийн амьдарч буй сууцны хувьд 39.9% нь орон сууцны хороололд, 36.3% нь гэр хорооллын байшинд, 22.4% нь Монгол гэрт амьдардаг гэжээ. Ажил эрхлэлтийн хувьд 30.3% нь төрийн албанд ажилладаг оролцогчид байна.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3: МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА

ЗОРИЛГО

Цахим орчин дах хүүхэд хамгааллын чиглэлээр цаашид хийж хэрэгжүүлбэл зохих ажлууд, хүндрэл бэрхшээл зэргийг тодорхойлоход чиглэгдсэн.

АРГАЗҮЙ

Урьдчилсан бэлтгэсэн асуулгын дагуу ганцаарчилсан ярилцлагад тохирох оролцогчдыг сонгон шалгаруулж, тэдгээр мэргэжилтнүүдтэй нэг бүр цаг тохирч, мэргэшсэн чиглүүлэгчийн удирдлага доор ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан. Нэг удаагийн ганцаарчилсан ярилцлагын дундаж үргэлжлэх хугацаа нь 30 орчим минут байсан.

ХАМРАХ ХҮРЭЭ


Цахим орчин дах хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг 7 мэргэжилтэнтэй ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан. Үүнд:

1. НҮБ-ийн хүүхдийн сангийн мэргэжилтэн
2. Хүүхдийн тусламжийн 108 утасны мэргэжилтэн
3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн
4. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын мэргэжилтэн
5. Хөөрхөн зүрх ТББ-ын мэргэжилтэн
6. Нийслэлийн ЕБС-ын 1-р сургуулийн багш
7. Нийслэлийн ЕБС-ын 33-р сургуулийн багш

1.3 СУДАЛГААНЫ БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үндэсний хэмжээний асуудлыг авч үзэж байгаа тул чадварлаг, өргөн бүрэлдэхүүнтэй багийг бүрдүүлэн ажиллах нэн шаардлагатай байдаг. Тиймээс судалгааны багийг дараах бүтэцтэйгээр байгуулан ажиллалаа.

Зураг 1: Судалгааны багийн зохион байгуулалтын бүтэц



Судалгааны ажлыг 1 багийн ахлагч, 1 нягтлан бодогч, 1 ахлах судлаач, 4 статистик судалгааны мэргэжилтэн, 8 мэдээлэл оруулагч болон 30 мэдээлэл цуглуулалтын ажилтан, **НИЙТ 45 ХҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙГЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН.**

1.4 СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЕ ШАТУУД

Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ дараах үе шаттайгаар ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:



Судалгааг амжилттай зохион байгуулахын тулд дараах үйл ажиллагаануудыг шат дараалалтайгаар хэрэгжүүлсэн.

Хүснэгт 3: Судалгааны зохион байгуулалтын үе шатууд

Үе шатууд	Судалгааны нарийвчилсан үе шатууд
1. Судалгааны бэлтгэл ажлыг хангах үе шат	1. Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгслийг боловсруулах үе шат 2. Мэдээлэл цуглуулах тусгайланс программыг бэлтгэх үе шат 3. Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтнуудыг бүрдүүлэх үе шат
2. Туршилт судалгааг зохион байгуулах, мэдээлэл цуглуулах ажилтнуудыг сургах үе шат	1. Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтнуудыг сургаж бэлтгэх үе шат 2. Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгслийг турших, дахин засварлах, батлах үе шат 3. Туршилтын судалгааг зохион байгуулах үе шат
3. Мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулах үе шат	1. Судалгааны мэдээллийг цуглуулах үе шат 2. Явцын тайланг захиалагч талд 7 хоног бүр илгээх
4. Чанарын хяналт хийх, мэдээллийн сан үүсгэх үе шат	1. Цуглуулсан мэдээлэлд чанарын хяналтыг хийх үе шат 2. Улаанбаатар хот болон орон нутгийн мэдээлэл цуглуулалтын чанарын хяналтыг өдөр тутам хийж гүйцэтгэх, захиалагчид 7 хоног бүр мэдээлэх 3. Мэдээллийн сан үүсгэх
5. Тайлан боловсруулах, захиалагч талд хүлээлгэн өгөх үе шат	1. Судалгааны мэдээллийг шалгах засварлах, мэдээллийн сан үүсгэх үе шат 2. Судалгааны эцсийн тайланг бэлтгэж хүргүүлэх үе шат 3. Судалгааны материалыг бэлтгэх, хүлээлгэн өгөх үе шат 4. Судалгааны мэдээллийн санг хүлээлгэн өгөх үе шат

1.1 Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгслийг боловсруулах

Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгсэл (Survey instruments) гэдэгт дараах зүйлсийг хамруулан авч үзэж байгаа болно.

- 13-18 насны хүүхдээс авах судалгааны асуулга;
- 7-18 насны хүүхэдтэй эцэг, эхээс авах судалгааны асуулга;
- Мэргэжилтнүүдтэй хийх ганцаарчилсан ярилцлагын удирдамж;
- Ярилцлага авагч нар зориулсан үнэлгээний карт;
- Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд ашиглах бусад материалууд.

Судалгааны асуулгад ажлын даалгаварт дурдсан бүхий л зүйлсийг багтааснаас гадна бусад нэмэлт шаардлагатай асуултуудыг оруулж өгсөн. Судалгааны асуулгыг урьдчилсан байдлаар бэлтгэн, захиалагчтай байгууллагын ажлын хэсгийн ахлагч болон холбогдох бусад албан тушаалтнууд болон "Хүүхдийн тусламжийн утас 108" болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн мэргэжилтнүүдтэй уулзалтыг зохион байгуулсан. Уг уулзалтын хүрээнд захиалагч байгууллага болон мэргэжилтнүүдээс ирүүлсэн санал хүсэлт, мэдээллийн хэрэгцээний дагуу, судалгааны асуулгад саналыг тусган судалгааны асуулгыг батлуулсан. Батлагдсан судалгааны асуулгыг хавсралт хэсгээс харна уу.


Судалгааны асуулгыг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан. Үүнд:

- Судалгааны асуулт, хэрэглэгдэж буй үг хэллэг, нэр томьёо нь судалгаанд оролцогчдод ойлгомжтой, хоёрдмол утгыг илэрхийлээгүй, эргэлзээ төрүүлэхгүй байх,
- Олон улсын болон үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, хэрэглэгддэг ойлголт тодорхойлолт, ангилал кодчиллыг ашигласан байх,
- Мэдээлэл боловсруулалтыг хялбарчлах, мэдээлэл оруулалтын алдааг багасгах үүднээс асуултын хариултыг боломжит түвшинд кодчилсон байх,

1.2 Судалгааны мэдээллийг оруулах тусгайлсан программыг бэлтгэх

Судалгааны мэдээлэл цуглуулалтад интернэтэд суурилсан мэргэжлийн программыг ашигласан. 3G/4G дата сүлжээнд холбогдсон мэдээлэл цуглуулалтын программ нь ярилцлагын аудио бичлэг, асуулгын хариулт, судалгаа авч буй байршил зэргийг 30 секундийн дотор MMCG компанийн төв серверт шууд дамжуулдаг. Ингэснээр мэдээлэл цуглуулалтын чанарын хяналтыг REAL TIME хийх боломж бүрддэг. REAL TIME хяналт нь мэдээллийн алдаагүй байдлын түвшнийг нэмэгдүүлэх, судлаачдын өдөр тутмын ажлын явц, мэдээллийн чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой юм. Ярилцлага авагч хаана ажиллаж байгааг GPS-ийн байршлаар хянаж байгаа нь ярилцлага авагчийн аюулгүй байдлыг хангадаг. Мөн Android үйлдлийн систем дээр ажиллах боломжтой бөгөөд мэдээллийн логик уялдаа холбоог хянах, мэдээллийг SPSS, MS-Excel, STATA зэрэг мэргэжлийн программ руу хөрвүүлэн ашиглах боломжтой судалгааны мэдээлэл цуглуулах, оруулахад тусгайлан зориулагдсан мэргэжлийн программ юм.

Зураг 2: Таблетаар судалгааны мэдээлэл цуглуулалт хийх программын харагдах байдал



2.1 Туршилт судалгааг зохион байгуулах

Бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн гол ажлуудын нэг нь судалгааны асуулгын үг хэллэг нь судалгаанд оролцогчоос асуухад ойлгогдож байгаа эсэхийг судалгаа эхлэхээс өмнө туршиж үзэх байсан. Судалгааны асуулга болон мэдээлэл цуглуулалтын программыг турших ажлыг 2020 оны 06 сарын 15,16-ны өдөр Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 4 эцэг, эх болон 4 хүүхдийн дунд зохион байгуулсан. Туршилт судалгааны үеэр асуулга болон программд гарсан алдаа дутагдлыг илрүүлж засварлаж ажилласан.

Зураг 3: Судалгааны асуулга, зааврыг боловсруулсан дараалал



Асуулгыг батлуулахаас өмнө хөндлөнгийн редакторыг ажиллуулан үг үсгийн алдаа болон бусад алдааг хянуулсан. Харилцаа холбооны зохицуулах хорооноос асуулгуудыг хянан үзэж баталсны дараа асуулгуудыг САПИ (Computer Assited Personal Interview)-д зориулан программыг бэлтгэсэн. Асуулгыг боловсруулахдаа ISO 20252:2019 стандартын 4.4.1 дэх заалт (асуулгын зарчим, дизайн), 4.4.3 дахь заалт (Асуулгыг турших) зэрэг заалтыг дагаж мөрдсөн.

2.2 Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтнуудыг сургаж бэлтгэх

ММCG компанийн мэдээлэл цуглуулах ажилтнуудын бүртгэлээс судлаачдыг сонгон авч сургалтад хамруулсан. Судалгааны ажилд оролцож буй хүн бүр нь судалгааны зорилго, ач холбогдол, үйл ажиллагааны зохион байгуулалт, асуулга дахь нэр томьёо, асуулгыг хэрхэн бөглөх талаар сайтар ойлголттой байх нь судалгааны мэдээлэл цуглуулалтын чанарт чухал ач холбогдолтой. Мэдээлэл цуглуулах ажиллагчдыг бүрдүүлэх, сургаж бэлтгэхдээ ISO 20252:2019 стандартын "5.2 Мэдээлэл цуглуулах ажилтны удирдлага зохион байгуулалт, элсүүлэх болон сургах үйл ажиллагаа" хэсэгт заасан заалтуудыг баримтлан ажилласан.

Судалгааны багийн ахлагч, мэдээллийн хяналтын ажилтан, ярилцлага авагчдыг дараах байдлаар сонгон шалгаруулж ажиллуулсан. Багийн ахлагчид болон мэдээллийн хяналтын ажилтны хувьд өөрийн байгууллагын үндсэн ажилтнуудыг томилон ажиллуулсан. Ярилцлага авагчдыг "Эм Эм Си Жи" ХХК-ийн гэрээт ажилтны бүртгэлийн сан дахь мэргэшсэн судлаачдаас сонгон авч бүрдүүлсэн. Манай байгууллагын зүгээс ярилцлага авагчид болон операторуудын сонгон шалгаруулалтад ихээхэн ач холбогдол өгч ажилласан бөгөөд дараах байдлаар зохион байгуулсан. Үүнд:

- Ярианы болон бичгийн өндөр чадвартай, Их дээд сургууль төгссөн, багаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай хүмүүсийн ажилтнаар бүртгэж авсан.

- Эхний шатанд уг төсөлд ажиллах хүсэлтэй 80 мэргэшсэн судлаач бүртгүүлсэн бөгөөд үүнээс ижил төрлийн судалгаанд ажилласан туршлагыг харгалзан 40 судлаачийг сонгон авч үлдсэн.
- Эдгээр судлаачдад судалгааны төслийн арга зүйн сургалтыг 1 өдрийн хагас, дадлагажих сургалтыг мөн 1 өдрийн хагас зохион байгуулсан бөгөөд үүнээс 30 судлаач бүртгэлд үлдэж үргэлжлүүлэн ажилласан.
- Сонгон авсан 30 судлаачтай нэг бүрчлэн гэрээт ажилтны болон ажлын явцад олж мэдсэн мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх нууцлалын гэрээг байгуулсан.

Зураг 4: Судалгааны аргазүйн сургалт зохион байгуулж буй байдал



Хүүхэд болон өсвөр насны хүүхдээс судалгаа авах нь насанд хүрэгчдээс судалгаа авахаас ихээхэн ялгаатай. Учир нь хүүхэд, өсвөр насны хүүхдүүдийн сэтгэлзүй тогтворгүй байдгаас гадна хэрэв ямар нэгэн байдлаар цахим орчны дарамт шахалтад өртсөн тохиолдолд бусдад түүнийгээ илэрхийлж хэлэхгүй байх магадлал маш өндөр байдаг. Тиймээс тэдний асуудлыг гүнзгий ойлгох үүднээс ESOMAR-ийн хүүхдүүдтэй ярилцлага хийх удирдамж, аргазүйг мөрдлөг болгон ажиллах талаар судлаачдад гүнзгийрүүлсэн сургалтыг зохион байгуулсан.

ESOMAR - ХҮҮХДҮҮДТЭЙ ЯРИЛЦЛАГА ХИЙХЭД АНХААРАХ ЁС ЗҮЙН КОД

1. Хэрвээ сургуулийн орчинд судалгаа авахаар болбол судалгаа авахын өмнө тухайн байршлыг хариуцаж буй насанд хүрсэн хүний зөвшөөрлийг авсан байх ёстой.
2. Гэрт, гудамжинд эсвэл олон нийтийн газар судалгаа авахаар болбол хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, эсвэл эцэг эхийн зөвшөөрлөөр хүүхдийг харж байгаа хүний зөвшөөрлийг заавал авсан байх ёстой. Ямар ч нөхцөлд насанд хүрсэн хүн хамт байхгүй бол судалгаа авч болохгүй.
3. Ярилцлага авах зөвшөөрлийг авахдаа шаардлагатай бүхий л мэдээллийг эцэг эх, асран хамгаалагчид өгөх ба хангалттай мэдээлэлтэй байлгана. Хэрвээ асран хамгаалагч нь судалгааны асуулт бүрийг сонсох, харах боломжгүй бол ярилцлагын ерөнхий утга агуулга, байж болох эвгүй ичмээр асуултын тайлбарыг хамт тайлбарлах ёстой.
4. Ялангуяа гэр нь судалгаа авч байгаа тохиолдолд насанд хүрсэн хүн ойрхон байх нь тохиромжтой. Гэхдээ тухайн хүн нь заавал нэг өрөөнд байх шаардлагагүй. Судалгааны аргачлалын хувьд хариултын зөрүү үүсгэж мэдэх тул аль болох нэг өрөөнд байлгахгүй байхыг хичээх хэрэгтэй.

5. Хүүхэд, өсвөр насны хүүхдийн өсөлт хөгжлийн түвшнийг харгалзан үзэж, ямар төрлийн асуулт зохимжтой эсвэл зохимжгүй эсэхийг бодолцох шаардлагатай. Жишээ нь хүүхдээс асуухад айлгаж болзошгүй асуултыг тохирох арга хэрэгслүүдийг ашиглан өсвөр насны хүүхдээс зөв асууж болно. Анхаарах шаардлагатай асуудлуудад (i) Найзууд хоорондынх нь харилцаа, (ii) Эцэг эхтэй нь эвгүй байдалд оруулж болох асуулт, (iii) Санааг зовоож, сэтгэлийг нь түгшээж болзошгүй асуултууд орно.
6. Өмнөх зүйлд заасан асуултуудыг судалгааны сэдвийн хүрээнд оруулж болдог. Энэ тохиолдолд бүх тайлбарыг асран хамгаалагчид өгсөн байх ёстой ба тухайн асуултуудад хүүхэд болон өсвөр насныхан ямар нэгэн байдлаар санаа зовохгүй, будилахгүй, буруу ойлгохгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай.
7. Тусгай бэлтгэгдсэн ярилцлага авагч байх шаардлагатай ба ярилцлага авагч бүрийг тохиромжтой эсэхийг нарийн шалгуураар шалгах ёстой. Ярилцлага авагчийг хандлага, зан үйл нь сэжиг төрүүлэх бус, итгэл даахуйц байх хэрэгтэй ба ярилцлага авагч нарт зөвшөөрөл авах зөв аргууд, хүүхдүүдтэй хэрхэн сайн харилцаа үүсгэх вэ зэрэг тусгай сургалтад хамруулсан байх шаардлагатай.

3.1 Мэдээлэл цуглуулах багийн гишүүдийн аюулгүй байдал, COVID19-н нөхцөл байдлыг хангаж ажилласан байдал

Зөвлөх үйлчилгээний мэдээлэл цуглуулалтыг явуулахад судлаачдын аюулгүй байдлыг хангах нь хамгийн чухал юм. Тиймээс бид энэ тал дээр онцгой анхаарал хандуулан ажилласан бөгөөд дараах үе шатуудыг заавал дагаж мөрдсөн. Үүнд:

1. Энэ чиглэлийн судалгаа, зөвлөх үйлчилгээний мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэж байсан туршлагатай ярилцлага авагчдаар багаа бүрдүүлэх	2. Судлаачдын аюулгүй байдлыг хангах үүднээс заавал олгогдох зүйлсийг бүрдүүлэх, бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг шалгах	3. "Аюулгүй ажиллагааны дүрэм" танилцуулах, болон тухайн мэдээлэл цуглуулалтын ажлын онцлогтой холбоотой гарах бусад зүйлсийг заавал танилцуулж сургалт орох	4. "Аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн биелэлт, хэрэгжилтэнд судалгааны менежер болон мэдээлэл цуглуулах багийн ахлагч байнга хяналт тавих, хэрэгжилтийг хангах
---	---	--	---

Байгаль цаг уурын нөхцөл байдал, гэмтэж бэртэх зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан мэдээлэл цуглуулагч нарын аюулгүй байдлыг хангах үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Мэдээлэл цуглуулагч нарыг Тэнгэр даатгал компанийн "Гэнэтийн осол, хөдөлмөрийн чадвараа түр алдалтын даатгал"-д хамруулсан.
2. Мэдээлэл цуглуулагч нарт "Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтан мөн" гэдгийг батлах түр үнэмлэх олгох зэрэг арга хэмжээг авсан.
3. "Эм Эм Си Жи" ХХКомпанийн "Аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг бүх ярилцлага авагчид болон багийн ахлагчид, судалгааны менежерүүд үйл ажиллагааны үе шат бүрд дагаж мөрдөж ажилласан.

4. Мэдээлэл цуглуулагч нарын аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах багаж хэрэгслээр хангасан.
 - 4.0 Хурц тусдаг гар чийдэн
 - 4.1 Чанга дуу гаргагч /шүгэл/
 - 4.2 Нулимс асгаруулагч
5. Мэдээлэл цуглуулагч нарын талбар дээр ажиллах цагийн хуваарийг өвөл болон зуны нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр журамд заасан нөхцөлөөр тодорхойлсон.

COVID19 цар тахлын эрсдэлтэй нөхцөл байдлын үед мэдээлэл цуглуулалтыг хийж гүйцэтгэсэн тул Улсын Онцгой Комиссоос өгсөн чиглэлийн дагуу дараах сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Ярилцлага авагч нарыг өдөр бүр хэрэглэх маск, ариутгалын бодис, зайнаас халуун хэмжигч, бээлий зэргээр хангасан.
2. Өдөр бүр өөрсдийн халууныг хэмжиж ажилласан.
3. Энгийн эрүүл мэндийн асуулга асуусны дараа судалгаагаа авч ажилласан.
4. Судалгаанд оролцогчтой зайнаас харилцаж, хоорондын зайг барьж ажилласан.
5. Таблет болон гар утсаа өдөр бүр ариутган хэрэглэсэн.

3.2 Мэдээлэл цуглуулалтын явцад судлаач нарын ашигласан техник хэрэгсэл

Мэдээлэл цуглуулагчид болон багийн бусад гишүүдийг дараах техник хэрэгслээр хангаж аюулгүй байдлыг дээр зэргээр хангаж ажилласан. Мэдээлэл цуглуулагчид нь янз бүрийн орчинд ажилладаг учраас аюулгүй байдлыг хангах үүднээс шүгэлтэй гар чийдэн, малгай зэргийг дотоод журмын дагуу олгосон.

Хүснэгт 4: Мэдээлэл цуглуулалтад ашигласан техник хэрэгсэл

Хангагдах зүйлсийн зураг	Хангагдах зүйлсийн нэр	Олгогдох тоо	Зориулалт
Судлаачдын аюулгүй байдалтай холбоотой			
	Малгай /Эм Эм Си Жи ХХКомпанийн/	1	Судалгаа, зөвлөх үйлчилгээний компанийн нэрийн өмнөөс тухайн талбарт ажиллаж буйг илэрхийлдэг.
	Судлаачийн үнэмлэх /Эм Эм Си Жи ХХКомпанийн түр үнэмлэх/	1	Судалгаа, зөвлөх үйлчилгээний мэдээлэл цуглуулах ажлаар тухайн талбарт ажиллаж буйг илэрхийлэх нотлох баримт болдог.

	Таблет	1	Мэдээлэл цуглуулалтыг хийхэд ашигласан
	Маск, гар ариутгагч	1	COVID19-н халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор ашигласан

3.3 Мэдээлэл цуглуулалт болон түүврийн тархаалтыг хийсэн байдал

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг таблет болон судалгааны мэргэжлийн программ ашиглаж 100% нүүр тулсан ярилцлагын аргаар зохион байгуулсан. Ярилцлага авагч судалгааны зорилго болон судалгаагаар цуглуулсан мэдээллийн нууцлалыг Хувь хүний нууцын тухай хуулийн 5.4 дэх заалтын дагуу *"чандлан хадгалж, зөвхөн судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах болно"* гэдгийг хэлж тайлбарлаж, судалгаанд оролцохыг зөвшөөрсний дараа ярилцлагыг хийсэн. Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2020 оны 06 сарын 18 өдрөөс 06 сарын 27-ны өдрийн хооронд 10 хоногийн хугацаанд бүрэн дуусгасан.

Зураг 5: Судалгааны мэдээлэл цуглуулж буй байдал




Хүүхэд, өсвөр насны хүүхдийг судалгаанд хамруулахдаа ICC/ESOMAR ёс зүйн дүрмийг чандлан мөрдөж, мэдээллийн нууцлалыг сахин хамгаалж, бусад холбогдох хууль тогтоомж, ёс зүйн кодыг мөрдөж ажиллав. Үүнд:

- Эцэг, эхээс нь зөвшөөрөл авсны дараа хүүхдээс судалгаа авсан.
- Хүүхэд болон өсвөр насныхан судалгаанд оролцсоноороо ямар нэгэн байдлаар гэмтэх буюу сэтгэл түгших ёсгүй.

- Судалгаанд оролцогчийн эцэг эх, асран хамгаалагч нь тэдний аюулгүй байдалд санаа зовохгүй, тэдний эрх, сонирхол нь хамгаалагдаж байгаа гэдэгт бүрэн итгэлтэй байх хэрэгтэй.
- Ярилцлага авагч болон судалгааны ажилтнууд нь хүүхэд болон өсвөр насны хүүхэдтэй харилцахаас үүдэн гарах аливаа үл ойлголцлоос хамгаалагдсан байх ёстой.
- Судалгааны бүхий л үйл явцад хүүхэдтэй харилцахдаа ямар нэгэн байдлаар хүчирхийлэл хэрэглээгүй, хамгийн өндөр ёс зүйн хэм хэмжээг баримталж ажилласан.

Зураг 6. 13-16 насны хүүхдээс судалгаа авахдаа эцэг, эхээс нь зөвшөөрөл авсан хуудас



НЭСЭГ, ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ХҮУДАС
"ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ
СУДАЛГАА"

ММCG (Эм Эн Си Жи) ХХК судалгааны байгууллагаас иргэний байгуулж буй "ЦАХИМ
ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА"-ийн
мандай 13-15 насны хүүхэд хамрагдаж, мэдээлэл өгөхийг зөвшөөрч байна. Судалгааны
ерөнхий зүтгэ, агуулгатай танилцсан болно.

Судалгаанд оролцогч хүүхдийн нэр _____

Зөвшөөрөл өгсөн эцэг, эх, асран хамгаалагчийн нэр _____

Зөвшөөрөл өгсөн эцэг, эх, асран хамгаалагчийн гарын үсэг _____

Судалгаанд хамрагдаж хэлсэн мэдээллийг зөвхөн "ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА"-ийн нэгдсэн дүгнэлт гаргах зорилгоор
ашиглах бөгөөд таны зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн мэдээллийг тайлбарлах эрхгүй гэдгийг
"Хувь хүний нууцлал тухай Монгол Улсын хууль", ISO 20152:2019-ийн 4.1.2.2, 4.1.2.3-т заасны
дагуу агуулах бодилоо баталж байна.


Эм Эн Си Жи ХХК-ийн судалгааны нэр _____

Эм Эн Си Жи ХХК-ийн судалгааны гарын үсэг _____

СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН ТАРХААЛТЫГ ХИЙСЭН БАЙДАЛ

Судалгааны мэдээллийг төвлөрсөн нэг цэгээс цуглуулснаар эх олонлогоо төлөөлөх чадваргүй болдог. Харин түүврийн тархалтыг маш сайн хийснээр эх олонлогоо бүрэн төлөөлөх чадвартай болдог. Ингэснээр судалгааны үр дүн нэг байршилд байгаа хүүхэд болон эцэг, эхийн санаа бодлыг тусгасан биш, харин нийт хүүхэд болон эцэг, эхийн санаа бодлыг тусгаж чаддаг. Жишээ болгон Дархан-Уул аймагт судалгаа авсан байршлуудын GPS цэгийг харууллаа.

Зураг 7. Судалгаа авсан GPS цэгийн байрлал



4.1 Мэдээлэл цуглуулалтын чанарын хяналт

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг таблет болон судалгааны мэргэжлийн программ ашиглаж 100% нүүр тулсан ярилцлагын аргаар зохион байгуулсан. 3G/4G дата сүлжээнд холбогдсон мэдээлэл цуглуулалтын программ нь ярилцлагын аудио бичлэг, асуулгын хариулт, судалгаа авч буй байршил зэргийг 30 секундийн дотор MMCG компанийн төв серверт шууд дамжуулдаг. Ингэснээр мэдээлэл цуглуулалтын чанарын хяналтыг REAL TIME хийсэн.

Зураг 8. Real time чанарын хяналт хийсэн хянах самбарын харагдах байдал

Item ID	Item Name	Item Type	Item Status	Item Location	Item Date	Item Time	Item User	Item Comment	Item Action	Item Result	Item Score	Item Total
1000001	Item 1	Item 1 Type	Item 1 Status	Item 1 Location	Item 1 Date	Item 1 Time	Item 1 User	Item 1 Comment	Item 1 Action	Item 1 Result	Item 1 Score	Item 1 Total
1000002	Item 2	Item 2 Type	Item 2 Status	Item 2 Location	Item 2 Date	Item 2 Time	Item 2 User	Item 2 Comment	Item 2 Action	Item 2 Result	Item 2 Score	Item 2 Total
1000003	Item 3	Item 3 Type	Item 3 Status	Item 3 Location	Item 3 Date	Item 3 Time	Item 3 User	Item 3 Comment	Item 3 Action	Item 3 Result	Item 3 Score	Item 3 Total
1000004	Item 4	Item 4 Type	Item 4 Status	Item 4 Location	Item 4 Date	Item 4 Time	Item 4 User	Item 4 Comment	Item 4 Action	Item 4 Result	Item 4 Score	Item 4 Total
1000005	Item 5	Item 5 Type	Item 5 Status	Item 5 Location	Item 5 Date	Item 5 Time	Item 5 User	Item 5 Comment	Item 5 Action	Item 5 Result	Item 5 Score	Item 5 Total
1000006	Item 6	Item 6 Type	Item 6 Status	Item 6 Location	Item 6 Date	Item 6 Time	Item 6 User	Item 6 Comment	Item 6 Action	Item 6 Result	Item 6 Score	Item 6 Total
1000007	Item 7	Item 7 Type	Item 7 Status	Item 7 Location	Item 7 Date	Item 7 Time	Item 7 User	Item 7 Comment	Item 7 Action	Item 7 Result	Item 7 Score	Item 7 Total
1000008	Item 8	Item 8 Type	Item 8 Status	Item 8 Location	Item 8 Date	Item 8 Time	Item 8 User	Item 8 Comment	Item 8 Action	Item 8 Result	Item 8 Score	Item 8 Total
1000009	Item 9	Item 9 Type	Item 9 Status	Item 9 Location	Item 9 Date	Item 9 Time	Item 9 User	Item 9 Comment	Item 9 Action	Item 9 Result	Item 9 Score	Item 9 Total
1000010	Item 10	Item 10 Type	Item 10 Status	Item 10 Location	Item 10 Date	Item 10 Time	Item 10 User	Item 10 Comment	Item 10 Action	Item 10 Result	Item 10 Score	Item 10 Total

Мэдээлэл цуглуулалтын байдалд эргэн хяналт тавих (Back-checking):

Мэдээлэл цуглуулалтын чанарт хяналт тавихдаа бид ISO 20252:2019 стандартын 5.4 дэх заалт (Тоон судалгааны мэдээлэл цуглуулах ажилтны ажилд хяналт тавих)-ыг дагаж мөрдсөн.

Ингэхдээ дараах 4 төрлийн хяналтыг хийлээ. Үүнд:

1. Судалгаа авсан GPS байршлыг 97%-д тодорхойлсон.
2. Нийт ярилцлагын 95%-ийн аудио бичлэгийг хийсэн.
3. Судалгааны ярилцлагын 21% буюу 289 аудио бичлэгийг дахин сонсож хяналт хийсэн.
4. Нийт 483 оролцогчтой буюу 35% -тай нь эргэж утсаар холбогдож хяналт хийсэн.

Судалгааны төслийн багаас судалгаанд оролцогчтой утасны дугаараар эргэн холбогдож, судалгаанд оролцсон эсэх, судалгааны зорилго ач холбогдлыг хэрхэн ойлгосон болохыг тодруулж, цөөн тооны тодорхой хугацаанд өөрчлөгдөхөөргүй зарим асуултыг дахин асууж тулгаж шалгасан.

[illegible]

Багийн ахлагч нар хяналтын ажлын үр дүнгээр протокол хөтөлсөн бөгөөд хяналтын ажлын хүснэгтийг бөглөсөн. Хяналт хийгдэх явцад мэдээлэл цуглуулалт алдаатай, зохих журмын дагуу явагдаагүй тохиолдолд мэдээлэл цуглуулалтыг дахин хийх арга хэмжээг авч ажилласан. Эдгээр хяналтын хүрээнд 33 ярилцлага судалгааг хүчингүй болсон.

Зураг 10. Алдааны протоколыг хөтөлсөн байдал

№	Судалгааны ID	Судалгааны нэр	Асуултын дугаар	Алдааны тэмдэглэл	Судлаачид сангуулсан эр	Алдааны тоо
1	112357088	mmcg2020-125	Q4.1.1	Асуултыг асуулгүй алгасан.	Утасдаар хэлсэн	
2			Q3.3	Тл танин хүний цахим дархат нь на үү лавал үнэ тэмдгийнхний цахим дархат их үү	Утасдаар хэлсэн	
3			Q4.4	Асуултаа тайн ойлгуулах хариултыг бүрэн үншилж өгч сонгуулах /оригинал асуултыг тайн ойлголгүй байх шиг байна/	Утасдаар хэлсэн	
4	112357717	mmcg2020-120	no comment			
5	112398222	mmcg2020-120	no comment			
6	112357738	mmcg2020-117	Q1.5	Асуултыг асуулгүй алгасан. Асуултыг ит байсвалар нь бүрэн ойлгомжтой үншилж өгнө. 15 настай эмэгтэйд 13 настай эрэгтэй гэдгээр сонгосон.		
7			Q4.11.1	Оригиналыг өөрөөр нь хэлж байгаа гэдгээр ойлго.		
8	112398150	mmcg2020-117	no comment			
9	112407978	mmcg2020-109	no comment		Өөртэй нь уулзаж хэлсэн	
10	112408551	mmcg2020-108	Q4.11.1	Хуудсанд маань н-нэтийг асуулгүй ашиглан надна байгаа гэдэг асуултыг засах	Өөртэй нь уулзаж хэлсэн	
11	112399489	mmcg2020-111	Q1.5	Асуултыг бүрэн үншилж ит	Утасдаар хэлсэн	
12			Q1.1	Хариултыг бүрэн үншилж өгч сонгуулна. FB ашиглан байгаа юм чинэ Messenger байгаа гэсэн үг		
13			Q3.10	Хариултыг бүрэн үншилж өгч сонгуулна.		
14			Q3.4	Үгүй, мэдээгүй гэдгээр тайн гэсэн хариулт авсан байна.		
15			Q3.18	Хариултыг өөрөөр нь хэлүүлэх		
16	112404050	MMCG2020-201		Танилцуулгаа бүрэн үншилж ит	Утасдаар хэлсэн	
17			Q1.5	Асуултыг бүрэн үншилж ит. Назны ангилал түс бүрийг үншилж өгч сонгуулна. Ратонд гэдгийг сонгосон эхлэж хэлж нь л авна. Хүүхдэд энэ 2- лонхаас нь асуухгүй. Тус бүрд нь сүүлчээ судалгаа авна.		
18			Q1.1	Хүүхдэд нь бараг 1 настайгаас автвал хий үзлэг байсан гэдгээр 7-8 настайг хэрэглэн хэлсэн байх гэдгээр хариултыг түгээгүй.		
19			Q3.8	Хэлж мэдээгүй байна гэдэг хариултыг үншилж өгөөгүй.		



ХОЁР. СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

2. СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

13-18 настай хүүхдийн судалгаа:

Хүүхдүүд интернэт, цахим орчныг өдөр тутамдаа түгээмэл ашиглаж байна. 7-12 насны хүүхдүүдийн 62% нь, 13-18 насны хүүхдийн 71% нь өдөр бүр интернэт ашигладаг. Ялангуяа орон сууцны хороололд амьдардаг хүүхдүүдийн интернэтэд орж эхэлсэн нас бага, давтамж нь ойр байна. Интернэт орчинд 7-12 насны хүүхдүүд өдөрт дунджаар 2.3 цагийг, 13-18 насныхан 4.0 цагийг зарцуулдаг. Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) нь 5-10 насны хүүхдэд өдөрт 1 цагаас бага, 11-18 насны хүүхдэд өдөрт 2-оос бага цагийг цахим хэрэглээнд зарцуулах стандартыг гаргасан байдаг. Энэ стандартаас манай хүүхдүүдийн цахим хэрэглээ өндөр байна.

Хүүхдүүдийн интернэт ордог гол төхөөрөмж нь ухаалаг утас байна. Тэд ихэвчлэн мобайл дата (78%) болон өрхийн Wi-Fi ашиглаж (58%) интернэт орж байна. Хүүхдүүдийн 89% нь аав, ээжийн эзгүйд буюу хараа хяналтгүйгээр интернэт ашигладаг гэжээ. Энэ хандлага хүүхдүүд том болох тусам нэмэгдэж байна. Тийм учраас үүрэн холбооны оператор компаниуд болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудтай хамтарч технологийн шийдэл ашиглан цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр тодорхой ажлуудыг хийх хэрэгтэй.

Хүүхдүүдийн хамгийн их ашигладаг сошиал медиа нь фейсбүүк, фейсбүүкийн мессенжер, ютуб, инстаграм, тик ток байна. Инстаграм, тик токийг хөвгүүдээс охид хэрэглэх нь илүү байна. Хэдийгээр 13 болон түүнээс дээш насанд фейсбүүк хэрэглэхийг зөвшөөрдөг ч **7-12 настай хүүхдүүдийн 50% нь фейсбүүк хэрэглэдэг** аж. 13-18 насны хүүхдүүдийн 10 хүүхэд тутмын 8 буюу **77%-д нь фейсбүүкийн 1-с олон хаягтай найз байдаг**. Найзууд нь дунджаар 3-4 хаягтай. Фейсбүүкийн **илүү хаягаараа 61% нь бусадтай чатлах танилцах, 36% нь эцэг эхийн хяналтгүй сошиал медиа ашиглах зорилготой** байдаг гэжээ. Мөн 60% нь фейсбүүкийн найзууд дунд мэдэхгүй, танихгүй хүмүүс байдаг гэж хариулсан. Өөрөөр хэлбэл хүүхэд фейсбүүкт танихгүй хүнтэй харилцах магадлал их байна. Мөн фейсбүүкийн олон хаяг ашиглаж байгаа нь сошиал дахь харилцааг нь хянах боломжийг багасгаж байна.

Интернэтээр видео бичлэг үзэх, фейсбүүк, ютуб зэрэг сошиал медиа ашиглах, интернэт сайтуудаар зочлох, интернэтээр холбогдож тоглоом тоглох зэрэг нь **аюулгүй (65%) гэж 10 хүүхэд тутмын 6-7 нь боддог** байна. Цааш нарийвчилж интернэтээр хийдэг үйлдлээс эрсдэлийг хэрхэн харж байгааг нь тодруулахад, 70% нь хэн нэгэнд хувийн мэдээллээ чатаар хэлэх болон чатаар танилцсан хэн нэгэнтэй биечлэн уулзах нь хамгийн их эрсдэлтэй гэж хариулжээ. Мөн танихгүй хүнтэй чатлах гэж 68%, танихгүй хүнтэй фейсбүүкийн найз болох, интернэтийн сайтуудад бүртгэл хийхдээ хувийн мэдээллээ өгөх нь эрсдэлтэй гэж 51% нь үзсэн. Гэхдээ танихгүй хүнтэй харилцахаас зайлсхийхгүй байгааг өмнөх хэсгийн үр дүн харуулсан. Хүүхэд эрсдэл байгааг мэдэж байгаа ч гарах үр дүн, сөрөг нөлөөг нь гүйцэд харж, дүгнэж чадахгүй байгаа хандлага ажиглагдаж байна.

Хүүхдүүдийн 93% нь интернэт орчноор дамжуулан үйлдсэн гэмт хэргийн талаар ямар нэгэн байдлаар сонсож байсан боловч өөрийгөө хамгаалах үйлдлүүдийг хангалттай түвшинд хийж

чадахгүй байна. Тухайлбал, найзуудаас ирсэн холбоос бүхий мэдээллийг **52% нь шууд дарж үздэг**, хэн нэгэн этгээд сөрөг сэтгэгдэл бичвэл 2 хүүхэд тутмын 1 нь зүгээр л орхидог байна.

Олон улсын туршлагаар нийгмийн аливаа эмзэг асуудлыг гуравдагч бие дээр асуух байдлаар тодорхойлдог. Энэхүү аргагүйн дагуу цахим орчны халдлагад өртөж байсан байдлыг найзаар нь төлөөлүүлэн тодруулсан. Ингэхдээ 15 төрлийн цахим орчны халдлагын кэйстэй найзууд нь тулгарч байсан эсэхийг тодруулсан. Ингэхэд зөвхөн 13% нь буюу 10 хүүхдийн 1 нь л эдгээр 15 төрлийн цахим орчны халдлагын алинд нь ч өртөөгүй буюу үлдсэн **87%** нь эдгээрийн аль нэгэнтэй ямар нэгэн байдлаар тохиолдож байсан байна. Үүнийг нарийвчлан харвал, 31%-д нь эдгээрээс 1-2 нь тохиолдож байсан бол 23%-д нь 3-4 тохиолдолтой нь таарч байсан байна. Дунджилж авч үзвэл 1 хүүхэд дунджаар **3.7 тохиолдолтой** таарч байсан байна.

- **43% нь “Цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар манай үе тэнгийн хүүхдүүд ярьж байхыг сонсож байсан”** гэж хариулжээ. Үндэсний Статистикийн Хорооны 2018 оны жилийн эцсийн байдлаар тоон мэдээллээр Монгол Улсад 13-18 насны 267 мянган хүүхэд байгаа. Тиймээс **энэхүү асуудал нь хамгийн багадаа 115 мянган хүүхдийг хамарсан асуудал болж байна.**
- **39% буюу 104 мянган хүүхэд** цахим орчинд байршуулсан **зураг, мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл** (зүй бус, бүдүүлэг үг хэллэгээр доромжлуулах) **авч байсан.** Охидын 42% нь энэ төрлийн халдлагад өртөж байсан нь хөвгүүдээс 6 пунктээр өндөр байна.
- **38% буюу 101 мянган хүүхэд** интернэт, нийгмийн сүлжээгээр **огт танихгүй хүнтэй танилцаж, хэсэг хугацаанд харилцсаны дараа уулзаж байсан.** Энэ халдлага нас нэмэгдэх тусам өсөж байгаа бөгөөд 17-18 насны хүүхдүүдийн 49% буюу 2 хүүхэд тутмын 1 нь онлайнаар танилцсан хүнтэйгээ уулзаж байсан байна.
- **37% буюу 99 мянган хүүхэд** доромжилсон, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн **утга бүхий зураг, видео үл таних хүнээс чат, мессежээр ирж байсан.** Ялангуяа охидын 45%-д нь ийм төрлийн мессеж, чат ирсэн байгаа нь хөвгүүдтэй харьцуулахад өндөр байгаа юм.
- 6% буюу 16 мянган хүүхэд **банкны картын залиланд** өртөж байсан нь бусад цахим халдлагуудтай харьцуулахад **хамгийн бага** үр дүн юм.
- Хүүхдүүдийн **33% буюу 10 хүүхэд тутмын 3 нь садар самууныг сурталчилсан, насанд хүрэгчдэд зориулсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, 34% нь манай үе тэнгийн хүүхдүүд нүцгэн зургаа цахим орчинд тавьж байхыг харж байсан** гэж хариулж байгаагаас харахад цахим орчин нь насанд хүрээгүй хүүхдийн сэтгэхүйд сөрөг нөлөөтэй болохыг дахин дахин харуулсаар байна.

Уг цахим халдлагыг үе тэнгийнхэн нь нэг нэгэндээ үзүүлэх байдал өндөр (**57%**) байгаа тул нэг, нэгэндээ хүндэтгэлтэй хандах талаарх ойлголтыг өгөх нь чухал байна. Ихэвчлэн амьдралын нөхцөл тааруу, эцэг эхийн хараа хяналт сул, бүх насны охид, тэр дундаа бага ангиас дунд ангид шилжиж орж байгаа хүүхдүүд энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байна. Цахим халдлагад өртөх болсон шалтгаан гэнэн итгэмтгий, сониуч зангийн онцлог болоод цахим хэрэглээний талаарх мэдлэггүй байдал юм. Мөн эцэг, эх, багш гэх мэт эргэн тойрны хүмүүс нь хүүхдийг цахим эрсдэлээс хамгаалах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй нь нөлөөлдөг байна.

Цахим дарамтад өртсөн найзуудынх нь **59% нь буюу 10 хүүхэд тутмын 6 нь эцэг, эхдээ хэлж байгаагүй**. Дөнгөж 15% нь л эцэг, эхдээ хэлдэг нь эцэг, эх болон хүүхдүүд хоорондын ойлголцол, харилцаа хангалтгүй байгааг батлан харуулж байна.

Хүүхдүүд өөрийгөө хамгаалах зорилгоор хэн нэгнийг блоклох (67%), нууц үгээ солих (65%), найзаасаа хасаж (62%) байсан байна. Гэхдээ 2 шатат баталгаажуулалт, face recognition унтраах буюу автоматаар tag-лаж болохгүй болгох зэрэг аргуудыг ашиглах хандлага бага байна. Мөн 74% нь танихгүй хүмүүстэй найз болохгүй байх нь өөрийг хамгаалахад хамгийн чухал арг гэжээ.

Интернэтийн зохистой хэрэглээ, хор хөнөөл, урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг телевиз, аав, ээж болон интернэт, фейсбүүкээс авдаг байна. Гэхдээ интернэтийн үйлчилгээ байгууллагаас мэдээлэл авах байдал хамгийн бага байгаа тул энэ талаарх мэдээллийг хэрэглэгчдэдээ заавал өгөхийг шаардах нь зүйтэй.

7-18 насны хүүхэдтэй эцэг, эхийн судалгаа:

Эцэг, эхчүүдийн цахим хэрэглээ хүүхдүүдтэй харьцуулахад бага боловч өдөрт дунджаар 146 минут буюу 2.4 цагийг интернэтэд зарцуулж, ихэвчлэн оройн цагаар интернэт орж сошиал медиа ашиглаж байна. Хамгийн их ашигладаг сошиал медиа нь фейсбүүк (94%), фейсбүүкийн мессенжер (83%) юм.

Эцэг, эхчүүдийн 73% нь хүүхдийнхээ цахим хэрэглээг хянадаг гэж өөрийгөө боддог. Гэхдээ тэд ямар нэгэн технологийн тусламжтайгаар хянадаггүй. Гар утсыг нь үзэж шалгах, цагийн хязгаарлалттай үзүүлэх, утсыг нь хурааж авах, юу үзсэнийг нь харах зэргээр хяналт хийдэг. Эдгээр нь эцэг эхийн цаг заваас шалтгаалж, хяналт хийгдэхгүй байх нөхцөл үүсэх тохиолдолд найдваргүй хяналтын төрлүүд юм. Хүүхдийн гар утасны хэрэглээг хянахад тусалдаг олон төрлийн аппликэйшн байдаг ч тэдгээрийг **96% нь мэддэггүй**. Тиймээс эцэг, эхчүүдэд технологийн тусламжтайгаар хүүхдийнхээ цахим аюулгүй байдалд анхаарал тавьж болдог гэдгийг таниулж, түүнийг ашиглах дадалд сургах хэрэгцээ шаардлага байна. Мөн эцэг, эхчүүдийн **74%** нь гэрийн компьютер, таблет, гар утас зэрэгт хүүхдүүдээ цахим орчноос хамгаалах ямар нэгэн хамгаалалт хийдэггүй, ямар хамгаалалт хийх вэ гэдгийг мэдэхгүй байна.

Хүүхдээ саатуулах зорилгоор **44% нь гар утсаа өгч хэрэглүүлдэг** ба түүний 41% нь 6-аас доош насныхан байна. Хүүхдүүд нь аав, ээжийнхээ гар утсыг аваад тоглоом тоглох, ютубээр видео үзэх нь хамгийн их байдаг. Тиймээс хамгийн ихдээ хэдэн цаг утас ашиглах нь хүүхдийн эрүүл мэндэд болоод сэтгэл зүйд нь сөрөг нөлөөгүй талаарх зөвлөгөөг хүргэх шаардлагатай байна.

13 болон түүнээс дээш настай хүүхдийг фейсбүүкийн хаяг нээхийг зөвшөөрдөг боловч бодит байдал дээр 7-12 насны хүүхдүүдийн 50% нь фейсбүүк хэрэглэж байгаа талаар дээр дурдсан. Гэтэл хэдэн настайгаас ашиглах эрхтэй байдаг гэдгийг **62% нь мэдэхгүй** байна. Мөн хүүхдийнхээ цахим орчин дахь найзуудыг 30% нь огт мэддэггүй, бүх найзуудыг нь мэддэг эцэг, эх зөвхөн 11% нь байна.

Хүүхэд цахим хэрэглээний аюулын төвшнийг бууруулж ойлгож байгаа бол эцэг, эхчүүд эсрэгээрээ нь аюултай гэж үзэх хандлага давамгайлж байлаа. Эцэг эхчүүд цахим орчин хүүхдэд

нь аюултай гэж бодож байгаа ч технологийн талаарх мэдлэг болон гадаад хэлний мэдлэг тааруу байдагтай холбоотойгоор хамгаалалтыг хийж чадахгүй байгааг дээр дурдсан.

Эцэг, эхчүүдийн **91% нь өөрийн хүүхдээ цахим орчны халдлагад өртөж байгаагүй гэж боддог** байна. Гэтэл хүүхдүүдийн судалгаанаас харахад тэдний **87%** нь цахим орчны халдлагад өртөж байсан нь харагдсан. Учир нь хүүхдүүд нь эцэг, эхдээ цахим дарамтад өртсөн гэдгээ хэлдэггүй. Хүүхэд эрсдэлтэй нүүр тулж байгаагаа эцэг эхдээ хэлэхгүй, эцэг эх нь энэ талаар мэдэхгүй байна гэдэг нь цахим халдлагаас үүдэн гарах сөрөг нөлөөг улам ихэсгэж, гүнзгийрэх нөхцөл нь болж байна.

Хэдийгээр эцэг, эхчүүд манай хүүхдүүд цахим халдлагад өртөж байгаагүй гэж байгаа боловч 10 хүн тутмын 4 нь өсвөр насны хүүхдүүд өөрийн нүцгэн зургаа цахим орчинд тавьж байхыг харж байсан, **63%** нь өсвөр насны хүүхэд цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар ярьж байхыг сонсож байсан гэж хариулсан. Энэ нь цахим орчин дах аюул их байгааг бататгаж байна.

10 эцэг, эх тутмын 7 нь хүүхэдтэйгээ интернэт, цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах талаар заавар, зөвлөгөө байнга өгч, ярилцдаг гэж байгаа нь сайшаалтай ч тэдний зөвлөгөөг хүүхэд хэрэгжүүлж байгаа эсэх нь эргэлзээтэй юм. Тэд өгсөн заавар зөвлөгөөгөө хэрхэн хэрэгжиж байгааг хянаж чадахгүй байгаа. Эцэст нь дүгнэхэд, бүх насны хүүхдүүд эцэг эх болон асран хамгаалах үүрэгтэй хэн нэгний хараа хяналтгүйгээр цахим орчинд чөлөөтэй зорчиж, цахим орчинд болдог бүхий л эрсдэл, аюулын дунд амьдарсаар байна.



ГУРАВ. СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН

3.1 ХҮҮХЭД БУЮУ 13-18 НАСНЫХАН

1. 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ЦАХИМ ОРЧНЫ ХЭРЭГЛЭЭ


Бүлгийн хураангуй үр дүн

- **13-18 насны хүүхдүүдийн 71% нь өдөр бүр** интернэтэд ордог. Улаанбаатар хотын орон сууцны хороололд амьдардаг хүүхдүүд хамгийн өндөр давтамжтай интернэтийг ашиглаж байна. Нас нэмэгдэх тусам интернэт орох хандлага нэмэгдэж байна.
- Хүүхдүүдийн **80% нь 10-14 насандаа интернэт ашиглаж эхэлсэн** байна. Орон сууцны хороололд амьдардаг хүүхдүүд илүү эрт буюу бага настай байхдаа интернэт ашиглаж үздэг.
- Хүүхдүүдийн **97% нь өөрийн ухаалаг гар утсаараа интернэтэд холбогддог** байна. Орон сууцны хороололд амьдардаг хүүхдүүдийн 40 орчим хувь нь ширээний компьютер, нөүтбүүк зэргийг ашиглаж байгаа нь гэр хороололд амьдардаг хүүхдүүдээс 2-3 дахин өндөр байна.
- Интернэтэд орох боломжтой **өөрийн ухаалаг гар утасгүй хүүхдүүдийн хувьд аав, ээжийнхээ гар утсыг ашиглах хандлагатай** байна. Ээжийнхээ гар утсыг 22% нь, аавынхаа гар утсыг 12% ашигладаг гэжээ.
- **78% нь өөрийн гар утасны мобайл датаг ашиглаж интернэт орж байгаа** нь хамгийн өндөр байна. 58% нь өөрийн болон найз нөхөд, хамаатны гэрийн Wi-Fi ашиглаж байна. Үүрэн холбооны оператор компаниуд болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд цахим орчин дах хүүхэд хамгааллын чиглэлээр тодорхой ажлуудыг хийх нь чухал байна.
- Хүүхдүүдийн хамгийн их ашигладаг сошиал медиа нь **фейсбүүк** байгаа ба дунджаар **4 өөр сошиал медиа** ашиглаж байна. 96% нь фейсбүүк, 89% нь фейсбүүкийн мессенжер, 71% нь ютуб, 63% нь инстаграм, 45% нь тик ток ашигладаг. **Охидын хувьд инстаграм ашиглах** байдал 72% байгаа нь хөвгүүдээс 18 пунктээр, 51% нь тик ток ашиглаж байгаа нь хөвгүүдээс 13 пунктээр, 25% нь снайп чат ашиглаж байгаа хөвгүүдээс 16 пунктээр тус тус өндөр байна.
- Интернэт зарцуулдаг цагийг дунджилж тооцоолбол, **өдөрт дунджаар 240 минут буюу 4 цагийг зарцуулж байна**. Хамгийн их цагийг зарцуулж буй бүлэг нь 17-18 насныхан байгаа бөгөөд 279 минут буюу 4.6 цагийг зарцуулж байна. Хамгийн цагийг зарцуулж байгаа бүлэг нь 13-14 насныхан (212 минут буюу 3.5 цаг) байна.

Бүлгийн дэлгэрэнгүй үр дүн

Хүүхдийн судалгааны хүрээнд сүүлийн 3 сарын хугацаанд 3 сарын хугацаанд өөрийн болон аав,ээж, ах, эгч, эмээ, өвөө, найз нөхөд зэрэг бусад ойр дотнын хүмүүсийн гар утас, таблет, компьютер зэрэг төхөөрөмж ашиглаж интернэтээр видео бичлэг үзэх, фейсбүүк, ютюб зэрэг социал медиа ашиглах, интернэт сайтуудаар зочлох, интернэтээр тоглоом тоглох зэргийн аль нэгийг хийсэн оролцогчдыг судалгаанд хамруулсан. Цахим орчныг ямар давтамжтай ашигладаг болохыг тодруулахад **нийт оролцогчийн 71% нь өдөр бүр** ордог гэжээ. Энэхүү үр дүн нь байршил, одоогийн амьдарч буй сууц, насны ангилал болон хүйсээр ялгаатай байна. Улаанбаатар хотын хүүхдүүдийн 75% нь өдөр бүр интернэтэд орж байгаа нь орон нутгийн хүүхдүүдээс 7 пунктээр өндөр байна.

График 1. Интернэтэд ордог давтамж



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 1.8

Мөн орон сууцны хороололд амьдардаг хүүхдүүдийн 82% нь өдөр бүр интернэтэд ордог бол гэр хороололд амьдардаг хүүхдүүдийн 62% нь өдөр бүр ордог байна. Доорх хүснэгтээс **хөвгүүдээс илүү охид интернэтийг их ашиглаж байгаа** нь харагдаж байна. Насны хувьд **17-18 насныхан хамгийн өндөр давтамжтай** ашиглаж байна.

Хүснэгт 5. Интернэтэд ордог давтамж, хүйс, насны бүлэг, сууцны нөхцөлөөр


	Хүйс		Насны бүлэг			Сууцны нөхцөл		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	13-14 настай	15-16 настай	17-18 настай	Орон сууц	Гэр хороолол	
Өдөр бүр	68%	74%	56%	73%	83%	84%	62%	71%
7 хоногт 4-6 өдөр	17%	13%	23%	14%	8%	11%	18%	15%
7 хоногт 2-3 өдөр	13%	10%	17%	10%	8%	4%	16%	11%
7 хоногт нэг удаа	1%	2%	3%	1%	1%	1%	2%	2%
Сард 2-3 удаа	1%	1%	1%	1%	0%	0%	1%	1%
Сард нэг удаа	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%

Сард нэгээс бага удаа	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%

Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 1.8
Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Судалгаанд оролцсон **хүүхдүүдийн 80% нь 10-14 насандаа интернэт ашиглаж эхэлсэн** байна. Орон сууцны хороололд амьдардаг хүүхдүүдийн хувьд гэр хороололд амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад илүү эрт интернэт ашиглаж үзсэн байгаа нь ажиглагдаж байна. Мөн эрэгтэй хүүхдүүдийн 15% нь 6-9 насандаа интернэт ашиглаж эхэлсэн байгаа нь эмэгтэй хүүхдүүдээс 8 пунктээр өндөр байна.


График 2. Интернэт ашиглаж эхэлсэн нас, хүйс, байршил, сууцны нөхцөлөөр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 1.9

Хүүхдүүдийн 97% нь өөрийн ухаалаг гар утсаараа интернэтэд холбогддог байна. Энэ үр дүн нь байршил, хүйс зэргээр ялгаагүй байна. Гэхдээ нас нэмэгдэх тусам ширээний компьютер, нөүтбүүк зэргийг ашиглах хандлага нэмэгдэж байна. Мөн **орон сууцны хороололд амьдардаг хүүхдүүдийн 40 орчим хувь нь ширээний компьютер, нөүтбүүк** зэргийг ашиглаж байгаа нь гэр хороололд амьдардаг хүүхдүүдээс 2-3 дахин өндөр байна.

График 3. Интернэтэд ордог төхөөрөмж, насны бүлэг, байршил, сууцны төрлөөр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.1

Интернэтэд орох боломжтой өөрийн ухаалаг гар утасгүй хүүхдүүдийн хувьд аав, ээжийнхээ гар утсыг ашиглах хандлагатай байна. Тухайлбал ээжийнхээ гар утсыг 22% нь, аавынхаа гар утсыг 12% ашигладаг гэжээ. Гэртээ байхдаа интернэтэд орох нь хамгийн өндөр байна. Үүний дараа найзынхаа гэрт (27%), сургууль дээр (25%), хамаатны гэрт (23%), кофе шоп (15%-д очиж интернэт ашигладаг байна. Үүнийг задлан харвал, хөвгүүд найзындаа очиж Wi-Fi ашиглах болон компьютер тоглоомын газар очиж, ахлах ангийнхан сургууль дээр болон кофе шопд очиж интернэтэд орох хандлагатай байна.

Хүснэгт 6. Интернэтэд ордог байршил, хүйс, насны бүлэг, сууцны төрлөөр

Байршил	Нийт	Хүйс		Насны бүлэг			Сууцны төрөл	
		Эрэгтэй	Эмэгтэй	13-14 настай	15-16 настай	17-18 настай	Орон сууц	Гэр хороолол
Өөрийн гэртээ	99%	99%	99%	98%	100%	98%	99%	99%
Найзынхаа гэрт	27%	32%	21%	21%	31%	27%	25%	28%
Сургууль дээр	25%	21%	28%	14%	21%	38%	25%	25%
Хамаатан садны гэрт	23%	22%	24%	27%	29%	15%	23%	24%
Кофе шопд	15%	13%	18%	7%	16%	22%	22%	11%
Интернэт кафе	9%	9%	8%	5%	10%	10%	10%	8%
Компьютер тоглоомын газар	6%	11%	1%	5%	6%	8%	5%	7%
Бэйкери	6%	5%	6%	3%	6%	8%	9%	3%
Ажил дээр	3%	4%	2%	0%	3%	6%	2%	4%


Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.3

Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Судалгаанд оролцогчдын 78% нь өөрийн гар утасны мобайл датаг ашиглаж интернэт орж байгаа нь хамгийн өндөр байна. Харин 58% нь өөрийн болон найз нөхөд, хамаатны гэрийн Wi-Fi ашиглаж байна. Тиймээс үүрэн холбооны оператор компаниуд болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд цахим орчин дах хүүхэд хамгааллын чиглэлээр тодорхой ажлуудыг хийх нь чухал болох нь харагдаж байна. Сургуулийн Wi-Fi сүлжээг ашиглаж интернэт орох хандлага бага буюу 9%-тай байна. 13-18 настай хүүхдүүдийн хувьд гэртээ интернэтэд орохдоо аав,

ээжийн эзгүйд буюу гэртээ байхгүй байхад орох хандлага маш өндөр буюу 89% байгааг доорх графикаас харж болно. Харин 7-р ангийн сурагч буюу 13 настнуудын хувьд энэ хандлага хамгийн бага байгаа ба **ахлах ангид орох тусам хараа хяналтгүй ашиглах хандлага нэмэгдэж байна.**


График 4. Аав, ээжийнхээ эзгүйд интернэтэд орох байдал, суралцаж буй ангиар



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.5

Энэ насныхан интернэтэд ороод хамгийн их хийдэг үйлдэл нь сошиал медиа ашиглах байдаг байна. Үүний дараа дуу, клип, бусад видео бичлэг үзэх, найзуудтайгаа чатлах, холбоо барих зэрэг байна. Хүйсээр задлан харвал хөвгүүдийн 64% нь интернэтээр тоглоом тоглох үйлдлийг хамгийн их хийж байхад охидын 63% нь хичээлээ хийх, 53% нь Google-ээс өөрт хэрэгцээтэй мэдээллийг хайх, 49% нь шинэ мэдээ, мэдээлэл авч байна. Охидын хувьд илүү их чатлах, дуу хөгжим сонсох хандлагатай байна. Насны хувьд ч гэсэн ялгаатай зүйлс ажиглагдаж байна. Тухайлбал, 17-18 насныхны 31% нь подкаст (Podcast) сонсож байгаа нь 13-14 насныхантай харьцуулахад 6 дахин өндөр байна. Мөн 11, 12-р ангийн хүүхдүүд төлбөр тооцоо хийх хандлага хамгийн өндөр буюу 15-22% байна.

График 5. Интернет ороод хийдэг зүйлс, хүйсээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.6

Хүүхдүүдийн хамгийн ашигладаг сошиал медиа нь фейсбүүк байгаа ба дунджаар 4 өөр сошиал медиа ашиглаж байна. Ямар, ямар сошиал медиа ашигладаг болохыг тодруулахад, 96% нь фейсбүүк, 89% нь фейсбүүкийн мессенжер, 71% нь ютюб, 63% нь инстаграм, 45% нь тик Ток ашигладаг гэж хариулжээ. Энэ үр дүн нас, хүйсийн хувьд ихээхэн ялгаатай. Охидын хувьд инстаграм ашиглах байдал 72% байгаа нь хөвгүүдээс 18 пунктээр, 51% нь тик ток ашиглаж байгаа нь хөвгүүдээс 13 пунктээр, 25% нь снайп чат ашиглаж байгаа хөвгүүдээс 16 пунктээр тус тус өндөр байна. Бүх насныхан фейсбүүк ашиглах байдал өндөр байгаа ба 15 наснаас эхлэн инстаграм ашиглах хандлага эрс нэмэгдэж байна. Харин 13-14 насныхан тик ток ашиглах хандлага бусад насны бүлэгтэй харьцуулахад бага зэргийн өндөр байна. Ютюб хэрэглэх хандлага нь одоогийн амьдарч буй сууцны нөхцөлөөр ялгаатай байна. Орон сууцанд амьдардаг хүүхдийн 81% нь ютюб, 75% нь инстаграм ашиглаж байгаа нь гэр хорооллын

хүүхдүүдээс 17-20 пунктээр илүү байна. Мэдээж хэрэг ютуб, инстаграм ашиглахад их дата зарцуулдагтай холбоотой.

График 6. Ашигладаг сошиал медиа, хүйс, насны бүлэг, байршил, сууцны нөхцөлөөр


Сошиал медиа	Нийт	Хүйс		Насны бүлэг			Байршил		Сууцны нөхцөл	
		Эрэгтэй	Эмэгтэй	13-14 настай	15-16 настай	17-18 настай	УБ	Орон нутаг	Орон сууц	Гэр хороолол
Фейсбүүк	96%	95%	97%	95%	98%	96%	96%	96%	96%	96%
Фейсбүүк мессенжер	89%	89%	90%	85%	92%	90%	92%	87%	90%	89%
Ютуб	71%	72%	70%	64%	73%	74%	76%	67%	81%	64%
Инстаграм	63%	54%	72%	42%	67%	78%	68%	60%	75%	55%
Тик Ток	45%	38%	51%	55%	41%	39%	46%	44%	41%	48%
Снайп чат	17%	9%	25%	17%	19%	15%	22%	13%	18%	16%
Саунд клоуд	8%	8%	8%	1%	6%	15%	13%	4%	12%	5%
Твиттер	7%	6%	8%	3%	9%	10%	8%	6%	10%	5%
Уатс апп	4%	3%	5%	2%	3%	5%	7%	1%	4%	3%
Вибер	3%	2%	4%	1%	3%	4%	5%	1%	5%	1%
Скайп	3%	2%	3%	1%	2%	5%	5%	1%	5%	1%

Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.7

Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Өдөрт нийт хэдэн цагийг интернэт орчинд зарцуулдаг болохыг тодруулахад, 9% нь 1 цаг хүртэлх хугацааг зарцуулдаг бол 19% нь 2 цаг хүртэлх хугацааг зарцуулдаг гэжээ. Харин 20% нь өдөрт 6 болон түүнээс дээш цагийг интернэт орчинд зарцуулж байна.

График 7. Өдөрт интернэт орчинд зарцуулдаг цаг



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.8

Интернэт зарцуулдаг цагийг дунджилж тооцоолбол, 13-18 насныхан дунджаар өдөрт 240 минут буюу 4 цагийг зарцуулж байна. Хамгийн их цагийг зарцуулж буй бүлэг нь 17-18 насныхан байгаа бөгөөд 279 минут буюу 4.6 цагийг зарцуулж байна. Эсрэгээрээ хамгийн бага цагийг зарцуулж байгаа бүлэг нь 13-14 насныхан (212 минут буюу 3.5 цаг) байна.

Хүснэгт 7. Интернэтэд зарцуулдаг дундаж хугацаа, минутаар, ялгаатай бүлгээр

Хугацаа	Нийт	Хүйс		Насны бүлэг			Байршил		Сууцны нөхцөл	
		Эрэгтэй	Эмэгтэй	13-14 настай	15-16 настай	17-18 настай	УБ	Орон нутаг	Орон сууц	Гэр хороолол
Минут	240	231	248	183	249	279	258	226	277	212
Цаг	4.0	3.9	4.1	3.0	4.2	4.6	4.3	3.8	4.6	3.5

2. 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ФЕЙСБҮҮКИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ОНЦЛОГ


Бүлгийн хураангуй үр дүн

- 10 хүүхэд тутмын 8 буюу **77%-д нь фейсбүүкийн 1-с олон хаягтай найз байдаг**. Тэдгээр **найзууд нь дунджаар 3-4 хаягтай**. Хүүхдүүд өөрт байгаа фейсбүүкийн хаягийн тоог бууруулж хэлэх хандлагатай байдаг тул гуравдагч бие болох найзад нь байгаа фейсбүүкийн хаягийн тоогоор төлөөлүүлж авах нь оновчтой байдаг.
- Хөвгүүд охидоос арай олон хаяг ашиглаж байгаа** хандлага ажиглагдсан ба 15-16 насныхан бусад насны бүлэгтэйгээ харьцуулахад арай олон хаяг ашиглаж байв.
- Өөрт нь фейсбүүкийн хэдэн хаяг байгааг тодруулахад, **67% нь зөвхөн нэг л хаяг, 26% нь 2 хаяг, 7% нь 3 болон түүнээс болон хаяг бий** гэж хариулжээ.
- Илүү хаягаараа 61% нь бусадтай чатлах, танилцах, 36% нь эцэг, эхийн хяналтгүй сошиал медиа ашигладаг**. Охидын 44% нь эцэг, эхийн хяналтгүй сошиал ашиглах зорилготой байгаа нь хөвгүүдээс 15 пунктээр өндөр байна.
- 80% нь танихгүй хүнээс найз болох хүсэлт ирвэл, түүнийг хүлээж авдаггүй, 20% нь хүлээж авдаг гэж байгаа боловч 60% нь фейсбүүкийн найзууд дунд мэдэхгүй, танихгүй хүн байдаг** гэж хариулжээ. Хэрэв танихгүй хүнээс найз болох хүсэлт ирвэл хүлээж авах магадлалтай бүлэг нь 15-18 насны хөвгүүд байна.
- Фейсбүүкийн шинэ найзтай болохдоо 79% нь сайн таньдаг дундын найзууд байгаа эсэхийг шалгадаг, 57% нь профайл зургийг харж байна. Өөрөөр хэлбэл, фейсбүүкийн шинэ найзтай болоход **өөрийнх нь найзтай нь найз болсон байх, гоё профайл зурагтай байхад л хангалттай** байна.
- Интернэтийн бүртгэл хийхдээ **өөрийн нэр, зураг, хүйс зэргийг үнэн зөв оруулдаг**. Өөрийн гар утасны дугаараа хөвгүүдийн 68% нь оруулж байгаа нь охидоос 12 пунктээр илүү байна. Мөн хөвгүүдийн 35% буюу 10 хүүхэд тутмын 3-4 нь гэрийн хаягаа, 63% нь сурдаг сургуулиа оруулж байна.
- "Хэрвээ чамд интернэт хэрэглээний эрх өгье гэвэл хувийн мэдээллээ өгөх үү?" гэсэн туршилт асуултыг асуусан. Ингэхэд **94% нь үгүй гэж хариулсан** бол 4% нь хувийн мэдээллээ өгнө, 2% нь хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ.

Бүлгийн дэлгэрэнгүй үр дүн

Өөр сонирхолтой бас хүүхдүүдэд эрсдэлтэй байж болохуйц үр дүн гарсан нь 10 хүүхэд тутмын 8 буюу 77%-д нь фейсбүүкийн 1-с олон хаягтай найз байдаг байна. Тэдгээр найзууд нь дунджаар 3-4 хаягтай гэж хариулжээ. Улмаар өөрт нь фейсбүүкийн хэдэн хаяг байгааг тодруулахад, 67% нь зөвхөн нэг л хаяг, 26% нь 2 хаяг, 7% нь 3 болон түүнээс болон хаяг бий гэж хариулжээ. Ийм төрлийн асуултад **хүүхдүүд өөрт байгаа фейсбүүкийн хаягийн тоог бууруулж хэлэх хандлагатай байдаг тул гуравдагч бие болох найзад нь байгаа фейсбүүкийн хаягийн тоогоор төлөөлүүлж авах нь оновчтой байдаг.** Судалгаанд хамрагдсан хүүхдүүд дунд хамгийн ихдээ 10 фейсбүүкийн хаягтай хүүхэд байсан нь маш олон хаяг ашиглаж байгааг харуулж байна. Мөн хөвгүүдийн хувьд охидоос арай олон хаяг ашиглаж байгаа хандлага ажиглагдсан ба 15-16 насныхан бусад насны бүлэгтэйгээ харьцуулахад арай олон хаяг ашиглаж байв.

График 8. Фейсбүүкийн хаягийн тоо



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.10, 2.12

13-18 насныхан фейсбүүкийн илүү хаягаа ямар зорилгоор ашиглаж байгааг тодруулсан. Ингэхэд **61% нь бусадтай чатлах, танилцах, 36% нь эцэг, эхийн хяналтгүй сошиал медиа ашиглах** гэж хариулсан нь анхаарал татсан юм. Охидын 44% нь эцэг, эхийн хяналтгүй сошиал ашиглах зорилготой гэж хариулсан нь хөвгүүдээс 15 пунктээр өндөр байна. Харин уг үр дүн нас, байршил, сууцны төрөл зэргээр ямар нэгэн ялгаа байсангүй. Мөн **live stream үзэх, видео шэйрлэх, зарим групп руу орох, үзэл бодлоо илэрхийлэх, зургаа хадгалах, зар байршуулах зэрэг бусад зорилгоор** ашигладаг байна.


График 9. Фейсбүүкийн илүү хаягаа ашигладаг зорилго



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.11

Судалгаанд оролцсон **хүүхдүүдийн 80% нь танихгүй хүнээс найз болох хүсэлт ирвэл, түүнийг хүлээж авдаггүй, 20% нь хүлээж авдаг гэж байгаа боловч 60% нь фейсбүүкийн найзууд дунд чиний мэдэхгүй, танихгүй хүн байдаг гэж хариулжээ. Хэрэв танихгүй хүнээс найз болох хүсэлт ирвэл хүлээж авах магадлалтай бүлэг нь 15-18 насны хөвгүүд байна.** Харин охидын хувьд 15% нь танихгүй хүнээс ирсэн найзын хүсэлтийг хүлээж авдаг гэжээ. Нөгөө талаасаа охидын 58%-д нь фейсбүүкийн найзууд дунд мэдэхгүй, танихгүй хүн байдаг гэсэн нь хөвгүүдээс дөнгөж 4 пунктээр бага байна. Тиймээс мэдэхгүй, танихгүй хүнтэй найз болохгүй байх, хэрэв болсон байгаа бол unfriend хийх зэрэг кампанит ажлыг дахин хийх шаардлага байгаа нь харагдаж байна.


График 10. Фейсбүүкийн найзын хүсэлт хүлээн авах хандлага болон танихгүй хүнтэй найз болсон байдал, хүйс, насны бүлэг, байршлаар



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.13 болон 2.15

Фейсбүүкийн шинэ найзтай болохдоо 79% нь сайн таньдаг дундын найзууд байгаа эсэхийг шалгадаг, 57% нь профайл зургийг харж байгаа нь шинэ найзтай болох шалгуур нь хангалттай өндөр түвшинд байхгүй байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, **фейсбүүкийн шинэ найзтай болоход өөрийнх нь найзтай нь найз болсон байх, гоё профайл зурагтай байхад л хангалттай** байна. Охидын хувьд хөвгүүдтэй харьцуулахад бага зэргийн шаардлага өндөр байх хандлага ажиглагдаж байна.


График 11. Фейсбүүкийн шинэ найзтай болоход чухалчилж хардаг зүйлс



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.14

Цахим орчны аюулгүй байдлын хүрээнд анхаарвал зохих өөр нэг үр дүн байгаа нь 13-18 насны хүүхдүүд интернэтийн бүртгэл хийхдээ өөрийн нэр, зураг, хүйс зэргийг үнэн зөв оруулдаг гэжээ. Охидын хувьд 84% нь өөрийн зургаа оруулж байгаа хөвгүүдээс 14 пунктээр өндөр байгаа нь анхаарал татаж байна. Мөн 2 охин тутмын 1 нь буюу 57% нь сурдаг сургуулиа, 5 охин тутмын 1 нь буюу 22% нь гэрийн хаягаа үнэн зөв бүртгүүлдэг гэжээ. Харин хөвгүүдийн хувьд өөрийн гар утасны дугаараа 68% нь оруулж байгаа нь охиноос 12 пунктээр илүү байгаа юм. Мөн хөвгүүдийн 35% буюу 10 хүүхэд тутмын 3-4 нь гэрийн хаягаа, 63% нь сурдаг сургуулиа оруулж байна. Ялангуяа хамгийн их хувийн мэдээллээ оруулдаг бүлэг нь 15-16 насныхан байна. Мөн нас нэмэгдэх тусам өөрийн хувийн зургаа оруулах хандлага нэмэгдэж байна. Тиймээс цахим орчны эрсдэлтэй байдлаас өөрсдийгөө хамгаалахын тулд хувийн мэдээллээ оруулахгүй байх талаар заавар зөвлөмжийг өгөх нь зүйтэй болох нь эндээс харагдаж байна.


График 12. Интернет орчинд бүртгэл хийхдээ оруулдаг хувийн мэдээлэл, хүйсээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.17

Хувийн мэдээллээ алдах нь цахим орчны халдлагад өртөх гол шалтгааны нэг болдог. Тиймээс ямар тохиолдолд өсвөр насныхан хувийн мэдээллээ өгдөг болохыг олж илрүүлэх зорилгоор **“Хэрвээ чамд интернет хэрэглээний эрх өгье гэвэл хувийн мэдээллээ өгөх үү?” гэсэн туршилт асуултыг асуусан. Ингэхэд 94% нь үгүй гэж хариулсан бол 4% нь хувийн мэдээллээ өгнө, 2% нь хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ.** Охидын хувьд 95% нь хувийн мэдээллээ өгөхгүй байгаа нь хөвгүүдээс 2 пунктээр илүү байна. Хэдийгээр хүүхдүүд хувийн мэдээллээ интернетийн эрхээр солихгүй гэж байгаа боловч тухайн нөхцөл байдлаас хамаарч өөр хариу үйлдэл үзүүлэх эрсдэлтэй.

График 13. Интернетийн эрх өгье гэвэл хувийн мэдээллээ бусдад өгөх эсэх



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 2.18

3. 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ЦАХИМ ОРЧИН ДАХ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ

Бүлгийн хураангуй үр дүн


- Интернэтээр видео бичлэг үзэх, фейсбүүк, ютюб зэрэг сошиал медиа ашиглах, интернэт сайтуудаар зочлох, интернэтээр холбогдож тоглоом тоглох зэрэг нь ямар ч аюулгүй гэж 24% нь, бага зэргийн аюултай байж магадгүй гэж 41% нь хариулсан. Өөрөөр хэлбэл **10 хүүхэд тутмын 6-7 нь интернэтийг аюулгүй гэж үзэж байна.** Харин 26% нь ер нь бол аюултай, зөвхөн 7% нь маш аюултай, үлдсэн 2% нь хэлж мэдэхгүй буюу 10 хүүхэд тутмын 3-4 нь интернэт орчныг аюултай гэж үзэж байна.
- Хүүхдүүдийн **25% буюу 10 хүүхэд тутмын 2-3 нь хувийн мэдээллээ бусдад алдах аюултай** гэж үзэж байна. Үүний дараа дөнгөж 9% нь хакердуулах, фейсбүүкийн нууц үг, бусад мэдээллээ алдах болон нүдний хараа муу болох аюул бий гэж үнэлж байна.
- **70% нь хэн нэгэнд хувийн мэдээллээ чатаар хэлэх, өгөх болон чатаар танилцсан хэн нэгэнтэй биечлэн уулзах нь хамгийн их эрсдэлтэй** гэж хариулсан. Мөн танихгүй хүнтэй чатлах гэж 68%, танихгүй хүнтэй фейсбүүкийн найз болох, интернэтийн сайтуудад бүртгэл хийхдээ хувийн мэдээллээ өгөх гэж 51% нь үзэж байна. Live-stream апп-ууд ашиглах, онлайнаар холбогдож тоглоом тоглох нь эрсдэлтэй гэж 15-19% нь үзэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт боллоо.
- Хүүхдүүдийн **93% нь интернэт орчноор дамжуулан үйлдсэн гэмт хэргийн талаар ямар нэгэн байдлаар сонсож байсан** байна.
- **55% нь үнэгүй Wifi интернэт ашиглаж байхдаа өөрийн банкны нэвтрэх нэр, нууц үгээ ашиглан гүйгээ хийх нь эрсдэлтэй** гэдгийг, **79% нь төрөл бүрийн сонжоо, таавар, азаа үзэх зэрэг холбоос дээр дарснаар хувийн мэдээлэл, фейсбүүкийн нууц үг, хаяг, дансны мэдээллээ бусдад алдах эрсдэлтэй байдаг гэдгийг сонсож байсан** байна. Хүүхдүүд эдгээр эрсдэлийн талаар сонсож байсан нь эдгээр эрсдэлээс хамгаалах арга хэмжээг авдаг гэж шууд дүгнэж хэлж болохгүй.
- Найзуудаас ирсэн холбоос бүхий мэдээллийг дарж үзэх хандлагыг тодорхойлсон. **Ингэхэд 52% буюу 2 хүүхэд тутмын 1 нь хэрэв сонирхолтой мэдээлэл байвал шууд дарж үздэг** гэжээ. Харин 23% буюу 4 хүн тутмын 1 нь найдвартай эх үүсвэрийн мэдээлэл эсэхийг нягталж үзсэний дараа үздэг байна. Үлдсэн 25% нь найзуудаасаа ирсэн холбоос бүхий мэдээллийг үздэггүй гэсэн байна.
- Хүүхдүүдийн хуурамч хаягийг таних аргуудаас алийг нь мэдэж байгаа болохыг тодруулахад **68% нь хуурамч зураг болон бусдын нэр ашигласан эсэхийг нягтлан хардаг, 57% нь тухайн хаягт дундын найз байдаг эсэхийг шалгадаг** байна. Үүний дараа нэрийг нь нягтлах, тухайн хаягийг нээсэн он, сар, өдрийг харах, найзуудаасаа асуух зэрэг үйлдлийг хийдэг байна. Харин **14% нь л чатаар зурвас бичиж нягталдаг** байна.

Бүлгийн дэлгэрэнгүй үр дүн

Өмнөх бүлэгт 13-18 насныхны интернэтийг орчныг хэрхэн, хаана, ямар давтамж, ямар төхөөрөмжөөр, өдөрт хэдэн цагийг зарцуулдаг болохыг талаар дэлгэрэнгүй авч үзсэн. Харин энэ бүлгээр 13-18 насны хүүхдүүдийн цахим орчны аюулгүй байдлын талаарх мэдлэгийн түвшин ямар байгааг тодорхойлсон.

Интернэтээр видео бичлэг үзэх, фейсбүүк, ютуб зэрэг сошиал медиа ашиглах, интернэт сайтуудаар зочлох, интернэтээр холбогдож тоглоом тоглох зэрэг нь чамд аюул учруулна гэж боддог талаар тодруулахад, 24% нь ямар ч аюулгүй, 41% нь бага зэргийн аюултай байж магадгүй буюу 10 хүүхэд тутмын 6-7 нь аюулгүй гэж үзэх талдаа байна. Харин 26% нь ер нь бол аюултай, зөвхөн 7% нь маш аюултай, үлдсэн 2% нь хэлж мэдэхгүй буюу 10 хүүхэд тутмын 3-4 нь интернэт орчныг аюултай гэж үзэж байгаагаас харахад энэ талаарх мэдлэг, ойлголт хангалттай байхгүй байгааг харуулж байна. Интернэт орчныг аюултай гэж үзэх хандлага охидын хувьд бага зэргийн өндөр буюу 38% нь аюултай гэж үзэж байна. Энэ нь хөвгүүдээс 10 пунктээр өндөр байгаа юм. Харин насны хувьд авч үзэхэд 13-14 насны хүүхдүүдийн 36% нь аюултай гэж үзэж байгаа нь бусад насны бүлгээс хамгийн өндөр байна. Гэхдээ энэ үр дүн бусад насны бүлгээс дөнгөж 3-6 пунктээр л илүү байгаа нь хангалтгүй юм.


График 14. Интернэтэд орох нь хэр зэрэг аюултай гэж үзэж байгаа болох, хүйс, насны бүлгээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.1

Судалгааны хүрээнд интернэт орчинд ямар, ямар аюул учруулж болох вэ гэдгийг тодруулсан. Хүүхдүүдийн 25% буюу 10 хүүхэд тутмын 2-3 нь хувийн мэдээллээ бусдад алдах аюултай гэж үзэж байна. Үүний дараа дөнгөж 9% нь хакердуулах, фейсбүүкийн нууц үг, бусад мэдээллээ алдах болон нүдний хараа муудах аюул бий гэж үнэлж байна. Өөрөөр хэлбэл хүүхдүүд цахим орчны эрсдэлийн түвшнийг хэт багаар дүгнэж байж болзошгүй зүйл харагдаж байна.

График 15. Интернет орчин ямар аюул учруулна гэж бодож байгаа болох



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.2

Хүүхдүүдийн мэдлэгийн түвшнийг тодорхойлох өөр нэгэн асуулт нь найзуудаас ирсэн холбоо бүхий мэдээллийг дарж үзэх хандлагыг тодорхойлсон. Ингэхэд 52% буюу 2 хүүхэд тутмын 1 нь хэрэв сонирхолтой мэдээлэл байвал шууд дарж үздэг гэж хариулжээ. Харин 23% буюу 4 хүн тутмын 1 нь найдвартай эх үүсвэрийн мэдээлэл эсэхийг нягталж үзсэний дараа үздэг байна. Үлдсэн 25% нь найзуудаасаа ирсэн холбоос бүхий мэдээллийг үздэггүй гэсэн байна. Энэ хандлага хүйсийн хувьд бага зэргийн ялгаатай буюу хөвгүүдийн хувьд шууд дарж үзэх хандлага 56%-тай байгаа бол охидын хувьд 48%-тай байна.


График 16. Найзуудаасаа ирсэн холбоос бүхий мэдээллийг дарж үзэх байдал, хүйсээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.3

Хүүхдүүдийн цахим орчны мэдлэг, хандлагыг тодорхойлох зорилгоор учирч болох эрсдэлийг оролцогч нарт харуулж, аль нь хамгийн их эрсдэл учруулна гэж бодож байгааг тодруулсан. Ингэхэд судалгаанд оролцогчдын 70% нь хэн нэгэнд хувийн мэдээллээ чатаар хэлэх, өгөх болон чатаар танилцсан хэн нэгэнтэй биечлэн уулзах нь хамгийн их эрсдэлтэй гэж дүгнэж байна. Үүний дараа хамгийн их эрсдэлтэй нь танихгүй хүнтэй чатлах гэж 68%, танихгүй хүнтэй фейсбүүкийн найз болох, интернэтийн сайтуудад бүртгэл хийхдээ хувийн мэдээллээ өгөх гэж 51% нь үзэж байна. Эсрэгээрээ Live-stream апп-ууд ашиглах, онлайнаар холбогдож тоглоом тоглох нь эрсдэлтэй гэж 15-19% нь үзэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна. Эдгээр үр дүн хүйсээр ихээхэн ялгаатай харагдаж байна. Охидын хувьд танихгүй хүнтэй чатлах, танилцсан хүнтэйгээ биечлэн уулзах, чатаар хувийн мэдээллээ өгөхгүй байх нь хамгийн өндөр эрсдэлтэй гэж үзэж байгаа нь хөвгүүдээс 13-17 пунктээр өндөр байна.

График 17. Хамгийн их эрсдэл учруулна гэж бодож байгаа зүйлс, хүйсээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.4

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 93% нь интернэт орчноор дамжуулан үйлдсэн гэмт хэргийн талаар ямар нэгэн байдлаар сонсож байсан байна. Мөн 55% нь үнэгүй Wifi интернэт ашиглаж байхдаа өөрийн банкны нэвтрэх нэр, нууц үгээ ашиглан гүйгээ хийх нь эрсдэлтэй гэдгийг, 79% нь төрөл бүрийн сонжоо, таавар, азаа үзэх зэрэг холбоос дээр дарснаар хувийн мэдээлэл, фейсбүүкийн нууц үг, хаяг, дансны мэдээллээ бусдад алдах эрсдэлтэй байдаг гэдгийг сонсож байсан байна. Хэдийгээр хүүхдүүд эдгээр эрсдэлийн талаар сонсож байсан нь эдгээр эрсдэлээс хамгаалах арга хэмжээг авдаг гэж шууд дүгнэж хэлж болохгүй.

График 18. Цахим орчны гэмт хэрэг, эрсдэлийн талаар сонсож байсан байдал




Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.5, 3.6 болон 3.7

Дээрх үр дүн нас, хүйсийн хувьд ялгаатай зүйлс байхгүй байна. Гэхдээ 13-14 насны охидын хувьд дээрх эрсдэлийн талаар сонсож байсан хандлага бусад бүлгээс бага байгаа нь эдгээр бүлэгт мэдээлэл хүргэх шаардлагатай байгааг харуулж байна.

Цахим орчин дах дарамт хуурамч хаягаас хамгийн их ирэх хандлагатай байдаг талаар судалгааны материалуудад дурдсан байдаг. Мөн өсвөр насны хүүхдүүд фейсбүүкийн шинэ найзтай болохдоо зөвхөн профайл зургийг нь харах болон өөрийн найзуудтай нь найз байвал уг хүнийг найзаараа авах хандлагатай байдаг нь дээр харагдсан. Тиймээс **хүүхдүүдийн хуурамч хаягийг таних аргуудаас алийг нь мэдэж байгаа болохыг олж илрүүлэхийг зорьсон. Ингэхэд 68% нь хуурамч зураг болон бусдын нэр ашигласан эсэхийг нягтлан хардаг, 57% нь тухайн хаягт дундын найз байдаг эсэхийг шалгадаг байна. Үүний дараа нэрийг нь нягтлах, тухайн хаягийг нээсэн он, сар, өдрийг харах, найзуудаасаа асуух зэрэг үйлдлийг хийдэг байна. Харин 14% нь л чатаар зурвас бичиж нягталдаг байна.** Тиймээс хуурамч хаягийг таних аргачлалуудыг хүүхдүүдэд ойлгуулах, хуурамч хаягтай найз болсноор ямар эрсдэлд өртөж болох зэрэг талаар ойлгуулах нь ач холбогдолтой байна. Мөн охидын хувьд шинэ найзтай болохдоо хөвгүүдтэй харьцуулахад илүү баталгаажуулалт хийх хандлагатай байгаа нь судалгааны үр дүнд ажиглагдаж байна.

График 19. Хуурамч хаягийг таних аргуудыг ашиглаж буй байдал,



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.10

4. 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ЦАХИМ ОРЧНЫ ХАЛДЛАГАД ӨРТӨЖ БАЙСАН БАЙДАЛ

Бүлгийн хураангуй үр дүн

- Цахим орчны аюулгүй байдал, эрсдэлд өртөж байсан байдлыг хүүхдүүдээс шууд асуух нь тухайн хүүхдэд нэлээд эмзэг сэдэв байдаг. Улмаар хүүхдүүдэд таагүй зүйлээ дурсан санах, сэтгэлээр унах, эмзэг байдлаа мэдрэх гэх мэт зүйл тохиолдох эрсдэлтэй. **Олон улсын туршлагаас харахад нийгмийн аливаа эмзэг асуудлыг гуравдагч бие дээр асуух байдлаар тодорхойлдог.** Энэхүү аргазүйн дагуу судалгааны асуулгыг асуухдаа судалгаанд оролцогч өөрөө цахим орчны халдлагад өртөж байсан эсэхийг тодруулахгүйгээр гуравдагч бие дээр буюу найзад нь тохиолдож байсан эсэхийг тодруулсан. Өөрөөр хэлбэл, хэрэв найз нь цахим орчны халдлагад өртөж байсан бол судалгаанд оролцогч өөрөө халдлагад өртсөн байх магадлалтай гэж үзсэн болно.
- 43% нь **“Цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар манай үе тэнгийн хүүхдүүд ярьж байхыг сонсож байсан”** гэж хариулжээ. Үндэсний Статистикийн Хорооны 2018 оны жилийн эцсийн байдлаар тоон мэдээллээр Монгол Улсад 13-18 насны 267 мянган хүүхэд байгаа. Тиймээс **энэхүү асуудал нь хамгийн багадаа 115 мянган хүүхдийг хамарсан асуудал болж байна.**
- Цахим орчинд байршуулсан **зураг, мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл** (зүй бус, бүдүүлэг үг хэллэгээр доромжлуулах) **авч байсан** (39%) нь дараагийн хамгийн их өртсөн цахим дарамт болж байна. Охидын 42% нь энэ төрлийн халдлагад өртөж байсан нь хөвгүүдээс 6 пунктээр өндөр байна. Тиймээс энэ төрлийн цахим халдлага эрэгтэй, эмэгтэй гэлгүй бүх хүүхдүүд өртөж байсан байна.
- Гуравдах том эрсдэл нь **интернэт, нийгмийн сүлжээгээр огт танихгүй хүнтэй танилцаж, хэсэг хугацаанд харилцсаны дараа уулзаж байсан явдал** гэж 38% буюу 10 хүүхэд тутмын 4 нь хариулжээ. Энэ халдлага нас нэмэгдэх тусам өсөж байгаа бөгөөд 17-18 насны хүүхдүүдийн 49% буюу 2 хүүхэд тутмын 1 нь онлайнаар танилцсан хүнтэйгээ уулзаж байсан байна.
- Дөрөв дэх асуудал нь **доромжилсон, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зураг, видео үл таних хүнээс чат, мессежээр ирдэг явдал** (37%) байна. Ялангуяа охидын 45%-д нь ийм төрлийн мессеж, чат ирсэн байгаа нь хөвгүүдтэй харьцуулахад өндөр байгаа юм.
- **Банкны картын залиланд** 6% нь өртсөн байсан гэж хариулж байгаа нь цахим орчин дах бусад халдлагуудтай харьцуулахад **хамгийн бага** байгаа юм.
- Хүүхдүүдээс 15 төрлийн цахим орчны халдлагын кэйстэй найзууд нь тулгарч байсан эсэхийг тодруулсан. Ингэхэд **зөвхөн 13% нь буюу 10 хүүхдийн 1 нь л эдгээр 15 төрлийн цахим орчны халдлагын алинд нь ч өртөөгүй буюу үлдсэн 87% нь эдгээрийн аль нэгэнтэй ямар нэгэн байдлаар тохиолдож байсан байна.** Үүнийг нарийвчлан харвал, 31% нь эдгээр тохиолдлуудын 1-2 нь тохиолдож байсан бол 23%-д нь 3-4 тохиолдолтой нь таарч байсан гэж хариулжээ. Дунджилж авч үзвэл **1 хүүхэд дунджаар 3.7 тохиолдолтой таарч байсан** байна.
- 57% нь үе тэнгийнхний цахим дарамт их байдаг гэж хариулж байгаа бол үлдсэн 43% нь үл таних хүний цахим дарамт их байдаг гэж хариулжээ. Тиймээс өсвөр насныханд нэг, нэгэндээ хүндэтгэлтэй хандах талаарх ойлголтыг өгөх нь чухал байна.

- 92% нь цахим орчинд зураг, мэдээллээ хуваалцахаасаа өмнө бусдыг гомдоох, өөрийгөө ичээх вий гэдгээ сайн бодох хэрэгтэй гэдэгтэй санал нэгдэж байгаа нь хамгийн өндөр байна. Үүний дараа **91% нь доромжилсон, хараалын үг ашигласан, хэн нэгнийг доош нь хийсэн сэтгэгдлүүд хаа сайгүй байдаг гэдэгтэй санал нэгдэж байгаа** нь цахим орчинд бага насны хүүхдүүд хараа хяналтгүйгээр бүх төрлийн сөрөг контентыг үзэж байгааг харуулж байна. Тиймээс **хүмүүсийн хандлагыг өөрчлөх ажлуудыг үе шаттай, тасралтгүй хийх нэн шаардлагатай** байна. Хэдийгээр хүүхдүүдийн 87% нь цахим орчин бол хувийн орон зай биш, нийтийн орон зай юм гэдэгтэй санал нэгдэж байгаа боловч цахим орчныг буруу ашиглах хандлага байгаа болохыг өмнөх үр дүнгүүд харуулсан.
- Хүүхдүүдийн **33% буюу 10 хүүхэд тутмын 3 нь садар самууныг сурталчилсан, насанд хүрэгчдэд зориулсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, 34% нь манай үе тэнгийн хүүхдүүд нүцгэн зургаа цахим орчинд тавьж байхыг харж байсан** гэж хариулж байгаагаас харахад цахим орчин нь насанд хүрээгүй хүүхдийн сэтгэхүйд сөрөг нөлөөтэй болохыг дахин дахин харуулсаар байна.

Бүлгийн дэлгэрэнгүй үр дүн

Цахим орчны аюулгүй байдал, эрсдэлд өртөж байсан байдлыг хүүхдүүдээс асуух нь тухайн хүүхдэд нэлээд эмзэг сэдэв байдаг. Улмаар хүүхдүүдэд таагүй зүйлээ дурсан санах, сэтгэлээр унах, эмзэг байдлаа мэдрэх гэх мэт зүйл тохиолдох эрсдэлтэй. Тиймээс судалгааны мэдээлэл цуглуулалтыг хийхдээ энэхүү эрсдэлийг харгалзаж үзэж ажилласан. Олон улсын туршлагаас харахад нийгмийн аливаа эмзэг асуудлыг гуравдагч биед асуух байдлаар тодорхойлдог. Энэхүү аргазүйн дагуу судалгааны асуулгыг асуухдаа судалгаанд оролцогч өөрөө цахим орчны халдлагад өртөж байсан эсэхийг тодруулахгүйгээр гуравдагч бие дээр буюу найзад нь тохиолдож байсан эсэхийг тодруулсан. Өөрөөр хэлбэл, хэрэв найз нь цахим орчны халдлагад өртөж байсан бол судалгаанд оролцогч өөрөө халдлагад өртсөн байх магадлалтай гэж үзсэн болно.

Судалгааны үр дүнг нэгтгэн харахад сэтгэл эмзэглүүлэм үр дүн гарсан нь судалгаанд оролцогчдын **43% нь “Цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар манай үе тэнгийн хүүхдүүд ярьж байхыг сонсож байсан” гэж хариулжээ.** Өөрөөр хэлбэл 10 хүүхдэд тутмын 4 нь амиа егүүтгэх талаар ярьж байгаа нь маш өндөр үзүүлэлт юм. Тиймээс уг асуудлыг шийдвэрлэх нь ирээдүй хойч үе болсон хүүхдүүдийн хувьд нэн чухал асуудал болсон байна. Уг үр дүнг хүйсээр задлан харахад, охидын 45%, хөвгүүдийн 40% нь энэ талаар ярьж байсан байна. Насны хувьд 17-18 насныхны 49% нь энэ талаар ярьж байсныг сонсож байсан нь хамгийн өндөр байна. Харин 13-14 насныхны хувьд энэ талаар ярьж байхыг сонсож байсан хувь бусад насны бүлэгтэйгээ харьцуулахад хамгийн бага буюу 30%-тай байна. Мөн байршлын хувьд ялгаатай зүйл ажиглагдаа. Улаанбаатар хотын хүүхдүүдийн 47% буюу бараг 2 хүүхэд тутмын 1 нь амиа егүүтгэх талаар үе тэнгийн хэн нэгэн хүүхэд нь ярьж байхыг сонсож байсан бол орон нутгийн хүүхдүүдийн хувьд 39% нь сонсож байсан гэж хариулжээ. Амьдардаг сууцны хувьд бага зэргийн ялгаатай зүйл ажиглагдсан нь орон сууцны хороололд амьдардаг хүүхдүүдийн 45% нь энэ асуудлаар хэн нэгэн ярьж байхыг сонсож байсан нь гэр хороололд амьдардаг хүүхдээс 5 пунктээр өндөр байгаа юм.

Хүснэгт 8. Цахим орчны халдлагад өртөж байсан байдал, хүйс, насны бүлгээр

Нөхцөл	Нийт	Эрэг тэй	Эмэг тэй	13-14 нас	15-16 нас	17-18 нас
Цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар манай үе тэнгийн хүүхдүүд ярьж байхыг сонсож байсан	43%	40%	45%	30%	46%	49%
Би сошиал орчинд байршуулсан зураг, мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл (зүй бус, бүдүүлэг үг хэллэгээр доромжлуулах) авч байсан	39%	36%	42%	37%	43%	36%
Манай найзууд интернэт, нийгмийн сүлжээгээр огт танихгүй хүнтэй танилцаж, хэсэг хугацаанд харилцсаны дараа уулзаж байсан	38%	40%	37%	21%	42%	49%
Манай найзуудад доромжилсон, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зураг, видео үл таних хүнээс чат, мессежээр ирж байсан	37%	30%	45%	32%	39%	41%
Өөрөө мэдээгүй байхад +18 агуулгатай группт орсон байсан тохиолдолд гарч байсан	34%	30%	37%	20%	36%	43%
Чи хөөрхөн юмаа. Уулзах уу. Санхүү хэрэгтэй бол холбогдоорой гэсэн агуулга бүхий мессеж, чат манай найзуудад ирж байсан.	29%	23%	35%	16%	33%	36%

Хуурамч мэдээлэл гэдгийг мэдэлгүйгээр дарж ороод фейсбүүкийн нууц үгээ алдаж байсан	28%	30%	26%	25%	33%	26%
Манай найзууд хувийн зураг, бичлэгээ алдаж, олон нийтэд тараалгуулж байсан	21%	25%	17%	9%	27%	25%
Манай найзууд онлайн худалдааны луйварт өртөж байсан	21%	23%	18%	9%	22%	29%
Манай үе тэнгийн хүүхдүүд насанд хүрэгчдэд зориулсан садар самуун агуулгатай контентыг найзууд руугаа явуулдаг	19%	18%	20%	10%	18%	29%
Үл таних хаягаас интернэт, чатаар манай найзуудтай холбогдож, бэлгийн харилцааны талаар ярилцахыг оролдож байсан	18%	15%	20%	9%	18%	25%
Хэрвээ нүцгэн зураг, хувийн мэдээллээ явуулбал мөнгө өгье гэсэн агуулгатай мессеж манай найзуудад ирж байсан	13%	9%	17%	7%	17%	16%
Кино, видео клипэнд тоглуулна, photo модель болгож өгье гэсэн мессеж, чат үл таних хүнээс ирж байсан	8%	8%	8%	2%	9%	13%
Өөрөө мэдээгүй байхад санамсаргүй байдлаар худалдан авалт хийж, дансан дах мөнгөө алдаж байсан	8%	11%	6%	4%	9%	12%
Манай найзуудын фейсбүүкт оруулсан зургийг нь засаж янзлаад, олон нийтэд тараана эсвэл аав, ээж, гэрийнхэнд нь хэлнэ гэж айлган сүрдүүлж б	8%	6%	10%	5%	12%	6%
Манай найзууд банкны картын залиланд өртөж байсан	6%	8%	4%	2%	7%	8%

Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.8

Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Цахим орчинд байршуулсан зураг, мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл (зүй бус, бүдүүлэг үг хэллэгээр доромжлуулах) авч байсан нь дараагийн цахим орчинд үйлдэгддэг хамгийн том аюул болж байна. Ялангуяа охидын 42% нь энэ төрлийн халдлагад өртөж байсан нь хөвгүүдээс 6 пунктээр өндөр байна. Тиймээс энэ төрлийн **цахим халдлага эрэгтэй, эмэгтэй гэлгүй бүх хүүхдүүд өртөж байсан** болох нь харагдлаа. Гуравдахь том эрсдэл нь интернэт, нийгмийн сүлжээгээр огт танихгүй хүнтэй танилцаж, хэсэг хугацаанд харилцсаны дараа уулзаж байсан явдал гэж 38% буюу 10 хүүхэд тутмын 4 нь хариулжээ. Энэ хандлага нас нэмэгдэх тусам өсөж байгаа бөгөөд 17-18 насны хүүхдүүдийн 49% буюу 2 хүүхэд тутмын 1 нь онлайнаар танилцсан хүнтэйгээ уулзаж байсан байна. Цахим орчинтой холбоотой 4 дэх асуудал нь доромжилсон, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зураг, видео үл таних хүнээс чат, мессежээр ирдэг явдал байна. Ялангуяа охидын 45% нь ийм төрлийн мессеж, чат ирсэн байгаа нь хөвгүүдтэй харьцуулахад өндөр байгаа юм. Мөн 34% нь өөрөө мэдээгүй байхад +18 агуулгатай группт орсон байсан тохиолдолд гарч байсан байна. Ялангуяа 17-18 насны хүүхдүүдэд мэдээгүй байхад хүсээгүй групптээ орчихсон байх хандлага хамгийн өндөр байдаг байна.

Бас нэг анхаарал татахуйц үр дүн гарсан нь санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэсэн утга бүхий мессеж хүлээн авч байсан явдал байна. Чи хөөрхөн юмаа. Уулзах уу. Санхүү хэрэгтэй бол холбогдоорой гэсэн агуулга бүхий мессеж, чат найзуудад нь 17-18 насны хүүхдүүдийн 36%-д ирж байсан нь хамгийн өндөр байна. Ялангуяа охидод ийм агуулгатай мессеж их ирдэг байна. Мэдээлэлгүй байдлаасаа болж хуурамч мэдээлэл гэдгийг мэдэлгүйгээр дарж ороод фейсбүүкийн нууц үгээ алдаж байсан тохиолдол 28%-д нь тохиолдож байсан байна.

Харин 13-18 насны хүүхдүүдийн хувьд банкны картын залиланд 6% нь өртсөн байсан гэж хариулж байгаа нь цахим орчин дах бусад халдлагуудтай харьцуулахад хамгийн бага байгаа юм. Мөн өөрөө мэдээгүй байхад санамсаргүй байдлаар худалдан авалт хийж, дансан дах

мөнгөө алдаж байсан тохиолдол 8%-д нь өртөж байжээ. Хэдийгээр уг санхүү, мөнгөтэй холбоотой залиланд өртсөн байдал бага байгаа боловч бид энэ асуудлаас урьдчилан сэргийлэх ажлыг хийх нь чухал юм. Магадгүй хүүхдүүдийн хувьд банкны карт ашиглах байдал бага байгаа нь санхүүтэй холбоотой эрсдэлд өртөг байдал бага байж болзошгүй юм.

Хүснэгт 9. Цахим орчны халдлагад өртөж байсан байдал, байршил, сууцны төрлөөр

Нөхцөл	Нийт	УБ	Орон нутаг	Орон сууц	Гэр хороолол
Цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар манай үе тэнгийн хүүхдүүд ярьж байхыг сонсож байсан	43%	47%	39%	45%	40%
Би сошиал орчинд байршуулсан зураг, мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл (зүй бус, бүдүүлэг үг хэллэгээр доромжлуулах) авч байсан	39%	43%	36%	38%	40%
Манай найзууд интернэт, нийгмийн сүлжээгээр огт танихгүй хүнтэй танилцаж, хэсэг хугацаанд харилцсаны дараа уулзаж байсан	38%	46%	32%	41%	36%
Манай найзуудад доромжилсон, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зураг, видео үл таних хүнээс чат, мессежээр ирж байсан	37%	44%	33%	39%	37%
Өөрөө мэдээгүй байхад +18 агуулгатай группт орсон байсан тохиолдолд гарч байсан	34%	40%	29%	37%	32%
Чи хөөрхөн юмаа. Уулзах уу. Санхүү хэрэгтэй бол холбогдоорой гэсэн агуулга бүхий мессеж, чат манай найзуудад ирж байсан.	29%	34%	25%	32%	27%
Хуурамч мэдээлэл гэдгийг мэдэлгүйгээр дарж ороод фейсбүүкийн нууц үгээ алдаж байсан	28%	29%	27%	24%	31%
Манай найзууд хувийн зураг, бичлэгээ алдаж, олон нийтэд тараалгуулж байсан	21%	24%	18%	24%	19%
Манай найзууд онлайн худалдааны луйварт өртөж байсан	21%	23%	19%	25%	17%
Манай үе тэнгийн хүүхдүүд насанд хүрэгчдэд зориулсан садар самуун агуулгатай контентыг найзууд руугаа явуулдаг	19%	23%	17%	23%	17%
Үл таних хаягаас интернэт, чатаар манай найзуудтай холбогдож, бэлгийн харилцааны талаар ярилцахыг оролдож байсан	18%	22%	14%	20%	16%
Хэрвээ нүцгэн зураг, хувийн мэдээллээ явуулбал мөнгө өгье гэсэн агуулгатай мессеж манай найзуудад ирж байсан	13%	19%	9%	17%	11%
Кино, видео клипэнд тоглуулна, photo модель болгож өгье гэсэн мессеж, чат үл таних хүнээс ирж байсан	8%	10%	7%	12%	5%
Өөрөө мэдээгүй байхад санамсаргүй байдлаар худалдан авалт хийж, дансан дах мөнгөө алдаж байсан	8%	9%	8%	9%	7%
Манай найзуудын фейсбүүкт оруулсан зургийг нь засаж янзлаад, олон нийтэд тараана эсвэл аав, ээж, гэрийнхэнд нь хэлнэ гэж айлган сүрдүүлж б	8%	9%	7%	6%	9%
Манай найзууд банкны картын залиланд өртөж байсан	6%	6%	5%	6%	6%


Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.8

Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Цахим орчны халдлагад өртөж байсан байдал байршлын хувьд ялгаатай байна. Тухайлбал, Улаанбаатар хотын хүүхдүүд энэ төрлийн халдлагад өртсөн байдал орон нутгийн хүүхдүүдтэй харьцуулахад 10 гаруй пунктээр их байдаг байна. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын хүүхдүүд орон нутгийн хүүхдүүдтэй харьцуулахад цахим орчны халдлагад өртөх эрсдэл өндөр байна. Мөн сууцны нөхцөлөөр задлан харвал, орон сууцанд амьдардаг хүүхдүүд илүү их интернэтэд холбогддогтой холбоотойгоор илүү өртөх магадлалтай болж байна.

Бид хүүхдүүдээс 15 төрлийн цахим орчны халдлагын кэйстэй найзууд нь тулгарч байсан эсэхийг тодруулсан. Ингэхэд зөвхөн 13% нь буюу 10 хүүхдийн 1 нь л эдгээр 15 төрлийн цахим орчны халдлагын алинд нь өртөөгүй буюу үлдсэн 87% нь эдгээрийн аль нэгтэй ямар нэгэн байдлаар тохиолдож байсан байна. Үүнийг нарийвчлан харвал, 31% нь эдгээр тохиолдлуудын 1-2 нь тохиолдож байсан бол 23%-д нь 3-4 тохиолдолтой нь таарч байсан гэж хариулжээ.

График 20. Цахим орчны халдлагад найзууд нь өртөж байсан тохиолдол



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.8

Дунджилж авч үзвэл 1 хүүхэд дунджаар 3.7 тохиолдолтой таарч байсан байна. Үүнийг хүн ам зүйн үзүүлэлтээр задлан харвал ялгаатай хэд хэдэн үр дүн харагдаж байна. 17-18 насны хүүхдүүд 4.43 тохиолдолтой таарч байсан нь хамгийн өндөр байна. Нэгтгэн харвал, эмэгтэй, 17-18 насны, Улаанбаатар хотын, орон сууцны хороололд амьдардаг хүүхэд хамгийн их өртөх эрсдэлтэй бүлэг болж байна.


Хүснэгт 10. Цахим орчны халдлагад найзууд нь өртөж байсан тоо, хүйс, насны бүлэг, байршлаар

Нийт	Хүйс		Насны бүлэг			Байршил		Сууцны нөхцөл	
	Эрэгтэй	Эмэгтэй	13-14 настай	15-16 настай	17-18 настай	УБ	Орон нутаг	Орон сууц	Гэр хороолол
3.7	3.52	3.87	2.37	4.12	4.43	4.26	3.27	3.98	3.70

Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.8

Хүүхдүүдийн багагүй хувь нь цахим орчны халдлагад өртөж байгааг дээрх үр дүнгээр харуулсан. Тэгвэл цахим орчинд хүүхдүүдийн аюулгүй байдлыг алдагдуулж байгаа, компьютерын цаана байгаа эрхэм хэн байгаа вэ гэдгийг мөн тодруулсан. Ингэхэд хачирхалтай үр дүн гарсан нь судалгаанд оролцогчдын **57% нь үе тэнгийнхний цахим дарамт их байдаг гэж хариулж байгаа бол үлдсэн 43% нь үл таних хүний цахим дарамт их байдаг гэж хариулжээ. Эндээс харахад өсвөр насныхан нэг, нэгнээ цахим орчинд гутаан доромжилдог, цахим дарамт хийдэг тул нэг, нэгэндээ хүндэтгэлтэй хандах талаарх ойлголтыг өгөх нь чухал болох нь харагдаж байна.** Уг үр дүнг хүйсээр харвал, хөвгүүдийн 58% нь үе тэнгийнхний цахим дарамт их байдаг гэж хариулсан нь охидтой харьцуулахад 3 пунктээр өндөр, насны бүлгээр харвал 15-16 насныхны 64% нь үе тэнгийнхэн цахим дарамт хийдэг гэж хариулсан нь хамгийн өндөр байна. Мөн үе тэнгийнхний цахим дарамт орон нутгийн хүүхдүүдэд их тохиолддог гэжээ.

График 21. Хэн цахим дарамт хийдэг болох, хүйс, насны бүлэг, байршил, сууцны төрлөөр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 3.9

Судалгааны хүрээнд хүүхдүүдийн хандлагыг тодорхойлох асуултуудыг асуусан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 92% нь цахим орчинд зураг, мэдээллээ хуваалцахаасаа өмнө бусдыг гомдоох, өөрийгөө ичээх вий гэдгээ сайн бодох хэрэгтэй гэдэгтэй санал нэгдэж байгаа нь хамгийн өндөр байна. Үүний дараа 91% нь доромжилсон, хараалын үг ашигласан, хэн нэгнийг доош нь хийсэн сэтгэгдлүүд хаа сайгүй байдаг гэдэгтэй санал нэгдэж байгаа нь цахим орчинд бага насны хүүхдүүд хараа хяналтгүйгээр бүх төрлийн сөрөг контентыг үзэж байгааг харуулж байна. Тиймээс хүмүүсийн хандлагыг өөрчлөх ажлуудыг үе шаттай, тасралтгүй хийх нэн шаардлагатай байна. Хэдийгээр хүүхдүүдийн 87% нь цахим орчин бол хувийн орон зай биш, нийтийн орон зай юм гэдэгтэй санал нэгдэж байгаа боловч цахим орчныг буруу ашиглах хандлага байгаа болохыг өмнөх үр дүнгүүд харуулсан.

Хүүхдүүдийн 33% буюу 10 хүүхэд тутмын 3 нь садар самууныг сурталчилсан, насанд хүрэгчдэд зориулсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, 34% нь манай үе тэнгийн хүүхдүүд нүцгэн зургаа цахим орчинд тавьж байхыг харж байсан гэж хариулж байгаагаас харахад цахим орчин нь насанд хүрээгүй хүүхдийн сэтгэхүйд сөрөг нөлөөтэй болохыг дахин дахин харуулсаар байна.

График 22. Цахим орчны талаарх хүүхдүүдийн хандлага



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.14

5. 13-18 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ АРГА ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ БАЙДАЛ БОЛОН МЭДЭЭЛЭЛ АВДАГ СУВАГ

Бүлгийн хураангуй үр дүн

- Цахим орчны дарамтад өртсөн найзуудынх нь **59% нь буюу 10 хүүхэд тутмын 6 нь эцэг, эхдээ хэлж байгаагүй**. Дөнгөж 15% нь л эцэг, эхдээ хэлдэг байгаа нь эцэг, эх болон хүүхдүүд хоорондын ойлголцол, харилцаа хангалтгүй байгааг харуулж байна.
- **Өөрийгөө хамгаалах зорилгоор 67% буюу 10 хүүхэд тутмын 7 нь хэн нэгнийг блоклож байсан** байна. Зарим хүүхдүүдийн хувьд технологийн мэдлэг, гадаад хэлний мэдлэгээс хамаарч нууц үгээ сольж чадахгүй байх тохиолдол байдаг. 65% нь цахим орчинд өөрийгөө илүү аюулгүй болгох үүднээс нууц үгээ сольж байсан бол 62% нь хэн нэгнийг найзаасаа хасаж байсан байна. Охид эдгээр үйлдлүүдээс хөвгүүдээс ойролцоогоор 20 пунктээр илүү их хийсэн байгаагаас харахад цахим орчны дарамт, халдлагын гол өртөж буй бүлэг нь болохыг баталж байгаа юм. Гэхдээ 2 шатат баталгаажуулалт, face recognition унтраах буюу автоматаар tag-лаж болохгүй болгох зэрэг аргуудыг ашиглах хандлага бага байна.
- Хүүхдүүдийн **45% нь only friends тохиргоотойгоор фейсбүүк, инстаграмын пост оруулдаг**. Харин 23% буюу 4 хүүхэд тутмын 1 нь public тохиргоотой пост оруулдаг гэжээ.
- Хэн нэгэн этгээд сөрөг сэтгэгдэл бичвэл ямар хариу үйлдэл үзүүлдэг болохыг тодруулсан. Ингэхэд **51% буюу 2 хүн тутмын 1 нь зүгээр л орхидог** гэж хариулжээ. Магадгүй **хүүхдүүдийн хувьд ийм тохиолдолд ямар хариу үйлдэл үзүүлэх эсэхээ мэддэггүй байж болзошгүй**. Үүний дараа 36% нь сөрөг сэтгэгдлийг устгадаг бол 27% буюу 3 хүүхэд тутмын 1 нь постоо устгадаг байна.
- Хүүхдүүдийн **74% нь танихгүй хүмүүстэй найз болохгүй байх нь өөрийг хамгаалахад хамгийн чухал** гэжээ. Үүний дараа 68% нь бусдын нэр төрд халдсан пост бичихгүй, шэйрлэхгүй байх нь өөрийгөө хамгаалах үйлдэл гэж үзжээ. Мөн 55% нь нэр төрд халдсан, гүтгэсэн пост, мессежийг блоклох, 54% нь үнэн эсэх нь тодорхойгүй мэдээлэл авч цааш түгээхгүй байх, 51% нь цахим хаягийн нууц үгээ тогтмол солих зэргийг нэрлэлээ.
- Цахим сүлжээнд хүүхдүүд өдөрт дунджаар 4 цагийг зарцуулдаг. Цахим сүлжээнд олон цагийг зарцуулах нь ямар эрсдэлтэй болохыг тодруулахад **89% буюу 10 хүүхэд тутмын 9 нь нүдний хараа муудах** эрсдэлийг нэрлэлээ. Үүний дараа 81% буюу 10 хүүхэд тутмын 8 нь ядаргаанд орох, 64% буюу 10 хүүхэд тутмын 6 нь гар утас, компьютер зэрэг дэлгэцэд донтох эрсдэлийг нэрлэсэн юм. Мөн нь 55% нь хичээл номдоо сонирхолгүй болдог, 50% нь ээж аав, гэрийнхэнтэйгээ харилцах харилцаа муудах гэж хариулжээ.
- Интернэтийн зохистой хэрэглээ, хор хөнөөл, хэрхэн өөрийгөө болон бусдыг цахим орчны гэмт хэрэг, дарамт шахалтад өртөхөөс **урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг 54% нь телевизээс авдаг** байна. Дараагийн гол суваг нь аав, ээж байдаг гэж 53% нь хариулжээ. Мөн 52% нь энэ талаарх мэдээллийг интернэтээс авдаг байна. Харин анги даасан багш болон найз нөхдөөсөө энэ талаарх мэдээлэл авах байдал 50% буюу 2 хүүхэд тутмын 1 нь мэдээлэл авдаг гэжээ. Хамгийн бага мэдээлэл өгдөг нь

интернэтийн үйлчилгээ байгууллага байгаа тул энэ талаарх мэдээллийг хэрэглэгчдэдээ өгөхийг шаардлагыг хүргүүлэх нь зүйтэй.


- Хүүхдүүдийн **хамгийн их мэдээлэл авдаг суваг нь** фейсбүүк (89%) байна. Дараа нь телевиз гэж 65% нь хариулжээ. Гуравдугаарт 60% нь найз нөхөд, үе тэнгийнхэн гэсэн байна. Хүйсийн хувьд нэг ялгаа байгаа нь охидын хувьд инстаграмаар мэдээлэл авах хандлага хөвгүүдтэй харьцуулахад өндөр байна.
- **Ekids.mn, happywebs.mn зэрэг сайтуудад** байршуулсан нийтлэлүүдийг **30% буюу 10 хүн тутмын 3 нь уншиж байсан** бол 70% буюу 10 хүүхэд тутмын 7 нь уншиж байгаагүй байна. Эдгээр сайтууд руу 13-14 насны хүүхдүүд орж үзсэн байх хандлага бусад насны бүлэгтэй харьцуулахад хамгийн өндөр буюу 76% нь орж үзжээ.

Бүлгийн дэлгэрэнгүй үр дүн

Судалгааны үр дүнд харамсалтай гэж хэлж болох үр дүн гарсан нь цахим орчны дарамтад өртсөн найзуудынх нь 59% нь буюу 10 хүүхэд тутмын 6 нь эцэг, эхдээ хэлж байгаагүй байна.

Дөнгөж 15% нь л эцэг, эхдээ хэлдэг байгаа нь эцэг, эх болон хүүхдүүд хоорондын ойлголцол, харилцаа хангалтгүй байгааг харуулж байна.


График 23. Цахим дарамтад өртсөн тохиолдолд эцэг, эхдээ хэлдэг эсэх



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.1

Хэрэв цахим халдлагад найз чинь өртөж болзошгүй гэж санаа зовж байгаа бол чи тусламж авахын тулд хэнд хандах вэ? гэдгийг тодруулахад 63% нь аав, ээждээ хандана гэж хариулжээ. Гэхдээ бодит байдалд эцэг, эхдээ хэлдэггүй болохыг дээрх үр дүнгээс харж болно. Тиймээс эцэг, эхчүүдийн хувьд хүүхдүүдтэй маш сайн ярилцах, тэдний асуудлыг ойлгох, асуудлыг нь шийдвэрлэхийг эрмэлзэж байх нь маш чухал нөлөөтэй байна. Үүний дараа 49% нь буюу 2 хүүхэд тутмын 1 нь цагдаад хандана, 38% нь найз нөхдөдөө, 37% нь багшдаа, 35% нь 108 утас руу холбогдохоор байна. Насны хувьд харвар, 13-14 насныхан эцэг, эх, багш болон хүүхдийн тусламжийн 108 утас руу холбогдох хандлага өндөр байгаа бол нас нэмэгдэх тусам эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгчдээ хэлэх болон 108 утас руу холбох хандлага буурч байна. Өөрөөр хэлбэл 17-18 насныхан асуудлаа хэнд ч хэлэлгүй өөртөө хадгалах хандлага ажиглагдлаа.

График 24. Цахим халдлагад найз чинь өртөж болзошгүй гэж санаа зовж байгаа тохиолдолд хэнд хандах талаар, хүйсээр




Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.2

Сайшаалтай гэж хэлж болох үр дүн гарсан нь хүүхдүүдийн 99% нь хүүхдийн тусламжийн 108 утас байдаг талаар мэдэж байлаа.

Судалгааны зорилгод хүүхдүүд өөрсдийгөө цахим орчны дарамт, халдлагаас хэрхэн хамгаалах талаарх мэдлэг, ойлголт ямар байгааг тодруулах байсан. Энэ хүрээнд өөрийгөө хамгаалах үйлдлүүдээс алийг нь хийж байсан, мэдэж байгаа болохыг тодрууллаа. Хүүхдүүдийн 67% буюу 10 хүүхэд тутмын 7 нь өмнө нь хэн нэгнийг блоклож байсан байна. Зарим хүүхдүүдийн хувьд технологийн мэдлэг, гадаад хэлний мэдлэгээс хамаарч нууц үгээ сольж чадахгүй байх тохиолдол байдаг. Үүнийг тодруулахад 65% нь цахим орчинд өөрийгөө илүү аюулгүй болгох үүднээс нууц үгээ сольж байжээ. Мөн өөрийгөө хамгаалах зорилгоор 62% нь хэн нэгнийг найзаасаа хасаж байсан байна. Өөрийгөө хамгаалах эдгээр үйлдлүүдийг охид хөвгүүдээс ойролцоогоор 20 пунктээр илүү их хийсэн байгаагаас харахад цахим орчны дарамт, халдлагын гол өртөж буй бүлэг нь охид болохыг баталж байгаа юм. Насны хувьд авч үзвэл, нас нэмэгдэх тусам өөрийгөө хамгаалах үйлдлүүдийг хийж байсан нь их болж байна. Нөгөө талаасаа хүүхдүүд **2 шатат баталгаажуулалт, Face recognition унтраах буюу автоматаар tag-лаж болохгүй болгох зэрэг аргуудыг ашиглаж байгаагүй зөвхөн найзаасаа хасах, блоклох, репорт хийх зэргээр аргуудыг нийтлэг ашигласан байна.** Энэ нь ихэнхдээ үйл явдал болж өнгөрсний дараа нь авдаг арга хэмжээ гэж харж болохоор байна. Тиймээс урьдчилан сэргийлэх арга замуудыг ашиглах талаар сурталчлах хэрэгтэй байна.


График 25. Цахим орчинд өөрийг илүү аюулгүй болгох зорилгоор хийж байсан зүйлс, хүйсээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.4

Сошиал орчинд өөрийгөө хамгаалах, хувийн мэдээллээ алдахгүй байх өөр арга бол пост хийхдээ тохиргоог өөрчлөх байдаг. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 45% нь only friends тохиргоотойгоор фейсбүүк, инстаграмын пост оруулдаг байна. Харин 23% буюу 4 хүүхэд тутмын 1 нь public тохиргоотой пост оруулдаг гэжээ. Пост оруулахдаа хийдэг тохиргоо нь нас болон хүйсийн хувьд ялгаатай зүйл ажиглагдсангүй. Нас нэмэгдэх тусам public тохиргоотой пост оруулах хандлага бага зэрэг нэмэгдсэн харагдаж байна. Эсрэгээрээ 13-14 насныхан only me тохиргоотой оруулах хандлага бусад насны бүлэгтэй харьцуулахад 2-3 пунктээр өндөр байна.


График 26. Сошиал орчинд пост оруулахдаа хийдэг тохиргоо, насны бүлгээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.5

Өмнөх бүлэгт найзуудынх нь 39% өөрийн оруулсан постдоо гутаан доромжлуулсан, сөрөг агуулгатай сэтгэгдэл авч байсан болох нь харагдсан. Тэгвэл хэн нэгэн этгээд сөрөг сэтгэгдэл бичвэл ямар хариу үйлдэл үзүүлдэг болохыг тодрууллаа. Ингэхэд 51% буюу 2 хүн тутмын 1 нь зүгээр л орхидог гэж хариулжээ. Магадгүй хүүхдүүдийн хувьд ийм тохиолдолд ямар хариу үйлдэл үзүүлэх эсэхээ мэддэггүй байж болзошгүй юм. Үүний дараа 36% нь сөрөг сэтгэгдлийг устгадаг бол 27% буюу 3 хүүхэд тутмын 1 нь постдоо устгадаг байна. 13-15 насны хүүхдүүдийн хувьд зүгээр орхих хандлага өндөр байдаг бол 17-18 насныхан сөрөг сэтгэгдлийг устгах хандлага өндөр байдаг байна.

График 27. Сөрөг сэтгэгдэлд үзүүлдэг хариу үйлдэл, хүйсээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.6

Чи өөрийгөө бусдад цахим дарамтыг үзүүлж байсан гэж боддог уу? гэдгийг тодруулахад 87% нь үгүй, 7% нь тийм байж магадгүй, 3% нь бусдад цахим дарамж үзүүлж байсан, үлдсэн 3% нь хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ. Хүйсээр задлан харвал, хөвгүүдийн 13% нь хэн нэгэнд цахим дарамж үзүүлж байсан бол охидын хувьд 8% нь үзүүлж байсан гэжээ. Байршлын хувьд нэлээд ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, Улаанбаатар хотын хүүхдүүдийн 14% нь хэн

нэгэнд цахим дарамт үзүүлсэн гэдгээ зөвшөөрсөн бол орон нутгийн хүүхдүүдийн 6% нь л үзүүлж байсан байна. Мөн нас нэмэгдэх тусам хэн нэгэнд цахим дарамт үзүүлэх хандлага нэмэгдэж байна.

Хүснэгт 11. Цахим дарамт хийх хандлага болон мэдээлэл бусадтай хуваалцах хандлага

		Нийт	Хүйс		Насны бүлэг			Байршил	
			Эрэгтэй	Эмэгтэй	13-14 настай	15-16 настай	17-18 настай	УБ	Орон нутаг
Чи өөрийгөө бусдад цахим дарамтыг үзүүлж байсан гэж боддог уу?	Тиймээ. Үзүүлж байсан	3%	5%	2%	1%	2%	5%	4%	2%
	Тийм байж магадгүй	7%	8%	6%	1%	7%	11%	10%	4%
	Үгүй	87%	85%	89%	94%	89%	78%	82%	91%
	Мэдэхгүй байна	3%	3%	4%	3%	1%	6%	4%	3%
Хэн нэгийг элдэв үгээр гутаан доромжлох нь тэднийг маш их сэтгэл санаагаар унадаг талаар сонсож байсан уу?	Сонсож байсан	91%	86%	96%	87%	92%	94%	91%	91%
	Сонсож байгаагүй	9%	14%	4%	13%	8%	6%	9%	9%
Аливаа мэдээлэл share хийхдээ үнэн эсэхийг олон эх сурвалжаас нягталж шалгадаг уу?	Тийм	58%	58%	58%	56%	59%	59%	63%	54%
	Үгүй	42%	42%	42%	44%	41%	41%	37%	46%


Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.7, 4.8 болон 4.9

Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Мөн хэн нэгийг элдэв үгээр гутаан доромжлох нь тэднийг маш их сэтгэл санаагаар унадаг талаар сонсож байсан эсэхийг тодруулахад 91% нь сонсож байсан байна. Аливаа мэдээлэл share хийхдээ үнэн эсэхийг олон эх сурвалжаас нягталж шалгадаг эсэхийг тодруулахад 42% нь үгүй, 58% нь тийм гэжээ. Өөрөөр хэлбэл, өөрт таалагдсан мэдээллийн үнэн зөв эсэхийг нягтлалгүй бусадтай хуваалцах хандлага байдаг болохыг харуулж байна. Ялангуяа 13-14 насны орон нутгийн хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт бусад бүлэгтэй харьцуулахад бага зэрэг өндөр байгаа юм.

Цахим орчинд өөрийг хамгаалах үүднээс ямар ямар үйлдлүүдийг хийдэг болохыг тодруулсан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 74% нь танихгүй хүмүүстэй найз болохгүй байх нь өөрийг хамгаалахад хамгийн чухал гэжээ. Энэ нь хамгийн их эрсдэлтэй үйлдэл юу болохыг тодруулсан асуулттай нийцэж байна. Үүний дараа 68% нь бусдын нэр төрд халдсан пост бичихгүй, шэйрлэхгүй байх нь өөрийгөө хамгаалах үйлдэл гэж үзжээ. Мөн 55% нь нэр төрд халдсан, гүтгэсэн пост, мессежийг блоклох, 54% нь үнэн эсэх нь тодорхойгүй мэдээлэл авч цааш түгээхгүй байх, 51% нь цахим хаягийн нууц үгээ тогтмол солих зэргийг нэрлэлээ.


График 28. Цахим орчинд өөрийгөө хамгаалах үйлдлүүдийг хийдэг байдал, хүйсээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.10

Цахим сүлжээнд хүүхдүүд өдөрт дунджаар 4 цагийг зарцуулдаг. Тэгвэл цахим сүлжээнд олон цагийг зарцуулах нь ямар эрсдэлтэй болохыг тодруулав. Хүүхдүүдийн 89% буюу 10 хүүхэд тутмын 9 нь нүдний хараа муудах эрсдэлийг нэрлэлээ. Үүний дараа 81% буюу 10 хүүхэд тутмын 8 нь ядаргаанд орох, 64% буюу 10 хүүхэд тутмын 6 нь гар утас, компьютер зэрэг дэлгэцэд донтох эрсдэлийг нэрлэсэн юм. Хамгийн эмзэглүүштэй үр дүн нь 55% нь хичээл номдоо сонирхолгүй болдог, 50% нь ээж аав, гэрийнхэнтэйгээ харилцах харилцаа муудах гэж хариулжээ. Тиймээс цахим орчныг зөв зохистой хэрэглэх нь тэдний ирээдүйд маш чухал нөлөөтэй болох нь харагдаж байна.

График 29. Цахим орчинд олон цагийг зарцуулснаар учирч болох эрсдэл



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.11

Интернэтийн зохистой хэрэглээ, хор хөнөөл, хэрхэн өөрийгөө болон бусдыг цахим орчны гэмт хэрэг, дарамт шахалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг 54% нь телевизээс авдаг байна. Энэ нь хүүхдүүдийг цахим орчны аюулаас урьдчилсан сэргийлэх зорилгоор хийсэн ажлууд үр дүнд хүрсэн болохыг харуулж байна. Интернэтийн зохистой хэрэглээ, өөрийг урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл авдаг дараагийн гол суваг нь аав, ээж байдаг гэж 53% нь хариулжээ. Мөн 52% нь энэ талаарх мэдээллийг интернэтээс авдаг байна. Харин анги даасан багш болон найз нөхдөөсөө энэ талаарх мэдээлэл авах байдал 50% буюу 2 хүүхэд тутмын 1 нь мэдээлэл авдаг гэжээ. Хамгийн бага мэдээлэл өгдөг этгээд нь интернэтийн үйлчилгээ байгууллага байгаа тул энэ талаарх мэдээллийг хэрэглэгчдэдээ өгөхийг шаардлагыг хүргүүлэх нь зүйтэй. Хүйсээр задлан харахад охидын 62% нь аав, ээжээсээ мэдээлэл авч байхад хөвгүүдийн дөнгөж 45% нь л мэдээлэл авдаг гэжээ. Энэ нь эцэг, эхчүүд охиндоо илүү анхаарал хандуулж, цахим орчны талаарх мэдээлэл, зөвлөгөөг өгдөг болохыг харуулж байна.

График 30. Интернэтийн хэрэглээний талаарх мэдээлэл авдаг эх үүсвэр, хүйсээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.13

Насны хувьд задлан харвал ялгаатай зүйлс ажиглагдаж байна. Тухайлбал 13-14 насныхан эцэг, эх болон анги удирдсан багшаасаа илүү мэдээлэл авдаг бол нас нэмэгдэх тусам интернэтээс мэдээлэл авах хандлага нэмэгдсэн байна.

Хүснэгт 12. Интернэтийн хэрэглээний талаарх мэдээлэл авдаг эх үүсвэр, насны бүлгээр, байршлаар

Мэдээлэл авдаг эх сурвалж	Нийт	Насны бүлэг			Байршил	
		13-14 настай	15-16 настай	17-18 настай	УБ	Орон нутаг
Телевизээс	54%	54%	52%	55%	60%	49%
Аав, ээжээсээ	53%	65%	57%	40%	61%	48%
Интернэтээс	52%	36%	57%	61%	63%	43%
Анги удирдсан багшаасаа	50%	64%	52%	37%	53%	48%
Найз нөхдөөсөө	50%	46%	54%	50%	53%	48%
Сургуулийн нийгмийн ажилтнаас	40%	32%	45%	42%	38%	42%
Ах, эгчээсээ	36%	44%	40%	27%	42%	32%


Цагдаагийн байгууллагаас	26%	18%	26%	32%	25%	26%
Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллаас	17%	12%	21%	19%	22%	14%
Энэ талаарх мэдээллийг авч чаддаггүй	4%	5%	2%	4%	2%	5%

Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.13

Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Хүүхдүүдийн хамгийн их мэдээлэл авдаг сувгийг тодруулсан. Тэдний хувьд 89% нь фейсбүүкээр мэдээлэл авч байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Үүний дараа 65% нь телевиз гэж нэрлэсэн. Гуравдугаарт 60% нь найз нөхөд, үе тэнгийнхэн гэсэн байна. Тиймээс эдгээр мэдээлэл авдаг сувгуудыг ашиглаж мэдээлэл хүргэх нь хамгийн үр дүнтэй байна. Хүйсийн хувьд нэг ялгаа байгаа нь охидын хувьд инстаграмаар мэдээлэл авах хандлага хөвгүүдтэй харьцуулахад өндөр байна.


График 31. Хамгийн их мэдээлэл авдаг хэрэгсэл, суваг, хүйсээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.15

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны хөгжүүлсэн ekids.mn, happywebs.mn зэрэг сайтуудад байршуулсан цахим орчны ёс зүйтэй хэрэглээг сурталчлан таниулах, цахим орчинд хэрхэн хамгаалах, нийгмийн сүлжээний эерэг болон сөрөг үр дагаврын талаарх нийтлэлүүдийг 30% буюу 10 хүн тутмын 3 нь уншиж байсан бол 70% буюу 10 хүүхэд тутмын 7 нь уншиж байгаагүй байна. Эдгээр сайтууд руу 13-14 насны хүүхдүүд орж үзсэн байх хандлага бусад насны бүлэгтэй харьцуулахад хамгийн өндөр буюу 76% нь орж үзжээ. Хөвгүүдтэй харьцуулахад охидын орж үзсэн байдал 7 пунктээр өндөр байгааг доорх графикаас харж болно.

График 32. Ekids.mn, harptwebs.mn рүү орж нийтлэл уншиж байсан байдал, насны бүлгээр



Эх үүсвэр: 13-18 насны хүүхдээс авсан судалгаа, асуулт 4.16

3.2 ЭЦЭГ, ЭХЧҮҮД БУЮУ 7-18 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ГЭР БҮЛ

1. ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ЦАХИМ ОРЧНЫ ХЭРЭГЛЭЭ


Бүлгийн хураангуй үр дүн

- Судалгаанд хамрагдсан өрхүүдийн **42% нь гэртээ суурин интернэтгүй** байна.
- Эцэг, эхчүүдийн хамгийн их ашигладаг сошиал медиа нь **фейсбүүк, фейсбүүкийн мессенжер**.
- **Өдөрт дунджаар 146 минут буюу 2.4 цагийг интернэтэд зарцуулж байгаа** нь 13-18 насны хүүхдүүдтэй харьцуулахад 94 минутаар бага байна. Хамгийн их цагийг зарцуулж буй бүлэг нь 35 хүртэлх насны эцэг, эх байгаа бөгөөд 207 минут буюу 3.4 цагийг зарцуулж байна.
- Сошиал медиаг **80% нь оройн цагаар ашигладаг**. Ихэвчлэн оройн цагаар ашиглаж байгаа нь хүүхдүүдтэй ярилцах боломжийг багасгаж байна.
- **Хүүхдээ саатуулах зорилгоор 44% нь гар утсаа өгч** хэрэглүүлдэг. Үүнийг задлан харвал, 7-9 настай хүүхдэдээ өгдөг гэж 33% нь, 4-6 настайд 23% нь, 1-3 настай хүүхдэд утсаа өгч ашиглуулдаг гэж 18% нь хариулжээ.
- **Хүүхдүүд аав, ээжийнхээ гар утсыг аваад тоглоом тоглох, ютубээр видео үзэх** нь хамгийн их.
- Хүүхдүүдийн нь **83% нь 13-аас доош насандаа интернэт ашиглаж** эхэлсэн. 10-12 настайгаасаа интернэт ашиглаж эхэлсэн гэж 33% нь үзэж байгаа нь хамгийн өндөр байна. Харин 1-3 настайдаа 9% нь, 4-6 настайдаа 21% нь, 13-15 настайдаа 16% нь интернэт ашиглаж эхэлсэн.
- **10-12 настай хүүхдэдээ ухаалаг гар утас авч өгөх хандлага хамгийн өндөр** буюу 35%-тай байна. Эцэг, эхчүүдийн 4% нь хүүхдээ 4-6 настай байхад нь, 13% нь 7-9 настайд нь ухаалаг гар утас авч өгчээ.

Бүлгийн дэлгэрэнгүй үр дүн

Эцэг, эхээс авах судалгаанд 7-18 настай хүүхэдтэй аав ээжүүдийг хамрууллаа. Энэ бүлэгт тэдгээрийн өөрсдийнх нь цахим орчин, интернэтийн хэрэглээг тодруулж асуусан. Судалгаанд оролцогчдын 42% нь гэртээ суурин интернэтгүй байна. Байршлаар нь харвал, орон нутгийн оролцогчид Гэр интернэтийг хэрэглэх хандлага өндөр байна.

График 33. Өрхийн хэрэглэдэг интернэт, байршлаар



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.1

Аав ээжүүдийн хамгийн их ашигладаг сошиал медиа нь фейсбүүк, фейсбүүкийн мессенжер байна. Ямар ямар сошиал медиа ашигладаг болохыг нь тодруулахад 94% нь фейсбүүк, 83% нь фейсбүүк мессенжер, 44% нь ютюб, 34% нь гүүгл ашигладаг гэж хариулжээ. Хүйсээр нь харвал сошиал медиа хэрэглээнд төрлөөсөө хамаарч ялгаа ажиглагдаж байна. Ээжүүд аавуудаас фейсбүүк мессенжерийг 7 пунктээр, снайп чат 6 пунктээр, инстаграм 6 пунктээр, тик ток 18 пунктээр илүү ашиглаж байгаа бол аавууд твиттерийг 6 пунктээр илүү хэрэглэж байна. Бүх насныхан фейсбүүк ашиглах байдал өндөр байгаа ба байршлаар нь харахад ч энэ үр дүн ижил байна. Харин фейсбүүкийн мессенжер, инстаграм, ютюб, тик ток зэргийн хэрэглээ 40-ээс дээш насанд багассан үзүүлэлттэй байна. Мөн ютюб, инстаграм, твиттер, снайп чат, гүүгл зэргийн хэрэглээ Улаанбаатар хотод илүү байна.

Хүснэгт 13. Эцэг, эхчүүдийн сошиал медиа хэрэглээ, насны бүлгээр, байршлаар

	Хүйс		Нас					Байршил		Нийт
	Аав	Ээж	35 хүртэлх нас	36-40 настай	41-45 настай	46-50 настай	51+ настай	УБ	Орон нутаг	
Фейсбүүк	93%	95%	99%	98%	95%	93%	72%	96%	93%	94%
Фейсбүүк мессенжер	79%	86%	94%	90%	77%	79%	55%	87%	79%	83%
Ютуб	44%	45%	60%	49%	38%	36%	23%	51%	39%	44%
Гүүгл	33%	35%	43%	37%	31%	32%	16%	45%	25%	34%
Инстаграм	12%	18%	33%	15%	8%	9%	3%	22%	10%	15%
Тик Ток	6%	20%	27%	14%	10%	4%	2%	16%	11%	13%
Твиттер	13%	7%	15%	10%	5%	10%	8%	13%	8%	10%
Снайп чат	2%	8%	10%	5%	3%	2%	2%	8%	3%	5%
Вибер	4%	7%	12%	5%	1%	3%	6%	9%	2%	5%
Аль нь ч байхгүй	4%	4%	1%	2%	3%	4%	22%	2%	6%	4%
Уатс апп	2%	5%	5%	6%	2%	0%	0%	4%	3%	3%
Скайп	2%	5%	5%	5%	1%	2%	0%	4%	2%	3%
Саунд клоуд	2%	1%	3%	2%	1%	0%	0%	2%	1%	2%
Бусад бичих	3%	1%	3%	2%	1%	2%	2%	3%	1%	2%

Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.2
Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Өдөрт нийт хэдэн цагийг интернэт орчинд зарцуулдаг болохыг тодруулахад, 25% нь 1 цаг хүртэлх хугацааг зарцуулдаг бол 25% нь 1-2 цаг хүртэлх хугацааг зарцуулдаг, 21% 2-3 цаг хүртэлх хугацааг зарцуулдаг гэжээ.

Хүснэгт 14. Интернэт орчинд нэг өдөрт зарцуулдаг хугацаа, хүйс, байршлаар

Хугацаа	Хүйс		Байршил		Нийт
	Аав	Ээж	Улаанбаатар	Орон нутаг	
30 минут хүртэлх	13%	15%	15%	13%	14%
31-59 минут	12%	9%	9%	12%	11%
1-2 цаг	24%	25%	23%	26%	25%
2-3 цаг	22%	20%	17%	24%	21%
3-4 цаг	10%	8%	11%	8%	9%
4-5 цаг	6%	5%	8%	4%	6%
5-6 цаг	3%	4%	4%	3%	3%
6-7 цаг	0%	2%	1%	1%	1%
7-8 цаг	1%	3%	3%	1%	2%
8-9 цаг	0%	1%	1%	0%	0%
9-10 цаг	2%	2%	2%	1%	2%
10-11 цаг	1%	2%	2%	1%	1%
Бусад	8%	5%	4%	8%	6%

Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.3

Интернэт зарцуулдаг цагийг дунджилж тооцоолбол, **эцэг, эхчүүд дунджаар өдөрт 146 минут буюу 2.4 цагийг зарцуулж байна.** Энэ нь 13-18 насны хүүхдүүдтэй харьцуулахад 94 минутаар бага гэсэн үг. Хамгийн их цагийг зарцуулж буй бүлэг нь 35 хүртэлх насны эцэг, эх байгаа бөгөөд 207 минут буюу 3.4 цагийг зарцуулж байна. Эсрэгээрээ хамгийн цагийг зарцуулж байгаа бүлэг нь 50+ насныхан (119 минут буюу 2.0 цаг) байна. Улаанбаатар хотын орон сууцны хороололд амьдардаг эцэг, эхчүүд илүү их интернэт ашиглаж байна.


Хүснэгт 15. Эцэг, эхчүүдийн интернэтэд зарцуулдаг дундаж хугацаа, минутаар, ялгаатай бүлгээр

Хугацаа	Нийт	Хүйс		Насны бүлэг					Байршил		Сууцны нөхцөл	
		Аав	Ээж	35 хүртэлх нас	36-40 настай	41-45 настай	46-50 настай	51+ настай	УБ	Орон нутаг	Орон сууц	Гэр хороолол
Минут	146	138	154	207	128	133	124	119	162	134	173	127
Цаг	2.4	2.3	2.6	3.4	2.1	2.2	2.1	2.0	2.7	2.2	2.9	2.1

Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.3

Сошиал медиаг ихэвчлэн оройн цагаар ашиглаж байна. Судалгаанд хамрагдсан **аав, ээжүүдийн 80% нь оройн цагаар**, 34% нь өдрийн цагаар, 17% нь өглөөний цагаар сошиал медиа ашиглаж байна. Оройн цагаар сошиал медиа ашиглах нь аавуудын хувьд ээжийнхээс 11 пунктээр илүү байгаа ба өдрийн цагаар ээжүүд ааваас 9 пунктээр илүү сошиал медиа ашиглаж байна. Ер нь аав, ээжүүд сошиал медиа ашиглахдаа ихэвчлэн оройн цагаар ашиглаж байгаа нь хүүхдүүдтэй ярилцах боломжийг багасгаж байгаа тул анхаарал хандуулах ёстой асуудал мөн юм.


График 34. Эцэг, эхчүүдийн сошиал медиа ашигладаг цаг, хүйсээр



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.4

Сошиал медиаг хэзээ ашиглаж байгааг байршлаар нь ялгаж харвал Улаанбаатар хотын аав, ээжүүд өдрийн цагаар ашиглах нь орон нутгийнхаас 11 пунктээр илүү байгаа ба оройн цагаар ашиглах нь орон нутагт 6 пунктээр илүү байна.


График 35. Эцэг, эхчүүдийн сошиал медиа ашигладаг цаг, байршлаар



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.4

Судалгаанд хамрагдсан аав, ээжүүдээс **хүүхдээ саатуулах зорилгоор гар утсаа өгч хэрэглүүлдэг** эсэхийг нь тодруулахад 44% нь өгдөг буюу тийм гэсэн байна. Ээжүүдийн 46% нь, аавуудын 43% нь гар утсаа өгдөг гэжээ. Өөрөөр хэлбэр аав, ээжүүд хүүхдээ саатуулах зорилгоор гар утсаа адилхан өгдөг байна.


График 36. Хүүхдээ саатуулах зорилгоор гар утсаа өгдөг эсэх, хүйсээр



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.5

Хэдэн настай хүүхдээ саатуулах зорилгоор гар утсаа өгдгийг нь тодруулж асуусан. 7-9 настай хүүхдэдээ өгдөг гэж 33% нь, 4-6 настайд 23% нь, 1-3 настай хүүхдэд утсаа өгч ашиглуулдаг гэж 18% нь хариулжээ. Ээжүүдийн хувьд 1-3 настай хүүхдэдээ гар утсаа өгч ашиглуулах хандлага аавуудынхаас илүү байна.

График 37. Хэдэн настай хүүхдээ саатуулах зорилгоор гар утсаа өгдөг болох



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.6

Хүүхэд **аав, ээжийнхээ гар утсыг тоглоом тоглох, ютүбээр видео үзэх зорилгоор хамгийн их ашигладаг** байна. Гар утсаар тоглох үйлдлийг 66% нь, 64% нь ютүбээр видео үзэх, 41% нь гар утсан дээр байгаа зураг, бичлэгийг үздэг байна. Аав ээжийнхээ утсан дээр фейсбүүкээ шалгах үйлдэл хийдэг нь бусдаасаа харьцангуй бага буюу 17%-тай байна. Аав ээжийнхээ утсан дээр хүүхдийн хийдэг үйлдлийг байршлаар харахад ялгаатай зүйл гараагүй. Өөрөөр хэлбэл Улаанбаатар, орон нутагт энэ үр дүн ижил байв.


График 38. Эцэг, эхийнхээ гар утсыг аваад хүүхдүүдийн хийдэг үйлдэл



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.7

Судалгаанд хамрагдсан аав, ээжүүдийн 33% нь хүүхдээ 10-12 настайгаасаа интернэт ашиглаж эхэлсэн гэж байгаа нь хамгийн өндөр байна. Хүүхдийн интернэт ашиглаж эхэлсэн насны хувьд 1-3 наснаас бусад насан дээр байршлаар ялгарал ажиглагдахгүй байгаа ба энэ насандаа интернэт хэрэглэж эхлэх хандлага Улаанбаатар хотод 6 пунктээр илүү байна. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын хүүхдүүд орон нутгийн хүүхдүүдтэй харьцуулахад арай бага насандаа интернэт ашиглаж эхэлдэг байна.


График 39. Хүүхдийн интернэт хэрэглэж эхэлсэн нас, байршлаар



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.8

Хүүхдийнхээ хэрэглээнд зориулж ухаалаг гар утас авч өгдөг насны хувьд 35% нь 10-12 насанд, 25% нь 13-15 насанд нь авч өгдөг байна. Байршлаар нь харвал энэ онцлог ялгаралгүй байгаа ба харин 9-өөс доош насанд нь ухаалаг гар утас авч өгөх хандлага Улаанбаатар хотод арай илүү байна. Эндээс 10 нас хүрээд дийлэнх нь ухаалаг утастай болж байгааг харж болно.

График 40. Хүүхдэдээ ухаалаг утас авч өгдөг нас, байршлаар



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.9

2. 7-12 НАСТАЙ ХҮҮХДИЙН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ


Бүлгийн хураангуй үр дүн

- 7-12 настай хүүхдүүдийн интернэтийн хэрэглээг эцэг, эхээс нь тодруулсан. Эцэг, эхчүүдийн **87% нь өөрийн 7-12 насны хүүхдэд нь интернэт орох боломжтой төхөөрөмж байгаа** гэж хариулжээ.
- Хүүхдүүдийн **70% нь аав ээжийнхээ гар утсыг ашиглах боломжтой** байна. Аавынхаа гар утсыг 61% нь ашиглах боломжтой байдаг бол ээжийнхээ гар утсыг 78% нь ашиглаж байна.
- Өрхүүдийн **7%-д нь гэр бүлийн дундын хэрэглээний таблет байдаг бол 3 өрх тутмын 1 нь гэр бүлийн дундын хэрэглээний компьютертой**. Уг дундын хэрэглээний компьютерын гол хэрэглэгч нь 19 болон түүнээс дээш насныхан байдаг байна. Дараагийн гол хэрэглэгч нь 10-14 насныхан гэж 24% нь хариулжээ.
- Сүүлийн 3 сард **7-12 насны хүүхэд нь интернэт орсон гэж 83% хариулсан**. Тэдгээр **хүүхдүүдийн 62% нь өдөр бүр ордог**. Орон сууцанд амьдардаг хүүхдүүдийн өдөр бүр интернэт орох байдал гэр хороололд амьдардаг хүүхдүүдээс 28 пунктээр илүү байна.
- 13 болон түүнээс дээш настай хүүхдийг фейсбүүкийн хаяг нээхийг зөвшөөрдөг боловч бодит байдал дээр **7-12 насны хүүхдүүдийн 50% нь фейсбүүк хэрэглэдэг**.
- Тэдний хамгийн их нь ашигладаг сошиал медиа нь **фейсбүүк, фейсбүүкийн мессенжер, ютюб болон тик ток** байна.
- 7-12 насныхан өдөрт дунджаар **140 минут буюу 2.3 цагийг интернэт орчинд зарцуулж** байна. Хамгийн их цагийг зарцуулж буй бүлэг нь орон сууцны хороололд амьдардаг хүүхдүүд бөгөөд 160 минутыг зарцуулж байна. Эсрэгээрээ хамгийн цагийг зарцуулж байгаа бүлэг нь гэр хороололд амьдардаг хүүхдүүд (125 минут буюу 2.1 цаг) байна.

Бүлгийн дэлгэрэнгүй үр дүн

7-12 настай хүүхдүүдийн интернэтийн хэрэглээг эцэг, эхээс нь тодруулсан. Нийт судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдийн 13% нь манай 7-12 насны хүүхдэд интернэт орох боломжтой төхөөрөмж байхгүй буюу **87% нь ямар нэгэн төхөөрөмж байгаа** гэж хариулжээ. Эцэг, эхчүүдийн хэлж байгаагаар 7-12 настай хүүхдүүдэд интернэт орох боломжтой ухаалаг гар утас бий хариулах хандлага хамгийн өндөр байна. Үүний дараа нөүтбүүк, ширээний компьютер зэрэг ордог байна.


График 41. 7-12 настай хүүхдэд нь интернэт орох боломжтой төхөөрөмж байгаа эсэх, байршлаар



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.10

Энэ насны хүүхдүүдийн 70% нь аав ээжийнхээ гар утсыг ашиглаж байна. Аавуудын гар утсыг 7-12 насны хүүхэд нь ашиглах боломж 61% байгаа бол ээжүүдийнхээ гар утсыг 78% нь ашиглаж байна. Өөрөөр хэлбэл ээжүүдийн гар утас энэ насны хүүхдүүдэд илүү нээлттэй байдаг байна.


График 42. Гар утсыг нь хүүхэд ашиглах боломжтой байдаг эсэх, хүйсээр



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.11

Гэр бүлийн дундын хэрэглээний таблет байдаг эсэхийг тодруулахад 7%-д нь байдаг гэжээ. Энэхүү таблетыг 58% нь хүүхэд хяналтгүйгээр ашиглах боломжтой байдаг гэсэн байна.

График 43. Гэр бүлийн дундын хэрэглээний таблеттай эсэх, уг таблетыг хүүхэд хяналтгүйгээр ашиглах боломжтой эсэх, байршлаар



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.12 болон 2.15

Гэрт нь байдаг дундын хэрэглээний таблетад эцэг, эхийн аккаунт бүртгэлтэй байх хандлагатай 48% нь байна. Тиймээс хүүхдээ эрсдэлээс сэргийлэх зорилгоор эцэг, эхчүүдийн хувьд өөрийн аккаунт хаягийг ашиглаж, өөрийн хүүхдээ юу үзэж байгаа, юу хийж байгаа болохыг хянах боломжтой харагдаж байна.


График 44. Гэр бүлийн дундын хэрэглээний таблетад бүртгэлтэй байдаг аккаунт



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.14

Аав, ээжүүдийн **3 хүн тутмын 1 нь гэр бүлийн дундын хэрэглээний компьютер байдаг** гэжээ. Улаанбаатар хотод амьдардаг гэр бүлийн хувьд дундын хэрэглээний компьютертой байх нь орон нутгийн өрхүүдээс 8 пунктэр илүү байна.


График 45. Гэр бүлийн дундын хэрэглээний компьютер байдаг эсэх, байршлаар



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.16

Уг дундын хэрэглээний компьютерын гол хэрэглэгч нь 19 болон түүнээс дээш насныхан байдаг гэж эцэг, эхчүүд хэлж байна. Дараагийн гол хэрэглэгч нь 10-14 насныхан гэж 24% нь хариулжээ.

График 46. Гэр бүлийн дундын хэрэглээний компьютерын гол хэрэглэгч, байршлаар



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.17

Эцэг, эхчүүдийн хэлж байгаагаар 7-12 настай хүүхдийн интернэтийн хэрэглээ өндөр байна. Сүүлийн 3 сард 7-12 насны хүүхэд нь ямар нэгэн байдлаар интернэт орсон гэж 83% хэлсэн байна. Фейсбүүк 13 настай хүүхэд фейсбүүкийн хаяг нээхийг зөвшөөрдөг боловч **7-12 насны хүүхэдтэй аав, ээжүүдийн 50% нь хүүхдээ фейсбүүк хэрэглэдэг гэсэн** байна. Энэ үр дүн байршлаар нь харахад онцын ялгарал харагдаагүй. Харин сууцны нөхцөлөөр авч үзвэл орон сууцанд амьдардаг энэ насны хүүхэд интернэт хэрэглэдэг (91%) байх нь гэр хороололд (78%) амьдардаг хүүхдийнхээс 13 пунктээр өндөр байна.


График 47. 7-12 насны хүүхдийн интернэт, фейсбүүкийн хэрэглээ



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.18, 2.21

7-12 насны интернэт хэрэглэдэг хүүхдүүдийн интернэтийг ямар давтамжтай ашигладаг болохыг тодруулахад **62% нь өдөр бүр ордог** байна. Энэхүү үр дүн нь байршлаар ялгаагүй байсан бол сууны төрлөөр ялгаатай байна. Орон сууцанд амьдардаг хүүхдүүдийн өдөр бүр интернэт орж байгаа байдал нь гэр хороололд амьдардаг хүүхдүүдээс 28 пунктээр илүү буюу харьцангуй өндөр байна.

График 48. 7-12 насны хүүхдийн интернэт ордог давтамж, сууцны төрлөөр



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.19

Өдөрт нийт хэдэн цагийг интернэт орчинд зарцуулдаг болохыг тодруулахад, 28% нь 1 цаг хүртэлх хугацааг зарцуулдаг бол 31% нь 2 цаг хүртэлх, 18% нь 2-3 хугацааг зарцуулдаг гэжээ.

Хүснэгт 16. 7-12 насны хүүхдүүдийн өдөрт интернэт орчинд зарцуулдаг цаг, байршлаар

Хугацаа	Улаанбаатар	Орон нутаг	Нийт
30 минут хүртэлх	15%	17%	16%
31-59 минут	11%	12%	12%
1-2 цаг	28%	33%	31%
2-3 цаг	17%	19%	18%
3-4 цаг	9%	7%	8%
4-5 цаг	8%	4%	6%
5-6 цаг	4%	2%	3%
6-7 цаг	0%	1%	0%
7-8 цаг	1%	2%	1%
8-9 цаг	1%	1%	1%
9-10 цаг	2%	0%	1%
10-11 цаг	2%	3%	2%

Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.20

Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Интернэт зарцуулдаг цагийг дунджилж тооцоолбол, **7-12 насныхан дунджаар өдөрт 140 минут буюу 2.3 цагийг зарцуулж байна.** Хамгийн их цагийг зарцуулж буй бүлэг нь орон сууцны хороололд амьдардаг хүүхдүүд байгаа бөгөөд 160 минут буюу 2.7 цагийг зарцуулж байна. Эсрэгээрээ хамгийн цагийг зарцуулж байгаа бүлэг нь гэр хороололд амьдардаг хүүхдүүд (125 минут буюу 2.1 цаг) байна.


Хүснэгт 17. 7-12 насны хүүхдүүдийн интернэтэд зарцуулдаг дундаж хугацаа, минутаар, байршил, сууцны төрлөөр

Хугацаа	Нийт	Байршил		Сууцны нөхцөл	
		УБ	Орон нутаг	Орон сууц	Гэр хороолол
Минут	140	152	131	160	125
Цаг	2.3	2.5	2.2	2.7	2.1

Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.20

Интернэтэд ордог хүүхдүүд нь ямар ямар сошиал медиаг ашиглаж байгааг тодруулахад **хамгийн их нь фейсбүүкийн мессенжер ашигладаг гэж 88% нь хариулжээ. Үүний дараа хамгийн их ашигладаг сошиал медиа нь ютюб болон тик то байна.** Байршлын хувьд харвал Улаанбаатар хотын 7-12 насны хүүхдүүд ютюбыг ашиглах хандлага орон нутгийн хүүхдүүдтэй харьцуулахад 16 пунктээр өндөр байдаг байна. Мөн Улаанбаатар хотод снайп чат ашиглах хандлага өндөр байна.

График 49. 7-12 насны хүүхдүүдийн ашигладаг сошиал медиа, байршлаар



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 2.22


3. ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ЦАХИМ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ

Бүлгийн хураангуй үр дүн

- **Эцэг, эхчүүдийн 21% нь хүүхдэдээ фейсбүүк хаяг нээж өгдөг** бөгөөд хүүхдүүд өөрөө эсвэл ах, эгч, найз нь нээж өгдөг.
- Эцэг, эхчүүдийн **32% нь 10-12 насанд нь фейсбүүкийн хаяг нээж өгчээ**. Гэхдээ 11% нь 1-3 насны хүүхдэдээ фейсбүүк хаяг нээж өгсөн байсан.
- Фейсбүүк, инстаграмыг **13 болон түүнээс дээш настай хүүхэд ашиглах эрхтэй байдаг гэдгийг 62% нь мэдэхгүй** байв.
- Эцэг, эхчүүдийн **79% нь хүүхдийнхээ цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавьдаг** гэж өөрсдийгөө үнэлсэн.
- Цахим орчны хүүхдийн хүмүүжилд үзүүлэх нөлөөг эергээр үнэлэх байдал бага ба сөргөөр үнэлэх хандлага илүү байна. Хэдийгээр сөрөг гэж үнэлж байгаа боловч ямар сөрөг нөлөө үзүүлдэг талаар гүнзгий ойлголт байдаггүй.
- Хүүхдийнхээ **цахим орчин дахь найзуудыг 30% нь огт мэддэггүй**. Бүх найзуудыг нь мэддэг эцэг, эх зөвхөн 11% нь байна. Гэхдээ ээжүүдийн 69% нь хүүхдийнхээ цахим орчин дахь найзуудыг мэдэхийг хүсдэг нь аавуудтай харьцуулахад 26 пунктээр илүү байна.
- Эцэг, эхчүүд **интернэт ашиглах нь аюул багатай** гэж үзэх хандлагатай байна.
- Цахим, интернэт орчны аюулаас хамгаалахын тулд **зөв зохистой хэрэглээний талаар ярилцах нь зүйтэй гэж 58% нь үзэж байна**. Гэхдээ бодит байдал дээр хүүхдүүдтэйгээ ярилцах нь бага байдаг нь хүүхдийн судалгааны хэсгээс харагдсан. Дараагийн сэргийлэх арга зам нь интернэт бага ашиглах талаар хэлж сануулах гэж үзэж байна.
- Эцэг, эхчүүдийн **66% нь танихгүй хүнтэй найз болох нь эрсдэлтэй** талаар, **55% нь нууц үг, хувийн мэдээллээ өгч болохгүй талаарх** зөвлөгөөг өгч байсан.
- Интернэт орчноор дамжуулан үйлдэгдсэн **гэмт хэргийн талаар 89% нь сонссон ба 27% нь цахим залилан, луйврын талаар сонсож** байсан. Харин 11% нь танихгүй хүнтэй танилцах, 9% нь хүчирхийллийн талаар сонсож байжээ.
- **54% нь 15-18 насны хүүхдүүд энэ төрлийн эрсдэлд хамгийн их өртөх магадлалтай гэж үзэж байгаа** бол 39% нь 10-14 насныхан гэж хариулжээ.

аав, ээжүүд энэ талаар Улаанбаатарынхтай харьцуулахад 12 пунктээр бага мэдэж байна. Тиймээс анхан шатны мэдлэгийг эцэг, эхчүүдэд өгөх шаардлагатай гэдэг нь харагдаж байна.


График 52. 13 болон түүнээс дээш настай хүүхэд фейсбүүк, инстаграм ашиглах эрхтэй болдог гэдгийг мэддэг эсэх, хүйс, байршлаар



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.3

Судалгаанд оролцогчдын 79% нь хүүхдийнхээ цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавьдаг гэжээ. Хязгаарлалт тавьдаг байдал аав, ээжүүдийн хувьд ижил байна. Улаанбаатар хотын эцэг, эхчүүд хүүхдийнхээ цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавьдаг гэж өөрийгөө дүгнэх байдал бага зэргийн өндөр байна.

График 53. Хүүхдийнхээ цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавьдаг эсэх, хүйсээр




Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.4

Цахим орчны хүүхдийн хүмүүжилд үзүүлэх нөлөөний талаар аав, ээжүүдийн 57% нь эерэг болон сөрөг нөлөө аль аль нь бий гэж харж байгаа бол 25% нь ер нь сөрөг нөлөөтэй гэж үзсэн байна. Цахим орчны хүүхдийн хүмүүжилд үзүүлэх нөлөөг дан ганц эергээр үнэлэх нь бага харин нь сөргөөр үнэлэх хандлага илүү байна. Эндээс харахад эцэг, эхчүүд цахим орчныг хүүхдийн хүмүүжилд сөрөг талын нөлөө их байдаг гэж боддог байна. Хэдийгээр сөрөг гэж үнэлж байгаа

боловч эцэг, эхчүүд ямар, ямар сөрөг нөлөө үзүүлдэг талаар гүнзгий ойлголт байдаггүй болох нь судалгааны явцад ажиглагдсан юм.


График 54. Цахим орчны хүүхдийн хүмүүжилд үзүүлж буй нөлөө, хүйсээр



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.5

Аав, ээжүүдээс хүүхдийнхээ цахим орчин дахь найзуудыг мэддэг эсэхийг нь тодруулахад огт мэддэггүй гэсэн хариултыг 30% нь өгсөн нь эцэг, эхчүүд хүүхдээ цахим орчны эрсдэлээс хамгаалах энгийн арга хэрэгслийг ашигладаггүй болохыг харуулж байна. Хүүхдийнхээ цахим орчин дахь найзуудыг мэддэггүй байдалд аавуудын эзлэх хувь өндөр байна. Аавуудын 39% нь найзуудыг нь огт мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн бол ээжүүдийн 22% нь мэдэхгүй гэжээ байв. Бүх найзуудыг нь мэддэг аав, ээж дөнгөж судалгаанд оролцогчдын 11% нь байгаа бол зарим найзуудыг нь мэддэг нь 20%, цөөн хэдэн найзуудыг нь мэддэг нь 18% байна. Энэ байдал байршил болон сууцны нөхцөлөөр нь харахад ялгаагүй байлаа.


График 55. Хүүхдийнхээ цахим орчин дахь найзуудыг мэддэг эсэх, хүйсээр



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.6

Одоогийн байдлаар цахим орчинд хэнтэй найзалж байгааг нь мэдэхгүй байгаа боловч ээжүүдийн 69% нь хүүхдийнхээ цахим орчин дахь найзуудыг мэдэхийг хүсэж байна. Энэ нь аавуудтай харьцуулахад 26 пунктээр илүү байна.


График 56. Хүүхдийнхээ цахим орчин дахь найзуудыг мэдэхийг хүсдэг эсэх, хүйсээр



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.7

Эцэг, эхчүүдийн хувьд цахим орчин хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөөтэй гэж үзэх хандлага өндөр байгааг өмнөх хэсэгт харуулсан. Тэгвэл интернэтээр видео бичлэг үзэх, фейсбүүк, ютюб зэрэг сошиал медиа ашиглах, интернэт сайтуудаар зочлох, интернэтээр холбогдож тоглоом тоглох зэрэг нь хүүхдүүдэд аюул учруулна гэж бодож байгааг тодрууллаа. Судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдийн 20% нь маш аюулгүй, 52% нь ер нь аюултай гэжээ. Аюул багатай гэж 27% нь үзэж байна. Ялангуяа аавуудын хувьд аюул багатай гэж үзэх хандлага ээжүүдтэй харьцуулахад бага зэргийн илүү байна.

График 57. Цахим орчин нь хүүхдэд аюул хэр зэрэг аюултай гэж үзэж байгаа болох



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.8

Тэгвэл ямар аюул учруулна гэж бодож байгааг тодруулахад 20% нь буруу, муу зүйлд уруу татагдах, 14% нь тоглоомд донтох гэж хариулжээ. Бусад хариултын хувилбар нь 10 хувиас бага байна.

График 58. Эцэг, эхчүүдийн цахим орчны аюулыг төсөөлж буй байдал



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.9

Эцэг, эхчүүдийн хувьд хүүхдээ цахим, интернэт орчны аюулаас хамгаалахын тулд интернэтийн зөв зохистой хэрэглээний талаар ярилцах нь зүйтэй гэж 58% нь хариулжээ. Хэдийгээр энэхүү арга замыг зөв гэж бодож байгаа боловч бодит байдал дээр хүүхдүүдтэйгээ ярилцах нь бага, өөрсдөө оройн цагаар сошиал медиа ашиглаж байгаа нь харагдсан. Дараагийн сэргийлэх арга зам нь интернэт бага ашиглах талаар хэлж сануулах гэж эцэг, эхчүүд үзэж байна. Хүүхдүүдийн хувьд шинэ, содон зүйлст маш их татагдах хандлагатай байдаг тул эцэг, эхийн энэхүү сануулгыг хайхрахгүй орхих магадлал маш өндөртэй юм. Гуравдугаарт эцэг, эхчүүд интернэтийн хэрэглээг хүчээр хязгаарлах арга замыг нэрлэжээ.

График 59. Хүүхдийг цахим, интернэт орчинд хамгаалдаг хэлбэр



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.10

Хүүхдүүдтэйгээ ярилцах нь хамгийн зөв арга гэж үзсэн. Тэгвэл хүүхдүүддээ ямар зөвлөгөөг өгч байсан талаар тодрууллаа. Судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдийн 66% нь танихгүй хүнтэй найз болох нь эрсдэлтэй талаар, 55% нь нууц үг, хувийн мэдээллээ өгч болохгүй талаарх зөвлөгөөг өгч байсан байна. Харин интернэтийг аюулгүй ашиглах арга зам, ямар нэгэн зүйл тохиолдвол юу хийх нь хамгийн зөв зэрэг талаар зөвлөгөө өгч байсан байдал хангалтгүй байна. Өсвөр насныхан маш сониуч байдаг нь тэднийг шинэ зүйлийг туршиж үзэх сэдлийг төрүүлдэг. Тиймээс эцэг, эхчүүдийн хувьд эрсдэлтэй нөхцөлд ямар арга хэмжээ авах талаарх зөвлөмжийг өгөх нь хүүхдүүдээ эрсдэлээс хамгаалахад чухал нөлөөтэй юм. Уг үр дүнг байршлаар нь харахад Улаанбаатар хотын эцэг, эхчүүдийн хүүхдэдээ зөвлөгөө өгөх байдал орон нутгийнхантай харьцуулахад өндөр байлаа.


График 60. Хүүхдүүддээ зөвлөгөө өгч байсан байдал



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.11

Интернэт орчноор дамжуулан үйлдэгдсэн гэмт хэргийн талаар аав, ээжүүдийн 89% нь сонссон ба тэднийг сонсож байсан гэмт хэргүүдийн талаар нээлттэй тодруулахад 27% нь цахим залилан, луйврын талаар сонсож байсан байна. Үүний дараа 11% нь танихгүй хүнтэй танилцах, 9% нь хүчирхийллийн талаар сонсож байжээ. Харин хувийн мэдээллээ алдах, чатаар хүнтэй танилцаж эрсдэлд орох, садар самуунд уруу татагдах зэргийн талаар 10 хүрэхгүй хувь нь сонсож байсан байна.

График 61. Сонсож байсан цахим гэмт хэргүүд



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.14

60 гаруй хувь нь аюултай хүмүүстэй холбогдож дарамт, шахалтад орох, гэмт хэргийн золиос болох, элдэв муу зуршилд автах, донтох болон хувийн нууц мэдээллээ алдах талаар сонсож байсан байна. Байршлаар харахад өмнөтэй адил буюу Улаанбаатар хотын хүмүүс цахим гэмт хэргийн талаар сонссон байдал илүү байна.


График 62. Интернет орчноор дамжуулан үйлдсэн гэмт хэргийн талаар сонсож байсан эсэх



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.15

Эцэг, эхчүүдийн 54% нь 15-18 насны хүүхдүүд энэ төрлийн эрсдэлд хамгийн их өртөх магадлалтай гэж үзэж байгаа бол 39% нь 10-14 насныхан гэж хариулжээ. Тэдний хувьд 7-9 насныхан болон 19-с дээш насныхан өртөх магадлал хамгийн бага гэж үзэж байна. Энэ хандлага аав, ээжүүдийн хувьд ижил байлаа.

График 63. Цахим халдлагад өртөх өндөр эрсдэлтэй нас



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 3.16

4. ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ЦАХИМ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ТУРШЛАГА, ХАНДЛАГА БОЛОН МЭДЭЭЛЭЛ АВДАГ СУВАГ


Бүлгийн хураангуй үр дүн

- Эцэг, эхчүүдийн **91% нь өөрийн хүүхдээ цахим орчны халдлагад өртөж байгаагүй** гэжээ. Гэтэл хүүхдүүдийн судалгаанаас харахад тэдний багагүй хувь нь цахим орчны халдлагад өртөж байсан нь харагдсан. Тэгэхээр энэ нь хүүхдүүд нь эцэг, эхдээ цахим дарамтад өртсөн гэдгээ хэлдэггүй гэсэн үр дүнг бататгаж байна.
- Эцэг, эхчүүдийн **11% нь хүүхдүүдийнхээ +18 агуулгатай зураг харж, үзэж байхыг санамсаргүй байдлаар харж байсан бол 6% нь доромжилсон, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зураг, видео үл таних хүнээс чат, мессежээр хүүхдэд ирж байсан** гэжээ. Харин санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаарх мессеж ирж байсан гэж 5% нь хариулжээ.
- Гэрийн компьютер, таблет, гар утас зэрэгт **74% нь ямар ч хамгаалалт хийдэггүй, хэрхэн хамгаалалт хийх вэ гэдгийг мэдэхгүй** байна.
- Эрсдэлээс хамгаалах зорилгоор **хүүхдийнхээ гар утасны хэрэглээг хянадаг гэж 73% нь хариулсан ба гар утсыг нь үзэж шалгах, цагийн хязгаарлалттай үзүүлэх, утсыг нь хурааж авах, юу үзсэнийг нь харах зэргээр хяналт хийдэг.**
- Гэхдээ **хүүхдийн гар утасны хэрэглээг хянахад тусалдаг аппликейшний талаар 96% мэдэхгүй.**
- Цахим сүлжээнд **олон цагийг зарцуулах нь нүдний хараанд муугаар нөлөөлж, ядаргаанд оруулж, донтуулахаас гадна хичээл номдоо муу болох сөрөг үр дагавартай** гэж боддог байна. Харин нуруу нугасны зөв бус хөгжил, сэтгэл санааны тавгүй байдал, зожиг болох зэрэг эрсдэлийг бага байдаг гэжээ.
- **Танихгүй хүмүүстэй цахим орчинд найз болохгүй байх, цахим хаягийн нууц үгээ тогтмол солих нь хүүхдүүд өөрийг хамгаалах хамгийн сайн арга** гэж эцэг, эхчүүд дүгнэж байна.
- Цахим халдлагаас сэргийлэхэд эцэг, эхийн үүрэг оролцоо маш чухал гэдэгтэй бүгд санал нэгдсэн бол **10 хүн тутмын 7 нь хүүхдээ интернэт цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах талаар заавар, зөвлөгөө байнга өгч, ярилцдаг** гэжээ.
- 10 хүн тутмын 4 нь **өсвөр насны хүүхдүүд өөрийн нүцгэн зургаа цахим орчинд тавьж байхыг харж байсан бол 63% нь өсвөр насны хүүхэд цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар ярьж байхыг сонсож байсан** гэжээ.
- **Интернэтийн зохистой хэрэглээ, хор хөнөөл болон урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг телевизээс авч байна.** Энэ талаарх мэдээллийг интернэтээс авах байдал 37% байгаа нь телевизтэй харьцуулахад бараг 2 дахин бага байна.
- **10 эцэг, эх тутмын 7 нь Ekids.mn, happywebs.mn сайтуудаар орж нийтлэл, мэдээлэл уншиж байгаагүй байна.** Мэдлэг, мэдээлэлтэй байх нь өөрийгөө хамгаалах хамгийн сайн арга тул эдгээр сайтуудын хэрэглээг сурталчлах, эцэг эхчүүд болон хүүхдүүдийн үздэг хувилбараар байршуулах шаардлагатай байна.

Бүлгийн дэлгэрэнгүй үр дүн

Цахим орчиндох хүүхдэд хамгааллын судалгааны онцлог нь зөвхөн хүүхдүүдийн санал бодлыг сонсох бус, эцэг, эхийн ойлголт, мэдлэг, туршлагыг хамтад нь судалсан. **Эцэг, эхчүүдээс өөрийн хүүхдээ цахим орчны халдлагад өртөж байсан гэж бодож байгаа эсэхийг тодруулахад тэдний дөнгөж 4% нь л тийм, 91% нь үгүй, үлдсэн 4% нь хэлж мэдэхгүй байна гэсэн хариултыг өгчээ.** Гэтэл хүүхдүүдийн судалгаанаас харахад тэдний багагүй хувь нь цахим орчны халдлагад өртөж байсан нь харагдсан. Энэ нь эцэг, эхчүүд хүүхдүүддээ ямар асуудал байгааг төдийлөн мэддэггүй, нөгөө талаасаа хүүхдүүд нь эцэг, эхдээ асуудлаа хэлдэггүй гэдгийг бататгаж байгаа юм.

График 64. Хүүхдээ цахим орчны халдлагад өртөж байсан гэж бодож байгаа эсэх



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.1

Судалгааны явцад 13-18 насны хүүхдүүдээс асуусантай адилаар цахим орчны халдлагын кэйсүүдийг тодорхойлж, өөрийн хүүхдэд нь тохиолдож байсан талаар тодруулсан. **Хүүхдүүдийн судалгаатай харьцуулахад хачирхалтай үр дүн гарсан нь эцэг, эхчүүдийн 90 орчим хувь өөрийн хүүхдээ ийм төрлийн цахим дарамтад өртөж байгаагүй гэж хариулсан явдал юм.** Энэ нь нэг талаараа хүүхдүүд нь эцэг, эхдээ цахим дарамтад өртсөн гэдгээ хэлэхгүй байгааг харуулж байна. Эцэг, эхчүүдийн 11% нь хүүхдүүдийнхээ +18 агуулгатай гэдэг нь илэрхий зураг харж, үзэж байхыг санамсаргүй байдлаар харж байсан бол 6% нь доромжилсон, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зураг, видео үл таних хүнээс чат, мессежээр хүүхдэд ирж байсан гэжээ. Харин санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаарх мессеж ирж байсан гэж 5% нь хариулжээ.

График 65. Хүүхдүүд нь цахим халдлагад өртөж байсан талаараа хэлж байсан эсэх



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.2

Эцэг, эхчүүдийн хувьд цахим орчны халдлагын талаар хүүхдүүдээ зөвлөгөө өгдөг талаар өмнөх үр дүнгээс харж болно. Хэдий хэлж сануулж байгаа боловч хүүхдүүд уг сануулгыг хайхрахгүй өнгөрөх магадлалтай юм. Хамгийн сайн аргуудын нэг нь технологи дээр суурилсан хамгаалах арга хэрэгслүүд байдаг. **Гэрийн компьютер, таблет, гар утас зэрэгт хүүхдүүдээ цахим орчноос хамгаалах чиглэлээр ямар хамгаалалт хийдэг болохыг тодруулахад 74% буюу 10 эцэг, эх тутмын 7 нь хэрхэн хамгаалалт хийх вэ гэдгийг мэдэхгүй байна.** Энэ нь эцэг, эхчүүдийн технологийн талаарх мэдлэг болон гадаад хэлний мэдлэг тааруу байдагтай холбоотой.


График 66. Гэрийн компьютер, таблет, гар утас зэрэгт цахим орчноос хамгаалах программ, арга зэргийг ашигладаг эсэх



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.3

Хүүхдүүдийгээ эрсдэлээс хамгаалах зорилгоор гар утасны хэрэглээг хянадаг болохыг тодруулахад 73% нь хянадаг гэж бодож байгаа бөгөөд энэ тоон үр дүн нь ээжүүдийн хувьд 80% болж нэмэгдэж байна. Харин аав нарын хувьд 65% болж буурч байлаа. Эцэг, эхчүүдийн хувьд технологи ашиглахгүйгээр хэлж сануулах байдлаар хяналтыг хийж байгаа нь харагдсан.

График 67. Хүүхдийнхээ гар утасны хэрэглээг хянадаг эсэх



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.4

Эцэг эхчүүд хүүхдийнхээ гар утасны хэрэглээг хянахдаа гар утсыг нь үзэж шалгах, цагийн хязгаарлалттай үзүүлэх, утсыг нь хурааж авах, юу үзсэнийг нь харах зэргээр хяналт хийдэг байна.

График 68. Хэрхэн хүүхдийнхээ гар утсыг хянадаг болох



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.5

Хүүхдийн гар утасны хэрэглээг хянахад тусалдаг олон төрлийн аппликэйшн байдаг талаар мэддэг эсэхийг нь тодруулахад 96% нь аль ч аппликэйшнийг мэддэггүй байна. Мөн орон нутагт амьдардаг аав ээжүүдийн тус аппликэйшнийг мэддэг байдал Улаанбаатар хотынхтой харьцуулахад 6 пунктээр бага байна.

Хүснэгт 18. Хүүхдийн гар утасны хэрэглээг хянахад туслах аппликэйшийн талаар мэддэг эсэх


Гар утасны хэрэглээг хянахад туслах аппликэйшн	Аав	Ээж	Улаанбаатар	Орон нутаг	Нийт
Мэдэхгүй	96%	95%	92%	98%	96%
Circle App ашигладаг	0%	0%	0%	0%	0%
Kidbridge ашигладаг	1%	1%	1%	0%	1%
Kidgy ашигладаг	1%	1%	1%	0%	1%
Net Nanny ашигладаг	1%	1%	2%	0%	1%
Parental controll ашигладаг	2%	1%	3%	0%	1%
FamiSafe ашигладаг	1%	0%	1%	0%	0%
Spyzie ашигладаг	0%	0%	0%	0%	0%
mSpy ашигладаг	0%	0%	1%	0%	0%
Family link ашигладаг	1%	1%	2%	0%	1%
Net Nanny ашигладаг	0%	0%	0%	0%	0%
Norton Family ашигладаг	1%	0%	1%	0%	0%
Family Time ашигладаг	1%	2%	2%	1%	1%
Бусад бичих	1%	2%	2%	1%	1%

Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.6

Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Насанд хүрээгүй хүүхдийн цахим орчинд хийсэн буруу үйлдэл нь хариуцлага хүлээх хэмжээнд хүрвэл эцэг эх, асран хамгаалагч нь хариуцлага хүлээнэ гэдгийг 77% нь мэддэг гэжээ. Үүнийг мэдэх байдал аав, ээжүүдийн хувьд ойролцоо түвшинд байна.


График 69. Насанд хүрээгүй хүүхдийн цахим орчинд хийсэн үйлдэлд эцэг эх нь хариуцлага хүлээдгийг мэддэг эсэх



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.7

Эцэг, эхчүүд хүүхдэдээ интернэтээр худалдан авал хийх боломжтой банкны картыг өгөхгүй байх хандлага ашиглагдсан. 87% нь интернэтээр худалдан авалт хийх боломжтой банкны карт байхгүй байгаа нь энэ төрлийн цахим халдлагад өртөг эрсдэлийг бууруулж байна.


График 70. Хүүхдэд нь интернэтээр худалдан авалт хийх боломжтой банкны карт байгаа эсэх



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.8

Банкны карттай хүүхдийнхээр картыг нь 53% буюу 2 хүн тутмын 1 нь хянадаггүй байна. Ялангуяа орон нутгийн эцэг, эхчүүд хянахгүй байх хандлага өндөр байна. Эндээс орон нутгийн эцэг, эхчүүдийн аливаа мэдлэг Улаанбаатар хотын эцэг, эхчүүдтэй харьцуулахад бага байгааг харж болно.

График 71. Интернэтээр худалдан авалт хийх боломжтой банкны картыг хянадаг эсэх



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.9

Цахим сүлжээнд олон цагийг зарцуулах нь хүүхдүүдийн нүдний хараанд муу гэж 92% нь үзэж байна. Дараа нь 85% нь ядаргаанд ордог, 75% нь донтох, 71% нь хичээл номдоо муу болох сөрөг талуудтай гэж боддог байна. Харин нуруу нугасны зөв бус хөгжил, сэтгэл санааны тавгүй байдал, зожиг болох зэргийн эрсдэлийг бага байдаг гэж боддог байна.

График 72. Цахим сүлжээнд олон цагийг зарцуулснаар бий болох сөрөг үр дагавар, эцэг, эхийн бодлоор



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.11

Танихгүй хүмүүстэй цахим орчинд найз болохгүй байх нь хүүхдүүд өөрийг хамгаалах хамгийн сайн арга гэж эцэг, эхчүүд дүгнэж байна. Мөн цахим хаягийн нууц үгээ тогтмол солих нь өөрсдийгөө хамгаалах арга гэжээ.

График 73. Цахим орчинд хүүхдүүд өөрийг хамгаалах үүднээс хийх ёстой үйлдлүүд



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.10

Интернэтийн зохистой хэрэглээ, хор хөнөөл, хэрхэн өөрийгөө болон бусдыг цахим орчны гэмт хэрэг, дарамт шахалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг эцэг, эхчүүдийн мэдээлэл авдаг хамгийн гол суваг нь телевиз байна. Үүний дараа интернэтээс мэдээлэл авдаг гэж 37% нь хариулсан байгаа нь телевизтэй харьцуулахад бараг 2 дахин бага байна. Мөн аавуудын хувьд энэ талын мэдээлэл авч чадахгүй байгаа байдал нь ээжүүдтэй харьцуулахад 2 дахин их байна. Хүүхдийнхээ анги удирдсан багшаас 30% нь, цагдаагийн байгууллагаас 19% нь авдаг бол интернэт үзүүлэгч байгууллагаас дөнгөж 14% нь авч байгаа нь маш хангалтгүй юм.

График 74. Эцэг, эхчүүдийн интернэтийн хор хөнөөл, дарамт, зохистой хэрэглээний талаарх мэдээлэл авдаг эх үүсвэр



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.12

Эцэг, эх болон хүүхдүүдийг цахим орчны дарамт, халдлагын талаар мэдээлэл болгох зорилготой Ekids.mn, happywebs.mn сайтуудаар орж үзэж, нийтлэл уншиж байгаагүй гэж 10 эцэг, эх тутмын 7 нь хариулжээ. Мэдлэг, мэдээлэлтэй байх нь өөрийгөө хамгаалах хамгийн арга тул эдгээр сайтуудын хэрэглээг сурталчлах, эцэг эхчүүд болон хүүхдүүдийн үздэг хувилбараар байршуулах шаардлагатай байна.

График 75. Ekids.mn, happywebs.mn сайт руу орж байсан эсэх



Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.15

Эцэг, эхчүүд цахим дарамтын талаар мэдлэгтэй байхаас гадна зөв хандлага байх нь маш чухал. Үүнийг тодруулах зорилгоор эцэг, эхчүүдээс асуусан хандлагын асуултын хариултыг доорх

хүснэгтэд нэгтгэн харууллаа. Хүүхдийн интернэт хэрэглээнд хяналт тавих нь эцэг, эхчүүдийн үүрэг мөн, хүүхдээ цахим халдлагаас сэргийлэхэд эцэг, эхийн үүрэг оролцоо маш чухал гэдэгтэй бараг бүх эцэг, эхчүүд санал нэгдсэн. Эцэг, эхчүүд сошиал медиа их ашиглах нь хүүхдүүдэд буруу үлгэр дуурайлал болж байгаа гэдэгтэй 89% нь санал нэгдсэн. 10 хүн тутмын 7 нь буюу 72% нь хүүхдээ интернэт цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах талаар заавар, зөвлөгөө байнга өгч, ярилцдаг гэж хариулсан. Харин 10 хүн тутмын 4 нь буюу 40% нь өсвөр насны хүүхдүүд өөрийн нүцгэн зургаа цахим орчинд тавьж байхыг харж байсан гэсэн нь аюултай нөхцөл байдал юм.

Хүснэгт 19. Цахим орчны талаарх эцэг, эхчүүдийн хандлага

Ойлголтууд	Нийт	Хүйс		Байршил	
		Аав	Ээж	УБ	Орон нутаг
Хүүхдээ цахим халдлагаас сэргийлэхэд эцэг эхийн үүрэг оролцоо маш чухал	99%	99%	100%	99%	99%
Хүүхдийнхээ интернэт хэрэглээнд хяналт тавих нь эцэг эхчүүдийн үүрэг мөн	99%	98%	100%	99%	99%
Эцэг, эхчүүд сошиал медиа их ашиглах нь хүүхдүүдэд буруу үлгэр дуурайлал болж байна	89%	86%	92%	88%	90%
Интернэт тоглоомууд, веб сайтууд хэдийгээр “нас баталгаажуулалт” хийдэг ч тэдгээр нь хангалттай хэмжээнд ажилладаггүй, хуурах боломжтой байдаг	84%	84%	84%	85%	83%
Би хүүхдэдээ интернэт цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах талаар заавар, зөвлөгөө байнга өгч, ярилцдаг	72%	68%	75%	70%	73%
Хүүхдүүд маань интернэтийг аюулгүй болоод айдасгүйгээр ашиглаж чадаж байгаа	63%	66%	61%	60%	65%
Өсвөр насны хүүхэд цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар ярьж байхыг сонсож байсан	63%	59%	66%	63%	63%
Би 7-18 настай хүүхдүүдийнхээ зургийг фейсбүүкт оруулдаггүй	55%	55%	56%	60%	52%
Өсвөр насны хүүхдүүд өөрийн нүцгэн зургаа цахим орчинд тавьж байхыг харж байсан	40%	37%	43%	42%	39%

Эх үүсвэр: 7-12 настай хүүхэдтэй эцэг эхээс авсан судалгаа, асуулт 4.13
Жич: Ногоон болох тусам өндөр, улаан болох тусам бага хувьтай байгааг илэрхийлнэ.

Өөр цочирдуулам үр дүн гарсан нь эцэг, эхчүүдийн 63% нь өсвөр насны хүүхэд цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар ярьж байхыг сонсож байсан. Энэ байдал Улаанбаатар болон орон нутагт ижил байгаа бөгөөд ээжүүд энэ талаар илүү их сонсож байжээ.

3.3 ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

1. ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХАНД ЗОРИУЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Кампанит ажлын зорилго

Хүүхэд, өсвөр насныхан буюу 7-18 насныхны цахим орчны хэрэглээ, цахим орчинд өөрийгөө дарамт шахалт, доромжлол, гэмт хэрэгт өртөх эрсдэлээс хэрхэн хамгаалах талаарх мэдлэг олгох.

Зорилтот бүлгийн нарийвчилсан тодорхойлолт

Зорилтот бүлгийг үндсэн 3 хэсэгт хуваасан. Үүнд:

- 7-18 насны хүүхэд:** Төрөнгүүтээ интернэт, сошиал медиа, ухаалаг төхөөрөмжтэй танилцсан буюу тэдгээр нь энэ үеийнхний амьдралын салшгүй нэг хэсэг. Тиймээс, эдгээрийг тэдний амьдралаас ор тас хорих нь үр дүнгүй. Харин зохистой хэрэглээг хэвшүүлэх нь чухал. Тэд цахим орчин аюултай гэдгийг мэддэг ч түүний эсрэг, өөрийгөө хамгаалах ямар нэг үйлдэл бараг хийдэггүй.
- Тэдгээрийн ээж аав, асран хамгаалагч:** Энэ бүлгийнхэн цахим орчны аюулын талаар мэдлэг тун тааруу байна. Ямар арга хэмжээ авах талаар мэдлэггүй байна.
- Оролцогч талууд:** Эдгээр хүмүүс хэрэглэгчдийнхээ энэ талын мэдлэгийг нэмэгдүүлэх, аюул, халдлагаас сэргийлэх тухай оролдлого, сануулга, дорвитой ажил хийдэггүй аж.
 - Багш
 - Найзууд
 - Найзуудын эцэг эх
 - Сургалт, дугуйлангийн багш нар
 - Бизнесийн байгууллагууд буюу интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд
 - Энэ асуудлыг хариуцсан төрийн байгууллагууд
 - Энэ асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагууд
 - Бодлого боловсруулагчид

Коммуникэйшн стратеги (Communication strategy)

Дээр дурдсан зорилтот бүлэгт хүргэх гол болон дэд мессежнүүдийг тодорхойлохдоо судалгааны үр дүнд үндэслэсэн. Мөн гол мессежнүүдийг дараах 3 дарааллаар зорилтот бүлэгт хүргэнэ.

- Анхаарал татах:** Жишээ нь, цахим халдлагад өртсөн хүүхдүүдийн кэйсүүдийг танилцуулснаар зорилтот бүлгийн анхаарлыг татна.
- Үйлдэл хийлгэх:** Цахим гэмт халдлагаас хэрхэн сэргийлэх тухай аргуудыг зааж өгсөн контентууд. Мөн үүнийг технологийн боломжийг ашиглан хийж болно. Жишээ нь, хэн нэгэн танихгүй хүн чатлах хүсэлт илгээсэн үед өөдөөс нь нэр, регистрийн дугаар зэргээ хийхийг шаардсан линк илгээж, тухайн хүнийг гэрэл зурагтайгаа адилхан, ямар нэг гэмт

хэргийн сэдэлгүй хүн болохыг баталгаажуулдаг жижиг аппликэйшн бүтээж болох юм. Хэрэв тус апп-д мэдээллээ оруулахаас татгалзвал түүнийг эрсдэлтэй гэдгийг мэдэн чатлахгүй.

- 3. Зуршил болгох:** Сануулсан контентууд. Мөн технологийн шийдэл. Жишээ нь IP хаягаас нь эрсдэлтэй цахим хуудаснуудад орсон IP хаягийн байршлуудыг харуулдаг шийдэл. Үүнд үйлчилгээний байгууллага болон өрхүүдийг хамруулна. Өөрөөр хэлбэл, охид, хүүхдүүд үйлчилгээний газрын аюулгүй байдлыг харж байгаад хаана үйлчлүүлэхээ шийднэ. Мөн эцэг эхчүүд хүүхдийн очих гэж буй айлын аюулгүй байдлыг мөн хянаж байж шийднэ. Ийм технологийн боломж бий болсноор, хүүхдүүд, эцэг эх энэхүү хянах, шалгах үйлдлийг зуршил болгоно. Мөн хүмүүс өөрсдийнхөө буруу зуршлыг засах хөшүүрэг болно.

Гол болон дэд мессежнүүдийг Microsoft Excel Хавсралт №1-ээс харна уу.

Медиа стратеги (Media strategy)

Гол зорилтот хэрэглэгчдэд хүрэх медиа сувгуудыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- **Сошиал сувгууд:** Зорилтот бүлэг ихэнх цагаа сошиалд өнгөрөөдөг тул тэдэнд энэ сувгаар дамжуулж мэдээлэл хүргэх нь хамгийн үр дүнтэй. 96% нь фейсбүүк, 89% нь фейсбүүкийн мессенжер ашигладаг.
- **Интернэт сувгууд:** Мэдээний сайтууд гэх мэт интернэтийн бусад сувгуудыг ашиглах хэрэгтэй. Энэ нь хүүхдүүдээс бусад зорилтот бүлгийнхэнд мэдээлэл хүргэхэд тустай.
- **Уламжлалт-Телевиз:** Интернэтэд тэр бүр орж чаддаггүй, хотын захын болон алслагдсан хорооллын зорилтот бүлгийн хүүхдүүдэд зурагтаар дамжуулан мэдээлэл хүргэх нь үр дүнтэй. Gen Z-үүдийн 62% нь телевиз үздэг. Эх үүсвэр: MMCG – Үндэсний медиа хэрэглээний судалгаа - 2020
- **Уламжлалт-Самбар:** Хэдийгээр уламжлалт сувагт тооцогддог ч гудамжны самбар, автобусны буудлын самбар, ханан дээр наасан зурагт хуудас зэрэг нь зорилтот бүлгийнхний хамгийн их байдаг, зорчдог, явж өнгөрдөг байршлуудад байхдаа мэдээллийг маш сайн өгдөг. Гэхдээ энэ төрлийн сувгуудыг анхаарал татах түвшинд ашиглах нь илүү тохиромжтой. Gen Z-үүдийн 85% нь гаднах самбараас мэдээлэл авдаг. Эх үүсвэр: MMCG – Үндэсний медиа хэрэглээний судалгаа - 2020
- **Шинэ буюу new media сувгууд:** Зорилтот бүлэгт зориулж 108 утасны мессенжер хувилбарыг гаргах нь үр дүнтэй. Бичиж буй хүүхдийн нэр, зураг харагддаггүй, дата ашиглах шаардлагагүй буюу тухайн мессенжер платформ руу ороход интернэтийн сүлжээ шаардлагагүй байх хэрэгтэй. Эсвэл интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компани тухайн платформ руу орох эрхийг нээлттэй болгож болох юм.

Хэрэгжүүлэх кампанит ажлуудын санаа, хөгжүүлэлт

7-18 настай хүүхдүүдийн хувьд дараах кампанит ажлуудыг зохион байгуулах боломжтой. Үүнд:

№	СУДАЛГААНЫ ҮР ДҮН	АЯНЫ НЭР	АГУУЛГА
1	Өдөрт дунджаар 4 цагийг цахим орчинд өнгөрүүлдэг ашигладаг	Цахим Биеэ Цэвэрлэе Цахим Гэрээ Цэвэрлэе	Цахимыг зөв хэрэглэх тухай зөвлөгөөнүүд
2	Конвиненс дэлгүүр, кофе шоп, РС тоглоомын газруудын үнэгүй Wi-Fi ашигладаг	Үйлчилгээний Газруудыг Аюулгүй Болгоё	Үйлчилгээний байгууллагуудын интернэтээс аюултай, ёс бус цахим хуудаснуудад нэвтрэх боломжгүй болгох, үйлчилгээний газруудыг тийм апп, программ хангамж ашиглахыг уриалах
3	Фейсбүүкийн илүү дугаараа ашиглах зорилго нь бусадтай чатлах – 61%	Танихгүй Чатлагчийн Гарал Үүслийг Баталгаажуулъя	Дээр дурдсан танихгүй чатлагч нэр, регистрийн дугаараа оруулснаар өөрийгөө гэмт хэрэгтэй эсвэл цахим дарамтлагч биш болохыг баталгаажуулдаг апп
4	Эцэг, эхчүүдийн 86% нь оройн цагаар сошиал медиа ашигладаг	Амьд Харилцааг Амилуулъя	Гэр бүлийн ихэнх гишүүд цахимд цагаа өнгөрүүлж, гар утсаа ширтсэнээр бие биедээ анхаарал тавьдаггүй. Энэ байдлыг таслан зогсоох зорилгоор гэр бүлийнхний дунд амьд харилцааг дэмжсэн үйлдлүүдийг санал болгох, уриалах
5	77%-д нь фейсбүүкийн 1-с олон хаягтай найз байдаг	Олон Хаягаа Устгая	Олон хаягтай хүүхдүүдийг хаягаа устгахыг уриалах
6	60% нь фейсбүүкийн найзууд дунд мэдэхгүй, танихгүй хүн байдаг	Танихгүй Хүнд Но Гэж Хэлье	Танихгүй хүн танилцах гээд, найз болох гээд хүсэлт илгээх үед үл тоомсорлохыг уриалах
7	фейсбүүкийн шинэ найзтай болоход өөрийнх нь найзтай нь найз болсон байх, гоё профайл зурагтай	Шалгая, Баталгаажуулъя	Танихгүй хүн найзын хүсэлт илгээсэн эсвэл чатлах гээд ороод ирэх үед түүнийг аюулгүй болохыг хэрхэн баталгаажуулах аргуудыг

	байхыг л чухалчилж хардаг		зааж, түүний дагуу шалгадаг байхыг уриалах
8	23% буюу 4 хүүхэд тутмын 1 нь public тохиргоотой пост оруулдаг	Сошиал Дах Мэдээллээ Цэгцэлье	Сошиалд оруулсан ямар мэдээллээ хэрхэн бичих, ямар тохиргоо хийхийг заасан, улмаар түүний дагуу зөв, аюулгүй болгож засахыг уриалах
9	10 хүүхэд тутмын 6-7 нь интернэтийг аюулгүй гэж үзэж байна	Мэдэж Аваад Өөрийгөө Хамгаалъя	Хүүхдүүдэд аюултай байж болох бүх зүйлсийг таниулсан, улмаар түүнийг марталгүй санаж байхыг уриалах
10	79% нь төрөл бүрийн сонжоо, таавар, азаа үзэх зэрэг холбоос дээр дарснаар хувийн мэдээлэл, фейсбүүкийн нууц үг, хаяг, дансны мэдээллээ бусдад алдах эрсдэлтэй байдаг гэдгийг мэддэг боловч хэрэв сонирхолтой бол дарж үздэг	Сэжигтэй Юман Дээр Дарахгүй	Ямар өргөтгөлтэй, хэлбэртэй, нэр устай файл хувийн мэдээллийг сорж, аюул оруулдгийг тайлбарласан, улмаар түүний дагуу сэжигтэй зүйл дээр дарж, нээхгүй байхыг уриалсан
11	37%-д нь доромжилсон, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зураг, видео үл таних хүнээс чат, мессежээр ирж байсан	Цахим Хүчирхийлэгчийг Ил Болгоё	Цахимаар дарамталсан мессежнүүд, тохиолдол болон дарамтлагчийг ил болгохыг уриалах
12	52% буюу 2 хүүхэд тутмын 1 нь хэрэв сонирхолтой мэдээлэл байвал шууд дарж үздэг	Хуурамч Мэдээллийг Нягталъя	Хуурамч мэдээллийн шинж чанар, түүнийг хэрхэн нягтлах аргуудыг зааж, улмаар нягталж байхыг уриалах
13	34% нь манай үе тэнгийн хүүхдүүд нүцгэн зургаа цахим орчинд тавьж байхыг харж байсан	Хэт Их Хүссэн Зүйл Чамайг Хохирогч Болгоно	Олны танил болох, бусдад таалагдах гэх мэт хэт их хүссэн зүйл дээр нь дөрөөлж хүүхдүүдийг хохирогч болгодгийг таниулж, чи байгаагаараа "од", "таалагддаг" гэдгийг ойлгуулж, хэт их хичээхгүй байхыг уриалах

14	91% нь доромжилсон, хараалын үг ашигласан, хэн нэгнийг доош нь хийсэн сэтгэгдлүүд хаа сайгүй байдаг	Постоо Цэгнэе	Үгээр хүнийг алж болдгийг ойлгуулсан, тоглоомоор бичсэн үгс, оруулсан пост хүмүүст хэрхэн тусч, тэдний амьдралыг орвонгоор нь эргүүлдгийг ойлгуулж, улмаар ярьж, бичихээ цэгнэхийг уриалах
15	Найзуудад нь дунджаар 3-4 фейсбүүкийн хаяг бий. Хамгийн ихдээ 10 фейсбүүкийн хаягтай хүүхэд байсан	Хаягуудыг Шалгая	Хуурамч хаягийг хэрхэн шалгах тухай аргуудыг зааж, цаашид түүнийг зуршил болгохыг уриалах
16	1 хүүхэд дунджаар 3.7 цахим дарамтын тохиолдолтой таарч байсан.	Та Цахим Дарамтлагч Биш Биз?	Цахим дарамтлагч гэж хэн болохыг сонжоогоор ойлгуулж, цаашид бичиж буй постоо цэгнэхийг уриалах
17	34% нь манай үе тэнгийн хүүхдүүд нүцгэн зургаа цахим орчинд тавьж байхыг харж байсан	Нүцгэн Байхыг Минь Битгий Хараарай	Нүцгэн зургаа олон нийтэд ил тавихгүй байхыг уриалах
18	57% нь үе тэнгийнхний цахим дарамт их байдаг гэж хариулсан. 10 хүүхэд тутмын 7 нь өмнө нь хэн нэгнийг блоклож байсан	Bye Block	Цахимаар дээрэлхэгчдийг блокложыг уриалах

Аяны нэрийг криэтив багийн тусламжтайгаар дахин сайжруулах шаардлагатай.

2. ЭЦЭГ, ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Кампанит ажлын зорилго

7-18 насны хүүхэдтэй эцэг, эхчүүдийн цахим орчны дарамт шахалт, доромжлол, гэмт хэрэгт хүүхдээ өртөх эрсдэлээс хэрхэн хамгаалах талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх.

Зорилтот бүлгийн нарийвчилсан тодорхойлолт

Зорилтот бүлгийг үндсэн 3 хэсэгт хуваасан. Үүнд:

4. **7-18 насны хүүхэд:** Төрөнгүүтээ интернэт, сошиал медиа, ухаалаг төхөөрөмжтэй танилцсан буюу тэдгээр нь энэ үеийнхний амьдралын салшгүй нэг хэсэг. Тиймээс, эдгээрийг тэдний амьдралаас ор тас хорих нь үр дүнгүй. Харин зохистой хэрэглээг хэвшүүлэх нь чухал. Тэд цахим орчин аюултай гэдгийг мэддэг ч түүний эсрэг, өөрийгөө хамгаалах ямар нэг үйлдэл бараг хийдэггүй.
5. **Тэдгээрийн ээж аав, асран хамгаалагч:** Энэ бүлгийнхэн цахим орчны аюулын талаар мэдлэг тун тааруу байна. Ямар арга хэмжээ авах талаар мэдлэггүй байна.
6. **Оролцогч талууд:** Эдгээр хүмүүс хэрэглэгчдийнхээ энэ талын мэдлэгийг нэмэгдүүлэх, аюул, халдлагаас сэргийлэх тухай ямар нэг оролдлого, сануулга, дорвитой ажил хийдэггүй аж.
 - Багш
 - Найзууд
 - Найзуудын эцэг эх
 - Сургалт, дугуйлангийн багш нар
 - Бизнесийн байгууллагууд буюу интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд
 - Энэ асуудлыг хариуцсан төрийн байгууллагууд
 - Энэ асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагууд
 - Бодлого боловсруулагчид

Коммуникэйшн стратеги (Communication strategy)

Дээр дурдсан зорилтот бүлэгт хүргэх гол болон дэд мессежнүүдийг тодорхойлохдоо судалгааны үр дүнд үндэслэсэн. Мөн гол мессежнүүдийг дараах 3 дарааллаар зорилтот бүлэгт хүргэнэ.

1. **Анхаарал татах:** Хүүхдүүдийнхтэй адилаар цахим халдлагад өртсөн хүүхдүүдийн кэйсүүдийг танилцуулснаар зорилтот бүлгийн анхаарлыг татна.
2. **Үйлдэл хийлгэх:** Эцэг эхүүд цахим яг юугаараа аюултай тухай мөн түүнээс хэрхэн сэргийлэх тухай мэдлэггүй. Бас хүүхдүүдтэйгээ энэ сэдвээр тэдний сонирхож сонсох хэмжээнд ярилцах, зөвлөх үр чадваргүй байна. Тиймээс, тэдэнд олон талын алхамчилсан зөвлөгөө, заавар хэрэгтэй байгаа юм. Тэр зөвлөгөөнүүд цахим орчинд хайлт хийхэд хамгийн түрүүнд олддог байх хэрэгтэй.
3. **Зуршил болгох:** Эцэг эхчүүдийг хүүхдийнхээ цахим аюулгүй байдлыг ажигладаг, шалгадаг, тэдэнд сануулдаг, ярилцдаг болгох хэрэгтэй. Энэ төрлийн контентуудын сард нэг удаа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах, гар утсанд нь мессежээр хүргэх хэрэгтэй.

Эцэг эхүүдэд хүргэх гол болон дэд мессежнүүдийг Microsoft Excel Хавсралт №2-оос харна уу.

Медиа стратеги (Media strategy)

Энэ сегмент сошиал болон уламжлалт сувгуудыг аль алийг нь ашигладаг. Гол зорилтот хэрэглэгчдэд хүрэх медиа сувгуудыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- **Сошиал сувгууд:** Үүнд фейсбүүк, твиттер, ютюб багтана. 93% нь фейсбүүк ашигладаг.
- **Интернэт сувгууд:** Мэдээний сайтууд гэх мэт интернэтийн бусад сувгуудыг ашиглах хэрэгтэй. Ikon.mn, gogo.mn, ugug.mn, zarig.mn гэх мэт
- **Уламжлалт-Телевиз:** Ялангуяа оргил цагуудад энэ мэдээллийг зурагтаар цацах нь үр дүнтэй. Ингэхдээ, өөрийн нэрийн нэвтрүүлэгтэй эсвэл дүр, ая, өнгө аястай болж нэг сувгаар цацах нь төсөвт хэмнэлттэй. 80-аас дээш хувь нь телевиз үздэг. Эх үүсвэр: MMCG – Үндэсний медиа хэрэглээний судалгаа - 2020
- **Уламжлалт-Самбар:** Хэдийгээр уламжлалт сувагт тооцогддог ч гудамжны самбар, автобусны буудлын самбар, ханан дээр наасан зурагт хуудас зэрэг нь зорилтот бүлгийнхний хамгийн их байдаг, зорчдог, явж өнгөрдөг байршлуудад байхдаа мэдээллийг маш сайн өгдөг. Гэхдээ энэ төрлийн сувгуудыг анхаарал татах түвшинд ашиглах нь илүү тохиромжтой. 70 орчим хувь нь гаднах самбараас мэдээлэл авдаг. Эх үүсвэр: MMCG – Үндэсний медиа хэрэглээний судалгаа - 2020
- **Уламжлалт-радио:** Өглөө ажил цугларах, орой ажил тарах, ид түгжрэлийн үеэр өөрийн нэрийн нэвтрүүлэг, ая өнгө аястай нэвтрүүлэгтэй болох хэрэгтэй. Эсвэл богино хэмжээний контентууд байж болно. 30 орчим хувь нь радио сонсдог. Эх үүсвэр: MMCG – Үндэсний медиа хэрэглээний судалгаа - 2020
- **Шинэ буюу new media сувгууд:** Энэ сегментэд олон талын зөвлөгөө, заавар хэрэгтэй. Тэд мэргэжлийн хүнийг сонсохын ач холбогдлыг мэднэ. Тиймээс тэдэнд мэргэжлийн хүний зөвлөгөө, зааврыг ойлгуулж, дижитал буюу видео хэлбэрээр шаардлагатай зөвлөгөөнүүдийг цувралаар хүргэнэ.

Хэрэгжүүлэх кампанит ажлуудын санаа, хөгжүүлэлт

Эцэг эх асран хамгаалагч нарын дунд дараах үндсэн 2 кампанит ажлыг зохион байгуулах боломжтой. Үүнд:

№	АЯНЫ НЭР	АГУУЛГА
1	Фейсбүүк, инстаграмыг 13 болон түүнээс дээш настай хүүхэд ашиглах эрхтэй гэдгийг 62% нь мэддэггүй. Эцэг, эхчүүдийн 91% нь өөрийн хүүхдээ цахим орчны халдлагад өртөж байгаагүй гэж боддог	Томчуудыг Мэдлэгжүүлье
		Энэ аяны хүрээнд томчуудыг цахим халдлагын талаар, хүүхдүүдийг хэрхэн хамгаалах төрөл бүрийг мэдлэгийг цувралаар олгоно

2	Цахим орчны дарамтад өртсөн найзуудынх нь 59% нь буюу 10 хүүхэд тутмын 6 нь эцэг, эхдээ хэлж байгаагүй байна	Томчуудад Аргыг нь Зааж Өгье	Энэ аяны хүрээнд томчуудыг хүүхдүүдтэй цахим халдлагын талаар хэрхэн ярих, тэднийг хүлээж авах хэлбэрээр ярилцах арга техникүүд, мөн технологид суурилсан шийдлүүдийг хэрхэн хийх аргуудыг зааж өгнө.
---	--	------------------------------	---

Аяны нэрийг креатив багийн тусламжтайгаар дахин сайжруулах шаардлагатай.

3. КАМПАНИТ АЖЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХ КОНТЕНТЫН ХЭЛБЭР БОЛОН БҮТЭЭЛЧ АЖЛУУД

1. Эцэг эхчүүдэд хүүхдүүдтэйгээ цахим орчны аюулгүй байдлын талаар хэрхэн ярилцах, зөвлөгөө өгөх, хэвлэмэл гарын авлага бүтээх
2. Дижитал гарын авлага бэлдэх
3. Хүүхдүүдэд комик, мем, аним хэлбэрээр мэдээлэл хүргэх. Жишээ нь, Хандгай, Билгүүний харандаагаар, Алимаагийн комик гэх мэт аль эрт олонд танигдсан контентуудыг ашиглах.
4. Богино хэмжээний кино, цуврал видеонууд хийх, сторителлинг. Жишээ нь, Choirongoo шиг ийм тохиолдуулан түүхээр контент хийх, цахим халдлагад өртөж байсан талаарх кэйсүүд.
5. Influencer буюу олны танил хүмүүсээр уриалга гаргуулах
6. User generated content хийх боломжийг бүрдүүлэх. Жишээ нь, найзыгаа хэрхэн цахим орчноос хамгаалах вэ?
7. Street art хийх. Жишээ нь барилга, гудамж талбайд цахим орчны аюулгүй байдлын сэдэвтэй зураг зуруулж болно.
8. Сонжоо хийх. Чи цахим орчинд хэр аюулгүй байна вэ?
9. Инфо график хийх
10. Гэрэл зурагтай нийтлэл бичих

4. ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БОЛОН ҮҮРЭН ОПЕРАТОР КОМПАНИУДЫН ХИЙЖ БОЛОХ АЖЛУУД

1. Parental control зэрэг шүүлтүүрийн программыг хэрэгчдэдээ ашиглахыг заавал санал болгодог байх.
2. Технологийн компаниуд +18 контентыг хязгаарлаж чаддаг байх. Жишээ нь, кино багцуудаас эротик киног хүүхдүүдэд үзэж болдоггүй байх.
3. Pop-Up сануулгууд гарч ирдэг болох. Сөрөг агуулгатай аливаа контентыг хүүхдүүдэд хүрэхээс өмнө дэлгэцэн дээр нь хориглосон утга бүхий сануулга гарч ирэх. Мөн интернэтийг удаан хугацаагаар ашигласан үед гарч ирэх.
4. Гар утасны оператор компанийн дугаарын бүртгэлийг сайжруулж, үнэгүй дугаар тараах явдлыг бууруулахад анхаарах.
5. Операторууд хүүхдүүдэд сануулга SMS илгээх
6. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг цахим гэмт хэргийн эсрэг компани ажил өрнүүлэхийн, цахим гэмт хэргээс хамгаалах үйлчилгээ зохиож, нэвтрүүлэхийг уриалах.
7. Тухайн айл болон үйлчилгээний газруудаас ёс бус сайтуудад нэвтэрсэн бол тэр нь олон нийтэд харагддаг программ зохиох.
8. Яриа өдөж, харилцаж, танилцах гэж буй этгээдийн "гарал үүслийг" баталгаажуулдаг программ зохиох.
9. Сошиал платформ болгоны дээр анхааруулсан хэсгүүд бий болгох (Фейсбүүк дээр Covid-19-н мэдээлэл байсан шиг).
10. Интернэт рүү ороод 30 минут эсвэл тодорхой хугацаа өнгөрсний дараа дохио дугардаг апп бүтээх. Хэрэв гаднын апп байдаг бол сурталчлах.
11. Хүүхдэд ээлтэй, хамгийн аюулгүй интернэтийн үйлчилгээ үзүүлэгч зэргээр шалгаруулах.

I 4. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 05 сарын 15-ны өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт, Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэлд тусгасан 3 чиглэлийн дагуу цаашид авч хэрэгжүүлж болох ажлын саналыг судалгааны үр дүн үндэслэн боловсруулаа.

1. ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

- Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийж, цахим орчинд хүүхэд хамгаалах талаар шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах.
- Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн нэр томъёог олон нийтэд ойлгомжтой болгох, Монгол хэлэнд хөрвүүлэх.
- Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн шүүлтүүрийн программ, эцэг эхийн хянах хэрэгсэл (parental control) программыг заавал ашигладаг байх нөхцөлийг бүрдүүлэх. Энэ талаарх мэдээллийг эцэг эхчүүдэд хүргэдэг байх.
- Хүүхдийн цахим орчны зохистой хэрэглээ, дэлгэцийн өмнө өнгөрүүлэх цагийн хязгаарыг хүүхдийн насны ангилалд тулгуурлан боловсруулж, стандарт гаргах. Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) нь хүүхдийг насны ангиллаар хувааж, 0-4 насны хүүхдэд цахим хэрэглээг хориглох, 5-10 насны хүүхдэд өдөрт 1 цагаас бага, 11-18 насны хүүхдэд өдөрт 2-оос бага цагийг дэлгэцийн өмнө өнгөрүүлэх стандартыг гаргасан.

2. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНД НИЙЦСЭН ТЕХНОЛОГИЙН АРГА ХЭМЖЭЭ

- Интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын оролцоог нэмэгдүүлэх. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх ажилд интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын оролцоо чухал. Юнивишн, Скаймедиа гэх мэт мэдээлэл технологийн компаниуд +18 контентыг хязгаарлаж чаддаг байх хэрэгтэй. Жишээ нь, кино багцуудаас эротик киног хүүхдүүдэд үзэж болдоггүй байх. Хэрэв үзэх шаардлагатай бол баталгаажуулалт заавал хийдэг болох. Мөн эцэг, эхчүүдэд parental control-ийн хяналтыг ашиглахыг зөвлөдөг байх нь чухал байна.
- Гар утасны оператор компанийн дугаарын бүртгэлийг сайжруулах. Үнэгүй тараадаг эсвэл маш хямд үнээр борлуулдаг үүрэн холбооны дугаарын ард маш олон гэмт хэрэг холбогддог. Дугаарын бүртгэлийг сайжруулснаар фейсбүүкийг и-мэйл хаягаар нээдэггүй зөвхөн гар утасны хаягаар нээдэг болгох боломжийг судлах. Ингэснээр хүнийг гутаан доромжлон гүтгэх, хүүхдийг садар самуунд уруу татах үйлдлүүд тодорхой хэмжээнд хязгаарлагдана гэж таамаглаж байна.
- Үүрэн холбоо болон интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд хамтран шүүлтүүрийн программ ашиглан сөрөг агуулгатай аливаа контентыг хүүхдүүдэд хүрэхээс өмнө арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл тухайн мэдээлэл рүү нэвтэрч орох үйлдэл хийхэд дэлгэцэн дээр нь хориглосон утга бүхий сануулга гарч ирнэ.

- Бусадтай чатлах, эцэг эхийн хараа хяналтгүй сошиал медиа ашиглах зорилгоор фейсбүүкийн олон хаяг ашиглаж байна. Тиймээс фейсбүүкийн хаяг нээхэд иргэний үнэмлэхийн зураг оруулдаг байх зэргээр шаардлагыг нэмэгдүүлэх боломжийг судлах.
- Хүүхдийг садар самуунд уруу татах чиглэлийн мэдээ мэдээлэл явуулдаг веб сайтууд, фейсбүүкийн пост зэрийг зогсоох зорилгоор Black list буюу хар жагсаалт гэсэн веб сайт нээж ажиллуулах. Эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгчид хар жагсаалтад багтах веб сайтуудыг репорт хийх боломжийг бүрдүүлэх.
- Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль болон нийтийн номын сан зэрэгт шүүлтүүрийн программыг суурилуулах.
- CU, Circle K зэрэг конвиниенс дэлгүүр, кофе шоп болон үнэгүй Wi-Fi-тай газруудад хүүхдүүд олноороо цуглардаг. Тиймээс тэдний тогтмол ордог газруудад шүүлтүүрийн программыг суурилуулах. Шаардлагатай тохиолдолд Wifi -ийн сүлжээ унагагч байршуулах.
- Насанд хүрэгчдэд зориулсан аним, манга үзэх хандлага байна. Тиймээс энэ төрлийн сайтуудад хяналт тавих.
- Эцэг эхчүүдийн мэдээлэл технологийн хэрэглээний мэдлэг, соёл төлөвлөөгүй, мөн англи хэлний мэдлэгээс шалтгаалан хамгаалах программ хангамжийг ашиглаж чадахгүй байна. Тиймээс эх хэл дээрх хамгаалалтын программ хангамжийг боловсруулах, түүнийг хэрхэн суурилуулах, хэрхэн хэрэглэх талаар сургалт, зөвлөгөөг цогц байдлаар зохион байгуулах.

3. ЦАХИМ ОРЧНЫ ЗӨВ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЛЭГ ОЛГОХ

Энэ хүрээнд хэд хэдэн оролцогч талуудыг хамруулсан сургалтыг зохион байгуулах, гарын авлага гаргах, мэдлэг олгох ажлуудыг шат дараатай хийх шаардлагатай байна. Үүнд:

Эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх. Эцэг, эхчүүд өөрсдийн интернэтийн хэрэглээндээ цензур тавьж, хүүхдэдээ үлгэр дуурайл үзүүлэх соёлыг эзэмшиж, хүүхэдтэйгээ өнгөрүүлэх цагаа уртасгах нь цахим донтолтоос сэргийлж, хүүхдээ эрсдэлд өртөхөөс хамгаалах эхний алхам байхаар байна. Дараах чиглэлээр мэдлэгийг олгох нь зүйтэй.

- Сүүлийн жилүүдэд монголчуудын гадаадад ажиллаж, амьдрах хандлага нэмэгдэхийн хэрээр өвөө, эмээгийн хяналтад байдаг хүүхэд олширсон. Энэ нь хараа хяналтгүй цахим хэрэглээ, түүнээс үүдсэн донтолтыг нэмэгдүүлж байна. Тэгэхээр ах, эгч, эмээ, өвөө нарын оролцоог нэмэгдүүлж, мэдлэг олгох.
- Эцэг эхийн эзгүйд хяналтгүй интернэт ашиглах хандлага өндөр байна. Нөгөө талаас эцэг, эхчүүд хяналтын арга техникийг ашигладаггүй болох нь судалгаагаар гарсан. Тиймээс эцэг, эхчүүдэд болон олон нийтэд чиглэсэн удирдамж, зөвлөмжийг бэлтгэн хүргэх.
- Эцэг, эхчүүдийн үүрэг оролцоо маш чухал гэж үзэж байгаа боловч бодит байдал дээр эцэг, эхчүүд энэ үүргээ гүйцэт биелүүлэхгүй байгаа нь ажиглагдсан. Тиймээс эцэг эхчүүд өөрсдөө хүүхдэдээ үлгэрлэл үзүүлж орон цагаар хүүхэдтэйгээ хамт байхдаа сошиал медиа ашиглахгүй байх, тэдэнтэй найз нь мэт ярилцах, өөрсдийнхөө хэрэгцээнд тохирсон гэрийн дүрэм зохиож, дагаж мөрдөх дадлыг бий болгох. Жишээ нь, өдөрт

гурваас илүү цаг интернэт ашиглахгүй. Ашиглахдаа алаан хядаантай тоглоом тоглохгүй, насныхаа хязгаараас давсан зүйлийг үзэхгүй зэргийг ойлгуулах.

- 13 нас хүрээгүй хүүхдэдээ фейсбүүк хаяг нээж өгөхгүй байхад анхаарах.
- Эцэг эхчүүд завгүй, харин хүүхэд завтай байгаа байна. Улмаар цахим орчинд хэн нэгний тансаг хэрэглээ, чамин ганган эдлэлийг харж, бусдын найз нөхөдтэйгөө наргин баясаж буй дүр зургийг харан өөртэйгөө жиших хандлагатай байна. Бусдаас шалтгаалж амьдрах, хэрэв тэдэн шиг байж чадахгүй бол өөртөө гутрах, амьдралын буруу хэв маягт автах нь цахим орчинтой холбоотой. Иймд хүүхдээ завгүй байлгахад анхаарч, хичээлээс гадуур чөлөөт цагийг үр бүтээлтэй, сонирхолтой өнгөрүүлэхэд анхаарч, төрөл бүрийн сургалт, спортын клубүүдэд хүүхдээ тогтмол хамруулах.
- Бага насны хүүхдээ саатуулах зорилгоор гар утсаа өгөхгүй байх. Хэрэв өгөх шаардлагатай бол хамгаалалтын программыг суулгах.

Багш, сурган хүмүүжүүлэгчийн оролцоог нэмэгдүүлэх. Цахим орчноос өсвөр насныхныг хамгаалах үр дүнтэй аргуудын нэг нь сургуулийн орчинд хамгаалалтыг хийх явдал юм. Энэ хүрээнд дараах ажлуудыг хийж болно. Үүнд:

- ЕБС-ийн сургуулийн иргэний боловсрол, эрүүл мэнд гэх мэт хичээлүүдэд цахим эрсдэлээс хамгаалах чиглэлийн агуулга оруулж өгөх.
- Багшийн хувьд цахим орчны талаар сурагчдаасаа давах мэдлэгтэй байх нь эргэлзээтэй. Тиймээс багш, сурган хүмүүжүүлэгч нарын цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаарх мэддэг, энэ чиглэлийн мэдлэгийг хүүхдүүдэд заах чадвар, олгох анхаарах.
- ЕБС бүрд цахим орчинд хүүхэд эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, энэ чиглэлийн мэдлэг мэдээллээр хангаж, цахим орчны аюулгүй хэрэглээний талаар сурталчилдаг “Хүүхэд хамгааллын баг”-тай болгох.
- Эцэг эхчүүдэд хандан цахим орчинд хүүхдээ эрсдэлээс хэрхэн хамгаалах талаар зөвлөгөө өгч, танин мэдэхүйн чиглэлийн арга хэмжээ зохион байгуулах.
- Сургуулийн орчинд ухаалаг гар утсыг нь хурааж авах буюу түүнтэй адилтгах эд зүйлсийг хэрэглэхгүй байхад анхаарах. Шаардлагатай нөхцөлд товчлууртай утас хэрэглүүлэх.
- Анги удирдсан багш нь 13 нас хүрээгүй сурагчдааа фейсбүүк хаяг нээж өгөхгүй байх. Дийлэнх багш нар ангийн группт нэгдээд мэдээллээс хоцрохгүй яваарай гэж хэлэх хандлага нэмэгдсэн ба хүүхдийг зөвхөн ангийн группт бүртгүүлэхийн тулд цахим хаяг нээж өгөх тохиолдол байдаг. Уг хандлагыг өөрчлөх.

Бусад талуудын оролцоог нэмэгдүүлэх.

- Цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудтай хамтран мэдлэг олгох сургалт зохион байгуулах.
- Цахим орчныг зөв болгоё, Unfriend зэрэг кампанит ажлуудыг дахин идэвхжүүлэх.
- Урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээлэл өгөхөд тусламжийн үнэ төлбөргүй утас чухал үүрэгтэй. Тиймээс хүүхдийн эрх зөрчигдсөн талаарх мэдээллийг хүлээн авах, хүүхдэд буруу үлгэр дуурайлал өгч байгаа мэдээллийн сайт, цахим хуудас, фейсбүүк группийн талаар гомдол гаргах, шууд мэдэгдэх боломжийг бүрдүүлэх.
- Сэтгүүлчдийн ёс зүйн хэм хэмжээг нэмэгдүүлэх, энэ талаарх сургалтыг зохион байгуулах. Хүүхдийн эрхийн зөрчлийг дуулиан шуугиан болгох, хүүхдийг ичээх, дарамтлах асуудал байдаг. Энэ нь хүүхдүүдийг цахим дарамтын асуудлаа нуух, дотроо хадгалах хандлага руу түлхэж байна. Тиймээс хүүхдийг ашиглах, мэдээлэл өгснөөр



